



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ХУУЛЬ ЁС ДЭЭДЛЭХ

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл

2014 он, Цуврал 1 (47)

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төсөл: зарим шинэлэг зохицуулалт	7
Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч П.Золзаяа	
Иргэний хэргийн зохигч, түүний үндсэн шинжүүд	11
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант Д.Хуяг	
Эрх зүйн шинэтгэлд Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх чиг үүрэг	19
Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны магистр Р.Очирбал	
ЭРХ ЗҮЙ, СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ	
Үндсэн хуулийн эдийн засаг, түүний ач холбогдол	25
Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Ц.Баасанжав	
Захиргааны процессын хуулийг хэрэглэхэд гарч байгаа хүндрэлүүд, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд	33
Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүхийн шүүгч У.Бадамсүрэн	
Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд тавигдах шаардлага, шалгуур-орчин үеийн чиг хандлага сэдвийн хүрээнд	39
Хууль зүйн ухааны магистр О.Алтантуяа	
Шүүн таслах ажиллагааны мэтгэлцэх зарчмын талаарх зарим асуудал	45
Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Л.Даваасүрэн	
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ, АСУУДАЛ	
Усны хууль тогтоомж зөрчих гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг боловсронгуй болгох нь	48
Дүүргийн Эрүүгийн хэргийн 1-р шүүхийн шүүгч С.Соёмбо-Эрдэнэ	
Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, түүнийг тойрсон асуудал	54
Иргэний хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүхийн шүүгч Ц.Отгонцэцэг	

СУДАЛГААНЫ ТОЙМ

2013 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээнд хийсэн дүн шинжилгээ

ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн социологич, судлаач
Б.Доржпагма

61

ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

Монгол улсын өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт: харьцуулсан судалгаа

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Б.Мэргэн

75

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ БҮТЭЭЛИЙН БУЛАН

Mongolia's Arbitration Law: Some Challenging Issues of Legal Regulation of Arbitration

ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор И.Идэш

89

CONTENT

BEFORE CREATING A LAW (UNDERLINING ARTICLE, INTERVIEW)

- The Draft Law on Land Privatization for Citizens of Mongolia: Some Innovative Regulations** 7
(*P.Zolzaya, Judge of Appellate Court for Civil Cases*)

- Participants of Civil Proceedings and Their Main Features** 11
(*D.Khuyag, Senior Lecturer, Doctoral Candidate of School of Law of National University of Mongolia*)

- The Role of the Constitutional Court in me Mongolian Legal Reform** 19
(*R.Ochirbal, Lecturer of Law School of Otgontenger University, LLM*)

LEGAL THOUGHTS: REFLECTION

- Constitutional Economy and Its Importance** 25
(*Ts.Baasanjav, Advocate, Member of Association of Mongolian Advocates*)

- Main Obstacles and Related Solutions for the Implementation of the Administrative Procedural Law** 33
(*U.Badamsuren, Judge of First Instance 16th Court for Administrative Cases*)


- Requirements and Qualifications of the Constitutional Court Judges- Current Tendency** 39
(*O.Altantuya, LLM*)

- Some Issues of the Principle of Adversarial Court Proceedings** 45
(*L.Davaasuren, Judge of 10th Appellate Court for Criminal Cases*)

IMPLEMENTATION OF LAW, EFFICIENCY, PROBLEMS

- Improving the Criminal Liability for Water Law Violations** 48
(*S.Soyombo-Erdene, Judge of District Court of First Instance for Criminal Cases*)

- Issues relating to Decisions Establishing Administrative Rules** 54
(*Ts. Ogontsetseg, Judge of Third Appellate Court for Civil Cases*)



RESEARCH OVERVIEW:

- Analysis of 2013 Statistical Information of Crimes and Administrative Offences** 61
(B.Dorjagma, Sociology-researcher of National Legal Institute)

INTERNATIONAL PRACTICE

- Mongolia's Competition Law: A Comparative Study** 75
(B.Mergen, Master's Student of School of Law of National University of Mongolia)

ARTICLES AND ESSAYS IN FOREIGN LANGUAGE

- Mongolia's Arbitration Law: Some Challenging Issues of Legal Regulation of Arbitration** 89
(I.Idesh, Doctor, Head of Legal Research Center of National Legal Institute)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨР

Ж.Амарсанаа	Үндсэн хуулийн цэцийн дарга
Б.Амарсанаа	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэд захирал
А.Бакей	УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
Б.Баярсайхан	Хууль зүйн доктор
Д.Баярсайхан	Хууль зүйн доктор
Ж.Баярцэцэг	ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
Б.Билэгт	ЦЕГ-ын дарга
Ж.Бямбадорж	Хүний эрхийн үндэсний комиссын дарга
Д.Ганбат	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга
Б.Гүнбилэг	Хууль зүйн доктор
Д.Дорлигжав	Улсын Ерөнхий Прокурор
Н.Жанцан	Хууль зүйн доктор
Ц.Зориг	Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
В.Оюумаа	Хууль зүйн доктор
Ч.Өнөрбаяр	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх
Д.Солонго	МУИС-ийн ХЭС-ийн захирал
Ш.Түвшэндорж	УИХ-ын Хууль зүйн бодлогын байнгын хорооны дарга
Х.Тэмүүжин	Хууль зүйн сайд
Б.Тэмүүлэн	Хууль зүйн доктор
П.Цагаан	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
Ч.Энхбаатар	Хууль зүйн шинжлэх ухааны доктор
А.Эрдэнэцогт	Хууль зүйн доктор Ерөнхий эрхлэгч Х.Номингэрэл
	Эрхлэгч И.Идэш
	Хариуцлагатай нарийн бичгийн дарга
	Д.Нямбаяр
	Хэвлэлийн эхийг
	Б.Цэрэнлхам

Улсын бүртгэлийн дугаар:279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний
хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 6 дугаар
гарна.

Хаяг: Улаанбаатар - 46,
Чингэлтэй дүүрэг, Чингис хааны талбай-7
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.legalinstitute.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	<i>Chairman, Constitutional Court of Mongolia</i>
B.Amarsanaa	<i>Vice Director of the National Legal Institute</i>
A.Bakei	<i>Chairman, Standing Committee on State Structure of State Great Hural of Mongolia</i>
B.Bayarsaikhan	<i>Ph.D</i>
D.Bayarsaikhan	<i>Ph.D</i>
J.Bayartsetseg	<i>State Secretary, Ministry of Justice of Mongolia</i>
B.Bilegt	<i>Chief, General Police Department of Mongolia</i>
J.Byambadorj	<i>Chief Commissioner, National Human Rights Commission of Mongolia</i>
D.Ganbat	<i>Chairman, the Sub Committee on Human Rights of State Great Hural of Mongolia</i>
B.Gunbileg	<i>Ph.D</i>
D.Dorligjav	<i>General Prosecutor of Mongolia</i>
N.Jantsan	<i>Ph.D</i>
Ts.Zorig	<i>Chief Justice, Supreme Court of Mongolia</i>
V.Oyumaa	<i>Ph.D</i>
Ch.Unurbayar	<i>Legal Advisor to the President of Mongolia</i>
D.Solongo	<i>Dean, School of Law, National University of Mongolia</i>
Sh.Tuvdendorj	<i>Chairman, Standing Committee on Legal Policy of State Great Hural of Mongolia</i>
Kh.Temuujin	<i>Minister of Justice</i>
B.Temuulen	<i>Ph.D</i>
P.Tsagaan	<i>Head, the Office of the President</i>
Ch.Enkhbaatar	<i>Sc.D</i>
A.Erdenebsogt	<i>Ph.D</i>

Editor-in-Chief

Kh.Nomingerel

Executive Editor-in-Chief

I.Idesh

Acting Assistant Editor

Nayambayar

Designed by

B.Tserenlkham

<p>State Registration Number:279 ISSN: 2226-9185 Published by the National Legal Institute. Six issues in a Year.</p>	<p>Address: Ulaanbaatar-46, Chingeltei District, Chinggis khaan Square -7 Phone:+(976)-11-315735 Fax: 315735 Website: www.legalinstitute.mn E-mail: Lawjournal@legalinstitute.mn</p>
---	---

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ: ЗАРИМ ШИНЭЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ



Иргэний хэргийн давж заалдах
шатны шүүгч П.Золзаяа

Монгол Улсын Засгийн газраас шинэчлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн газрын багц хуулийн төслөөс Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судлан шинжилж, түүнд суурилан төслийн зохицуулалтын хийдэл, давхардал, зөрчлийг арилгаж, боловсронгуй болгох, төслийн заалтуудын уялдаа холбоог хангах талаарх саналаа хуулийн төслийн 1-р бүлгийн хүрээнд та бүхэнд хүргэх гэсэн юм.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай 2002 оны хуулийг хэрэгжүүлэх хугацааг 5 жил тутам сунгаж байсан боловч ихэнх иргэн газар өмчлөх эрхээ эдэлж чадаагүй байна. Энэ эрхийг баталгаажуулан хэрэгжүүлэх зорилгоор хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулжээ.

Негеө талаас, урьд нь газар өзэмшиж байсан иргэн л газраа өмчилж авснаас бусад тохиолдолд иргэд, тухайлбал, орон сууцны байранд амьдарч байгаа иргэн газар өмчилж авах эрхээ хэрэгжүүлэх боломж нь хомс байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 9 бүлэг 55 зүйлтэй боловсруулагджээ. Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөх байгаа хууль нь 7 бүлэг 41 зүйлтэй.

Төслөөр Монгол Улсын иргэнд газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлөх эрхээр баталгаажуулсан үнэт цаас буюу газар өмчлүүлэх сертификатыг олгох, түүнтэй холбогдсон нэгдсэн бүртгэл хөтлөх, сертификатыг үндэслэн иргэнд газар өмчлүүлэх, сертификатыг биржээр арилжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зарчмын гол өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байна.

Төслөөр уг хуулийн ерөнхий бүтцийг хэвээр хадгалж үлдсэн байгаа бөгөөд дээр асуудалтай холбоотойгоор 122 заалтыг шинээр нэмж, 51 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаас 46 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, 3 заалтыг хасаж, 3 заалтыг өөрчлөн найруулжээ.

Төслийн "Нийтлэг үндэслэл" гэсэн Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хуульд хэрэглэсэн зарим нэр томъёоны тодорхойлолт, Монгол Улсын иргэнд газрыг өмчлүүлэхэд баримтлах үндсэн зарчим, нэг иргэнд ногдох газрын хэмжээ зэрэг асуудлыг тусгасан байна.

Төслийн "Иргэдэд газар өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцааг зохицуулах талаарх төрийн байгууллага, нутгийн удирдлагын бүрэн эрх" гэсэн Хоёрдугаар бүлэгт иргэдэд газар өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцааг зохицуулах талаарх Улсын Их Хурал, Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, нутгийн удирдлагын бүрэн эрхийг нэг бүрчлэн байгууллага тус бүрээр тодорхойлсон зохицуулалтыг оруулжээ.

Төслийн "Газар өмчлүүлэх сертификат, түүнийг олгох журам", "Газрын сертификатын биржийн арилжаа" гэсэн Гурав, дөрөвдүгээр бүлэгт иргэн бурийн газар өмчлөх эрхийг нь баталгаажуулах зорилгоор газар өмчлүүлэх сертификат олгох, түүнтэй холбогдох харилцааг зохицуулахтай холбогдсон асуудлыг тусгагджээ. Түүнчлэнтөслийн онцлог зохицуулалт болох газар өмчлүүлэх сертификат нь хөрөнгийн зах зээлд хөрвөх чадвартай үнэт цаас бөгөөд уг үнэт цаас нь биржийн харилцааны зүйл байхаар тусгасан байна.

Төслийн "Иргэнд газар өмчлүүлэх" гэсэн Тавдугаар бүлэгт иргэнд газар өмчлүүлэх ажиллагааг зохицуулсан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр иргэнд өмчлүүлэх газрын мэдээллийг үндэслэн тухайн өмчлүүлэх газрыг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга иргэдээс газар өмчилж авах өргөдөл хүлээн авч газрыг газар өмчлүүлэх сертификатаар солих замаар газар өмчлүүлэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Харин иргэдэд аж ахуйн эрхлэх зориулалтаар газар өмчлүүлэх ажиллагааг нээлттэй дуудлага худалдааны хэлбэрээр хэрэгжүүлэхээр төсөлд тусгасан байна.

Төслийн "Газар өмчлөхтэй холбогдох онцгой зохицуулалт" гэсэн Зургадугаар бүлэгт иргэний газар өмчлөхтэй холбогдсон тусгай зохицуулалт буюу газар өмчлөгчийн эрх, үүрэг, өмчлөлийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зэрэг асуудал хамаарчээ.

Төслийн "Газар өмчлөх эрх дуусгавар болох, газар өмчлөгчийн эрхийг хязгаарлах" гэсэн Долдугаар бүлэгт иргэний газар өмчлөх эрх дуусгавар болох нэхцэл, шалтгаан, газар өмчлөх эрхийг хязгаарлах нэхцэл, шалтгааныг Иргэний хуулийн зохицуулалттай нийцүүлэн тусгаж, түүнчлэн газрыг хураах, газар өмчлүүлэх сертификатыг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлийг нарийвчлан тусгасан байна.

Төслийн Найм, есдүгээр бүлэгт иргэний газар өмчлүүлэх эрхтэй холбогдсон баталгаа, газар өмчлөх, газрын сертификаттай холбогдсон гомдол гаргах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг бусад асуудлыг тусгажээ.

Төслөөр Монгол Улсын иргэнд газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлөх эрхээр баталгаажуулсан үнэт цаас буюу газар өмчлүүлэх сертификатыг олгох, түүнтэй холбогдсон нэгдсэн бүртгэл хөтлөх, сертификатыг үндэслэн иргэнд газар өмчлүүлэх, сертификатыг биржээр арилжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зарчмын гол өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байна.

Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт оруулсан заалтуудад үг, нэр томьео, найруулгын хувьд хасах, нэмэх, өөрчлөх зэргээр хийсэн нь харагдаж байна.

Харин шинээр нэмсэн заалтууд нь Монгол Улсын иргэн бүрт газар өмчлөх эрхийг гэрчлэх

сертификат олгох, уг сертификатад үндэслэн иргэнд газар өмчлүүлэх, сертификатыг арилжихтай холбогдсон зохицуулалт байгаа боловч өөр хоорондоо болон хуулийн үндсэн заалтуудтай давхардал, зөрчил ихтэй байдал байна.

Хуулийн төслийн 1 дүгээр бүлэг нь 7 зүйлтэй. 1-р зүйлд хуулийн зорилтыг "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлон газар өмчлүүлэхтэй холбогдсон зарим нэр томъёог тухайлбал, газар, иргэнд газар өмчлүүлэх, иргэнд газар өмчлүүлэх ажиллагаа, газрын сертификат, газрын корпораци зэргийг тайлбарлажээ.

"Иргэнд газар өмчлүүлэх ажиллагаа гэж иргэнд газар өмчлүүлэхтэй холбогдох бүх үе шатны ажиллагааг" хэлнэ гэсэн боловч уг ажиллагаанд иргэнд газар өмчлөх сертификат олгох болон сертификатын биржийн арилжааг зохицуулсан 17-23 дугаар зүйлүүд хамрагдахгүй байна. Нөгөө талаас энэ тодорхойлолт нь Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 13.2.1: нэр томъёо нь олон утгатай бол; 13.2.2: нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол; 13.2.3: шинээр бий болсон ойлголт буюу нэр томъёо нь нийтэд ойлгомжгүй бол нэр томъёоны тайлбар хийнэ гэж заасны алинд ч хамаarahгүй байна.

Төслийн 3.1.2-т "иргэнд газар өмчлүүлэх" гэж Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэнд өмчлүүлж болохоор заасан бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газраас энэ хуульд заасан хэмжээ, болзол, шаардлага, журам,

нөхцөлөөр иргэний өмчлөлд шилжүүлэхийг хэлнэ гэсний нийтийн эдэлбэрийн газарт ямар газар орохыг тайлбарлаж оруулах нь зөв байна. Хуульд нийтийн эдэлбэр газар гэсэн нэр томъёог нэг мөр тодорхойлж өгснэөр энэ ойлголтыг хууль хэрэглэгч бүр өөр өөрөөр тайлбарлах боломжгүй болно.

Мөн "нийтийн эдэлбэр газрыг Газрын тухай хуулийн төсөлд "нийтийн эдэлбэрийн газар" гэж зохих журмын дагуу нийтээр ашиглахаар тогтоогдсон төрийн өмчийн газрыг /3.1.3/, нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, явган зам, ногоон байгууламж, энэ хуульд заасны дагуу өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглаулснаас бусад амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай, оршуулгын газар хамаарна /8.2/ гэж өөр өөрөөр томъёолсноо ос гадна Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 6.1-д нийтийн эдэлбэрийн газарт гудамж, талбай, зам, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг хамаарахаар давхардуулан заасан байгааг нэг ойлголтой болгож тодорхойлох нь зөв гэж үзнэ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Монгол улсын иргэнд газрыг дараах зориулалтаар өмчлүүлнэ: 4.1.1. гэр булийн хэрэгцээний 4.1.2. аж ахуй эрхлэх зориулалтаар гэж заасан байна. 4.1.2-т заасан аж ахуй эрхлэх зориулалтаар газар өмчлүүлэх нь өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд эргэлзээ төрүүлэхээр байгаа тул Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах,

өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 13.2.2-т “нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол нэр томъёоны хэсэгт тайлбарлаж оруулах” гэж заасны дагуу мөн нарийвчлан тайлбарлах шаардлагатай юм. Энэ ойлголтыг эдийн засгийн утгаар нь болон хууль зүйн үүднээс зөв тайлбарлах шаардлагатай гэж үзнэ

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3.2-т иргэний хувийн хөрөнгөөр шинээр барьж байгуулах, хуульд заасан журмаар хувьчилж авах, түүнчлэн Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журмын дагуу өөрийн өмчлөлд шилжүүлж авах барилга байгууламжид зориулан өмчлөх газар нь энэ хуулийн 5.1.7-д заасан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа тохиолдолд дуудлага худалдаа явуулах замаар өмчлүүлэх гэж заасан байна. Энэ заалтын агуулга санаа ойлгомжгүй байна. Хэрэв иргэн шинээр барилга байгууламж барих бол энэ зориулалтаар газар эзэмших эрхээ урьдчилан авсан байж хууль ёсны болно. Энэ тохиолдолд 5.3.1 шууд хамаарна. Харин ирээдүйд хувьчилж авах барилга байгууламж байгаа бол барилга байгууламжид зориулан газрыг өмчлөхөөр бол дуудлага худалдаа явуулах замаар өмчлүүлнэ гэсэн нь зөрчилтэй болсон. Иргэний хуулийн 197.6, 197.9-д зааснаар дуудлага худалдаанд нэг этгээд оролцоггүй. Дуудлага худалдаа явуулах замаар өмчлүүлнэ гэж заасан нь барилга байгууламжийн эзэн газраа дуудлага худалдаагаар авч болно, харин авч чадахгүй ч байх тохиолдолд газар өмчлөгч нь өөр этгээд болох боломжтой болж, үл хөдлөх хөрөнгө газраас салдаггүй байх Иргэний хуулийн 84.3, 85.2-д

заасан журмыг зөрчсөн агуулгатай зохицуулалт болжээ.

Төслийн 7 дугаар зүйлд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээг зааж өгсөн бөгөөд 7.2.1-д “ 5.3.1-д иргэний хувийн хөрөнгөөр барьж байгуулсан, барьж байгаа буюу хувьчилж авсан, түүнчлэн Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журмын дагуу өөрийн өмчлөлд шилжүүлж авсан барилга байгууламжид зориулан газрын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр зохих гэрээ байгуулж эзэмшүүлсэн газар нь энэ хуулийн 5.1.7-д заасан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарах тохиолдолд уг газрыг тухайн иргэнд шууд өмчлүүлэх газар нь түүний байршил зориулалтаас хамааран тухайн барилга байгууламжид зориулан эзэмшүүлсэн газартай тэнцэх хүртэл хэмжээтэй байна гэж заажээ. Иргэний хуулийн 85 дугаар зүйлийн 85.2-т Түр зуурын хэрэгцээ хангах зорилгоор бус байнын зориулалттай, газартай салшгүй бэхлэгдсэн байшин, барилга, байгууламж болон бусад зүйл нь газрын үндсэн бурдэл хэсэг байна гэж заасан. Одоогийн шүүхийн практикт түгээмэл гардаг маргааны төрөл нь барилгын ойр орчмын талбай болон барилгыг эзэмшиж ашиглахад зайлшгүй шаардлагатай эзэмшил газрын маргаан ялангуяа хөрш зэргэлдээ эзэмшигч нарын хооронд маргах явдал нэлээд болсон.

Тухайн барилга байгууламжид зориулан эзэмшүүлсэн газартай тэнцэх хүртэл хэмжээтэй газрыг өмчлүүлэх тохиолдолд энэ хуулиар эсвэл Газрын тухай хуультай уялдуулж ойр орчмын эзэмшил газрын хэмжээг тодорхой хэмжээгээр эсвэл ашиглах хүрээнд нь тодорхойлох нь зөв болов уу.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ЗОХИГЧ, ТҮҮНИЙ ҮНДСЭН ШИНЖҮҮД



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
ахлах багш, докторант Д.Хуяг

Нэг. Зохигчийн тухай ойлголт

Шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэхдээ иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, зөрчигдсөн эрхийг нь сэргээх тухай шийдвэр гаргадаг.

Шүүхээршийдвэрлэгдэж байгаа иргэний хэрэг иргэд хоорондоо ба иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн хоорондын эрх үүргийн талаар үүссэн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой байдаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч зохигч буюу “иргэн” гэдэгт ИХШХШЭЗ-н харилцаанд оролцогч Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно. Монгол улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг гадаадын иргэн гэнэ. Харин харьяалалгүй гэж аль ч улсын

харьяат бус хүнийг хэлнэ¹.

Нэхэмжлэгч “хуулийн этгээд” хувийн эрх зүйн хуулийн этгээд байх ба өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болсон үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагааг эрхэлдэг зохион байгууллагын нэгдлийг хэлнэ². Мөн байгууллага иргэний хэргийн зохигч байж болно. 1995-05-16-ны өдөр батлагдсан Байгууллагын нууцын тухай хуулийн 3.1-д “Байгууллага гэж тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлнэ” гэжээ.

ИХШХШ ажиллагаанд зарим тохиолдолд зохигчоор төр буюу Монгол улсын Засгийн газар болсон тохиолдол гарсан. Тухайлбал 2011 оны 10 сард “Монголын гол нууруудын нэгдсэнхөдөлгөөнтийн бус байгууллагын нэхэмжлэлтэй Засгийн газарт холбогдох тухайлбал “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн заалтыг хэрэгжүүлэх /учирсан хохирлыг Засгийн газраас зарлах, байгаль орчны хохирлыг хариуцагчаар төлүүлэх/ тухай хэргийг Дээд шүүх хяналтын шатаар хянаж уг хуулийн заалтыг

¹ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. 2010.

² Иргэний хууль. 2002.

биелүүлэхийг Засгийн газарт даалгасан байна³.

ИХШХШ тухай хуулийн 22-р зүйлийн 1-д “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, түүнчлэн энэ хуулийн 12.1.2 – 12.1.1.4-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийг хэргийн оролцогч гэнэ” гэжээ. Энэ тодорхойлтоос үзэхэд хэргийн оролцогч гэдэгт ямар субъектууд хамаарах вэ гэдэгт нэрлэн заасан болохоос биш мөн чанарын хувьд хэргийн оролцогч гэж ямар субъект байх вэ гэдэг нь тодорхойгүй байна.

Мөн хуулийн 26.1-д “Хэргийн зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд хамаарна” гэжээ. Үүнээс үзвэл зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч хоёр хамаарч, харин хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд гэдэгт маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд хамаарна гэж үзэж байна.

Учир нь маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд гэдэг нь иргэний хэрэг үүсгэсэн хэргээт нэхэмжлэгч, хариуцагчийн ашиг сонирхлоос тусдаа бие даасан шаардлагыг гаргаж, уг шаардлагын зүйл зохигчдын маргааны зүйлтэй ижил байж, уг хэрэгт өөрийн санаачилгаар оролцож, шаардлагаа нэхэмжлэгч, хариуцагч хоёуланд нь ба эсхүл тэдний аль нэгд нь холбогдуулан гаргадаг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээж өөрийн өшиг сонирхлоо хамгаалах

зорилгоор оролцдог этгээд юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1-д нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хэргийн оролцогч гэж заасан ба энэ хуульд зохигч гэсэн нэр томъёо байхгүй байна. Мөн зүйлийн 16.2-т нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд юм гэжээ.

ОХУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 38-р зүйлийн 1-д “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч хамаарна” мөн зүйлийн 2-т “Бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж эрх бүхий этгээд шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүх тухайн этгээдэд үүсгэсэн иргэний хэргийн талаар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчийн хувиар оролцохыг мэдэгдэнэ”⁴.

БНХАУ-ын Иргэний заргын хуулийн 5-р бүлэг “Зарга хийгсэд”, 49-р зүйл “ард иргэд, хуулийн эрхтэн буюу бусад зохион байгуулалт иргэний заргын тухайн хүн болж болно. Хуулийн эрхтэн нь түүний хуулиар тогтоосон төлөөлегчөөрөө заргалдуулна. Бусад зохион байгуулалт нь түүний гол хариуцлагтанаараа заргалдуулна”⁵. Зохигч⁶ нь хэргийн оролцогчдын

⁴Гражданский процессуальный кодекс РФ. От 14 ноября 2002. (2003-02-01 мөрдсөн)..

⁵1991-04-09 өдөр батлагдаж 2007-10-28 өдөр нэмэлт өөрчлөлт орсон. БНХАУ-ын иргэний хууль, түүнд холбогдох хуулиудын эмхтгэл. УБ.2010. Хөрүүлж эмхтгэсэн Т.Мөнжаргал. Б.Батбаяр. 211 дэх тал.

⁶Б.Чимэд нар. Шинжлэх ухааны академиас гаргасан улсын нэр томъёоны комиссын мэдээ

дотор үндсэн оролцогч юм.

Монгол улсын Дээд шүүхийн 2010-06-02 өдрийн 03 тоот “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчдын эрх зүйн байдлын тухай” зөвлөмжинд “хэргийн зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагчаас гадна(тэдгээртэйэрхзүйнхувьдижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд) хамаарах талаар ИХШХШТХ-ийн 26 дугаар зүйлд заажээ. Уг этгээд гэдэгт мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.4-т зааснаар онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан этгээд, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргасан этгээд, мөн бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргасан этгээд хамаарахаас гадна мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т зааснаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд эрх, үүргийн хувьд хамаарах боломжтой юм⁷гэжээ. Иймд Дээд шүүхийн 2010 оны 3 тоот зөвлөмжинд нэрлэн заасан бүх субъектууд “зохигч” гэдэг ойлголтонд хамаарах эсэхийг авч үзье. Үүнд:

1. Уг зөвлөмжинд нэхэмжлэгч, хариуцагчтай эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд гэдэгт ИХШХШ тухай хуулийн 22.1-д заасан бүх этгээдүүд хамаарахаар заасан нь хэргийн зохигч гэдэг ойлголтыг хэргийн оролцогч гэсэн ойлголттой адил гэж үзэж хэтэрхий өргөн хүрээнд авч үзсэн байна.

2. ИХШХШ тухай хуулийн 12-р зүйлийн 12.1.1- д эдийн ба эдийн бус баялагтай холбоотой

^{№107-108. УБ.1978. номын 238 дахь талд Оросын “Сторона гэдэг үгийг тал, этгээд, зохигч” гэжээ.}

^{7 Монгол улсын Дээд шүүхийн мэдээлэл. 2010.№3. 18 дахь тал}

эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл гэж заасан ба иргэний хэргийн оролцогч нь эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тохиолдолд шүүхэд уг эрхээ хамгаалулахаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд тухайн этгээдийг хэргийн зохигч гэж үзэх боломжтой гэж үзнэ.

3. ИХШХШ тухай хуулийн 12-р зүйлийн 12.1.2-т бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл гэж заасан ба ИХШХШ тухай хуулийн 31.1 хэсэгт прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд, энэ хуулийн 25-р зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцно, уг хуулийн 31.2-т бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдан ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25-р зүйлд заасны дагуу оролцож болно. Мөн хуулийн 31.3-т прокурор бусдын эрхийг хамгаалж байгаа этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос, эсхүл гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан явдал уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох үндэслэл болохгүй гэж заасан ба хуулийн дээрх заалтуудаас үзэхэд прокурор ба бусдын эрхийг хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийн эрх зүйн байдал нэхэмжлэгч, хариуцагчийнхаас өөр байна.

4. ИХШХШ тухай хуулийн 12-р зүйлийн 12.1.3-т онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс

гаргасан хүсэлт гэж заажээ. Онцгой ажиллагааны журмаар шүүхэд хэрэг шийдвэрлүүлэх гэж байгаа этгээд шүүхэд хүсэлт гаргах ба түүнийг хүсэлт гаргагч гэж нэрлэнэ. Хүсэлтийн агуулга нь эрх зүйн ач холбогдол бүхий үйлдэл буюу үйл явдлыг тогтоолгоход чиглэсэн байна. Онцгой ажиллагаа нь шүүхэд хүсэлт гаргах буюу нэг талын үйл ажиллагаагаар хэрэгждэг, эрхийн талаар маргаан байдаггүй, нэгтгэл нь нөгөө талдаа материаллаг эрх зүйн шаардлага гаргадаггүй (харилцаан эсрэгсонирхолтой талууд байдаггүй) учир уг ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч гэж үгүй. Үүгээрээ бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж маргадаг нэхэмжлэлээр үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай. Иргэн, хуулийн этгээд нэхэмжлэл гаргасан тохиолдолд материаллаг эрх зүйн харилцаа зөрчигдэж, мөнгө, эд хөрөнгө гаргуулах, өмчлөх зэрэгхэрээ хүлээн зөвшөөрүүлэх зэрэг шаардлагыг тавьж болно. Уг ажиллагаанд талуудын хооронд материаллаг эрх зүйн маргаан байхгүй шүүхэд нэхэмжлэл гаргадаггүй учир нэхэмжлэлтэй холбоотой хэм хэмжээнүүд хэрэглэгддэггүй.

Тухайлбал нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзах, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, өөрчлөх, зохигчидэвлээрэх, талуудыг солих, сөрөг нэхэмжлэл гаргах гэх мэт.

5. ИХШХШ тухай хуулийн 12-р зүйлийн 12.1.4-т Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол гэж заажээ. Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл

ажиллагаа болон эрх зүйн актын талаар гаргасан гомдол энэ хуулийн 12.1.4-т зааснаар иргэний хэрэг үүсгэх үндэслэл болно. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1-д заагдсан захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, эрх зүйн актаас өөр байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, эрх зүйн актад гомдол гарвал түүнийг хэргийн ерөнхий харьяаллын шүүхүүд хянан шийдвэрлэнэ.

**Хоёр. Хэргийн зохигч
гэсэн ойлголтын талаар
хуульч судлаачдын өгсөн
тодорхойлолтууд:**

ОХУ-ын доктор, профессор М.С.Шакарян иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч гэдэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа, субъектив эрх, хуулиар хамгаалсан хувийн ашиг сонирхлын талаар маргаанаа шүүхээр шийдвэрлүүлж байгаа хэргийн талуудыг хэлнэ⁸.

Хуульч Ц.Амарсайхан “зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч орно гэдэг нь тодорхой ойлгомжтой боловч, “тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд” тэж хэнийг хэлж байгааг дэлгэрүүлж авч үзэх нь зүйтэй⁹.

Хуульч Б.Буянхишиг ... иргэний хэрэгт маргалдагч талууд буюу нэхэмжлэгч, хариуцагч нь хувь этгээдийн журмаар процесст оролцоно... хэдийгээр бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нь ИХШХШ тухай хуулийн 29.2-т зааснаар тэдэнтэй ижил эрх, үүргийг хүлээж оролцох ч энэ

⁸ Гражданское процессуальное право России. Ред. М. С.Шакарян.М.1996.ст.60

⁹ Ц.Амарсайхан нар. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ.2008. 93 дахь тал.

ажиллагаанд зохигч болохгүй, тусдаа хэргийн оролцогч болдог¹⁰.

Хуульч З.Мөнхжаргал “ИХШХШ эрх зүйд нэхэмжлэгч, хариуцагч хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр ИХШХШ ажиллагаанд оролцож байгаа этгээдийг иргэний хэргийн зохигч” гэж нэрлэдэг¹¹.

Хуульч А.Дугармаа “хэргийн зохигчгэдэгњүүхэргийноролцогдоос нэхэмжлэгч, хариуцагч хоёрыг болон хуульд зааснаар тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх эдэлж, үүрэг хүлээж, хэрэгт оролцож байгаа этгээдийг хэлдэг. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч, хариуцагч болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь хэргийн зохигч болно” гэсэн ойлголт юм¹² гэжээ. Энд зохигчтой ижил эрх эдэлж, үүрэг хүлээж хэрэгт оролцож байгаа этгээд гэдэгт тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг хамруулах нь учир дутагдалтай гэж үзнэ. Нэхэмжлэгч, хариуцагчийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийг иргэний хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж байгаа этгээд гэж үзнэ. Учир нь төлөөлөгч нь хууль ёсны, сайн дурын, гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэх гэсэн хэлбэрүүдээр төлөөлдөг ба сайн дурын ба гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэх ажиллагаа нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэл, бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаага явуулдаг учир нэхэмжлэгч, хариуцагчийн

¹⁰Б.Буянхишиг. ХБНГУ-ын Ханис-Зайделин сан. “Эрх зүйн боловсрол” академи. Эрх зүйн мэдээлэл. 2011 он. 5-р сар. 2003. 32 дахь тал
¹¹З.Мөнхжаргал. Монгол улсын Иргэний хэрг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Ерөнхий ангид. УБ.2009. 134 дахь тал.

¹²Т.Мөнхжаргал, Д.Хуяг, А.Дугармаа нар.Иргэний хэрг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Ерөнхий ангид. УБ.2011. 66 дахь тал.

төлөөлөгчийг нэхэмжлэгч, хариуцагчтай ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд гэж үзэх боломжгүй. Иргэний хэрэгт өмгөөлөгч, нэхэмжлэгч, хариуцагчтай хууль зүйн туслалцаа үзүүлэх буюу хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр өмгөөллийн үйл ажиллагааг явуулдаг. Ингэхдээ өмгөөлөгч нь үйл ажиллагаага явуулахдаа Иргэний хууль, ИХШХШ тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль бусад хууль тогтоомжийг удирдлага болгон үйл ажиллагааг явуулдаг онцлогтой.

Гурав. Зохигчийн тухай Монгол улсад мөрдөгдөж байсан Иргэний байцаан шийтгэх болон ИХШХШ тухай хуулиудад заасан нь

1926-07-02 өдөр батлагдсан Монгол Ард Улсын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хуулийн 38,39-р зүйлд хариуцагчийг “нөгөө этгээд” гэж нэрлэсэн ба мөн хуулийн 44-р зүйлд “хэрэгт мэдүүлсэн ба нөгөө этгээд” гэж, 55-р зүйлд маргааны талуудыг “иргэний хэрэгт холбогдсон хоёр этгээд” гэж нэрлэжээ. 1952-05-27 өдөр батлагдсан Иргэний байцаан шийтгэх хуулийн 2-р зүйлд шүүхэд иргэний хэргийг зохигчдын нэхэмжлэлээр авч хянан шийдвэрлэнэ гэж заажээ. 1967-06-29 өдөр батлагдсан Иргэний байцаан шийтгэх хуулийн 34-р зүйлд хэргийн оролцогчдын бүрэлдэхүүнд “зохигчид” хамаарах тухай заагаад мөн хуулийн 38-р зүйлд зохигчид нэхэмжлэгч буюу хариуцагч нь иргэд, түүнчлэн хуулийн этгээдийн эрхтэй улс, хоршоолол, олон нийтийн байгууллага байж болно гэж заасан боловч уг хуульд зохигчид гэж чухам ямар этгээдийг хэлэх тухай тодорхойлолт байхгүй байсан. 1994-05-09 батлагдсан

ИХШХШ тухай хуулийн 20-р зүйлд хэргийн оролцогчдын бүрэлдэхүүнд ... "зохигчид" хамаарах тухай заажээ.

Дөрөв. Зохигчийн үндсэн шинжүүд

ИХШХШ тухай хуулийн 26-р зүйлд хэргийн зохигчийн бүрэлдэхүүнд ямар этгээд хамаарахыг нэрлэн заасан боловч зохигч гэсэн тодорхойлолтыг өгөөгүй байх ба ИХШХШЭ зүйн ном зохиол, судлаачдын бүтээл, хуулийн заалт, шүүхийн практикаас үзэхэд зохигч гэж дараах тодорхойлолтыг өгөх боломжтой гэж үзнэ.

Зохигч гэдэгт зөрчигдсөн буюу маргаантай байгаа эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхээр хамгаалулахаар шүүхэд нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргасан хэрэгт эрхийн талаар маргаантай байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд байх ба, материаллаг эрх ба хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж хоорондоо маргаантай байгаа эсрэг тэсрэг ашиг сонирхолтой, шүүх тухайн хэргийг хянан хэлэлцээд ямар агуулгатай шийдвэр гаргах талаар материаллаг эрх зүйн ба процессын эрх зүйн ашиг сонирхолтой, иргэний хэргийн бие даасан оролцогчийг хэлнэ.

Зохигч нь дараах үндсэн шинжийг агуулсан байна гэж үзэж болно. Үүнд:

1. Иргэний эрх зүйн чадвар, чадамжтай байх хууль зүйн шинжийг агуулна.

2. Нэхэмжлэг шүүхэд нэхэмжлэл гаргасныг шүүх хянан үзээд иргэний хэрэг үүсгэх захирамж гаргасны дараа хэргийн талууд албан ёсоор нэхэмжлэгч, хариуцагч гэж нэрлэгдэнэ.

3. Иргэний хэргийн зохигч нь хэргийн үндсэн буюу гол оролцогч байж хоорондоо харилцан хамааралтай байна.

4. Төрсдийн нэрийн өмнөөс эрх, ашиг сонирхлоо хамгаалулахаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог. Гэтэл прокурор ИХШХША-нд төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд төрийн нэрийн өмнөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

5. ИХШХШ тухай хуулийн 26.2 дахь заалтаас үзэхэд нэхэмжлэгч нь /зохигч/ хэргийн бусад оролцогчдоос илүү эрх эдлэх ба тухайлбал нэхэмжлэл гаргасан үндэслэл болон нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихсгэх, багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагчтай эвлэрэх, хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, нэхэмжлэгчтэй эвлэрэх, сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй байх ба ингэж материаллаг эрх зүйн шаардлага буюу маргааны объектыг цаашид хэрхэх, хувь заяаг нь шийдэх эрх зөвхөн түүнийг эзэмшигч этгээдүүдэд байна.

6. Эрхийн талаар ба хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлын талаарх маргаан нь шүүхээр хянан хэлэлцэгдэж шийдвэрлэх зүйл нь болдог.

7. Тэдний нэр дээр шүүхийн шийдвэр гардаг.

8. Тэдэнд шүүхийн шийдвэрийн хүчин чадал бүрэн хэмжээгээр хамаардаг.

9. Тэд шүүхийн зардал ба Улсын тэмдэгтийн хураамж төлнө.

10. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрх эдэлж оролцоно.

11. Зохигчийн аль нэг нь маргаантай байгаа эрх зүйн харилцаанаас гарсан /хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан зэрэг/ тохиолдолд түүнийг эрх залгамжлагчийн хүсэлтээр эрх залгамжлан авах этгээдээр сольж болно.

Тав. Нэхэмжлэгч, түүний үндсэн шинжүүд нь:

Нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлнэ. Түүний үндсэн шинжүүд нь:

1. Нэхэмжлэлд бичсэнээр эрх нь зөрчигдсөн, бусадтай эрхийн талаар маргаантай байгаа этгээд;

2. Эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж байгаа;

3. Эрхээ хамгаалулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж хандсан /хэргийн идэвхтэй тал/ этгээд;

4. Хариуцагч эрхийг нь зөрчсөн гэж үзэж байгаа учир эрхээ сэргээлгэж, хамгаалуулах гэж байгаа этгээд;

5. Өөрийн болон бусдын нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргасан этгээд. Бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах нь хуульд заасан дараах тохиолдолд байж болно. Энд иргэний эрх зүйн чадамжгүй 7 хүртэлх насын этгээд, сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээд, зарим чадамжтай, бүрэн бус чадамжтай, эрх зүйн чадамжийг хязгаарласан этгээдийг төлөөлж нэхэмжлэл гаргах ажиллагаа юм.

6. Субъектив эрх¹³ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо хамгаалулахаар шүүхэднэхэмжлэл гаргаж үүний дагуу шүүх иргэний хэрэг үүсгэдэг.

Хуульч Ц.Амарсайхан нэхэмжлэгч шүүхэд дараах байдлаар нэхэмжлэл гаргаж болно гэжээ. Үүнд:

- Нэхэмжлэгч нь өөрөө шүүхэд нэхэмжлэл гаргаж, өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;
- Бусдаар төлөөлүүлж шүүхэд нэхэмжлэл гаргуулж, түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах; Өөрөө нэхэмжлэл гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн төлөөлөгчийг оролцуулах зэргээр шүүхээр эрхээ хамгаалуулах боломжтой¹⁴.

Зургаа. Хариуцагч, түүний үндсэн шинжүүд

Хариуцагч гэж нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсан буюу үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй гэж нэхэмжлэлд дурдсан этгээдийг хэлнэ.

¹³ Субъектив эрх гэж иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн харилцаанд оролцогчдод хуульд зааснаар тухайн харилцаанд оролцож, бусад этгээдээс зохих зан үйлийг (үйлдэл, эс үйлдэхүй) шаардах, шаардлагатай тохиолдолд шүүхээр /өөрийн албадлалаар/ хамгаалулахаар хандах боломж мөн. Ц.Амарсайхан Д.Тунгалаг нар. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ.2008. 21 дэх тал.

Д.Баярсайхан. Эрх зүйн онол. Субъектив эрх – эрх зүйн харилцаанд оролцогч бүхий л субъектэд олгогдсон хууль зүйн боломж. Өмч хөрөнгө эзэмших, үйл ажиллагаа явуулах, аливаа серег үйлдлээс зайлсхийн зэрэг эрхийн бүх хэлбэрээр илрэнэ. УБ.2010.236 дахь тал

¹⁴ Ц.Амарсайхан Д.Тунгалаг нар. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ.2008. 94 дэх тал

Түүний үндсэн шинжүүд нь:

1. Нэхэмжлэлд дурдсанаар нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдан ашиг сонирхлыг зөрчсөн эсхүл нэхэмжлэгчтэй эрхийн талаар маргаан гаргаж байгаа этгээд;

2. Нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн /хохирол учруулсан буюу үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй/ энэ зөрчлийг арилгаагүй, үүрэг хүлээх ёстой этгээд;

3. Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн үндсэн дээр түүний эсрэг иргэний хэрэг үүсгэгдэж, уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхээс татан оролцуулж байгаа этгээд;

4. Шүүхэд түүний эсрэг гаргасан нэхэмжлэлтэй холбогдуулан шүүхэд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх талаар тайлбар өгөх, зарим тохиолдолд нэхэмжлэгчийн эсрэг сөрөг нэхэмжлэл гаргах зэргээр эрхээ хамгаалах боломжтой этгээд;

5. Нэхэмжлэгч шүүхэд хариуцагчийн эсрэг гаргасан нэхэмжлэлийн дагуу иргэний хэрэг үүсгэгдсэн хэрэгт ИХШХШЭ зүйн маргаантай материаллаг эрх зүйн

харилцааны субъект болж оролцдог учир зарим хуульч эрдэмтэд түүнийг "хэргийн идэвхгүй тал"¹⁵ гэж нэрлэдэг байна.

6. Θөрийнх нь эрхийг зөрчсөн гэж нэхэмжлэгчийн үзэж буй этгээд иргэний хэрэгт хариуцагчаар ордог. Харин тухайн этгээд хариуцлага хүлээх ёстай эсэхийг хэргийг хянан хэлэлцэний эцэст шүүх шийдвэрлэнэ.

Санал:

1. ИХШХШ тухай хуулийн 22-р зүйлд хэргийн оролцогчдын бүрэлдэхүүнд ямар этгээдүүд хамаарах, мөн хуулийн 26-р зүйлд хэргийн зохигч гэдэгт хэнхамаарахыг нэрлэн заасан боловч эрх зүйн байдлыг нь тодорхойлоогүй тул уг хуульд "хэргийн оролцогч", "зохигч" гэсэн тодорхойлолтыг тусгах;

2. Мөн хуулийн 25-р зүйлд хэргийн оролцогчийн эрх үүрэг, 25.1.2-т хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарсаны дараа хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх гэсэн заалт нь цаг хугацааны хувьд зохигчийн мэтгэлцэх эрхийг хязгаарласан заалт болсон тул өөрчлөх.

---00---

¹⁵Гражданский процесс. Под ред. В.В.Ярков. М.1999. ст 62.

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛД ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ*



*Отгонтэнгэр их сургуулийн багш,
хууль зүйн ухааны магистр
Рагчаагийн Очирбал*

Үндсэн хуулийн шүүх нь хүн төрөлхтний түүхэнд хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн бодитой үр дүн бөгөөд эрх зүйн шинэтгэлийн үйл ажиллагааг зөвөөр удирдахад нь зүглэн чиглүүлэгч, зөвлөн хэлэлцэхэд нь ухаалаг зөвлөгч, буруу үйлдэлд хараат бус хянагч нь байж Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангахад тэргүүлэх чиг үүрэг гүйцэтгэдэг шүүх эрх мэдлийн байгууллага юм.

Орчин цагийн нийгмийн тулгуур үнэт зүйлс болох хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх үзлийг хуульчлан бэхжүүлсэн Үндсэн хууль нь улс орны эрх зүйн тогтолцоог

бүхлээр шинэтгэх үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Үндсэн хуульт төрийн үзэлсанаа, үйлажиллагааны дэглэм ёсоор Үндсэн хуулийн хэм хэмжээ бүр заавал биелэгдэж, төрийн байгууллага, албан тушаалтын шийдвэр үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байж гэмээнэ эрх зүйн шинэтгэл Үндсэн хуулийн дагуу хийгдэх учиртай. Үндсэн хууль нь өөртөө өр бусын засаглах хүчийг агуулах хэдий ч амьд организмд байдаг өөрийгөө хамгаалах, нөхөн төлжүүлэх боломж байдаггүй тул энэхүү механизмыг бий болгох олон хувилбарт аргуудыг эрдэмтэн, судлаачид боловсруулсан нь дэлхийн улс орнуудад түгээмэл байдлаар хэрэгжиж байна. Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн хэрэгжилтийн баталгааг хангаж буй шинжээрээ эрх зүйн шинэтгэлд чиглүүлэгч, зөвлөгч, хянагчийн үүрэг гүйцэтгэдэг хэмээн тодорхойлсон болно.

Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэх, төгөлдөржүүлэх нь эрх зүйн шинэтгэлд Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх чухал үүрэг болно. Хүний засаглал дор бус хуулийн засаглал дор оршин амьдрах үзэл санаа нь амар хялбар байдлаар хэрэгжсэн улс үндэстэн үгүй биз ээ. Хуучны эзэрхэг, түрэмгий, хариуцлага хяналтыг үл мэдэх эрх дархтуудын дур зоргыг энгэгт үндсээр нь өөрчлөх зорилго

* Үндсэн Хуулийн Цэцийн даргын нэрэмжийг сэдэмж бичгийн уралдааны тэргүүн дэд байранд шалгарсан илтгэл

бүхий Үндсэн хуулт ёсны хувьсал өөрчлөлтийн үед хариуцлага, хяналтыг хараат бус, шударгаар хэрэгжүүлэх чадвартай, эрдэм, мэдлэг, ёс зүйгээр манлайлагч гишүүдтэй Үндсэн хуулийн шүүх хамгаас чухал.

Монгол улсын Үндсэн хуулийн цэц анхлан байгуулагдаж байх үед уг байгууллагын зорилго, чиг үүрэг, бүрэн эрхийг зөвөөр ухамсарлаж байсан нь тун цөөхөн байсан. Үндсэн хуулийн цэцийн хяналтыг үгүйсгэх, супруулах хандлага ч ажиглагдаж байлаа. Тухайлбал, Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн цэцийн дунд судлын хуралдаанаас гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлыг хуульд заасан журмын дагуу хэлэлцэн зохих хариу мэдэгдэг зохицуулалттай атал Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг зөв, буруу, үндэслэлтэй, үндэслэлгүйг тунгаан шийдвэрлэх эрхтэй мэтээр хандаж байсан нь нууц биш. 1994 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын 1, 2-т “Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийг.... тус тус зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хууль зүйн үндэслэлгүй гэж узсүгэй”, “Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хууль зүйн үндэслэлтэй гэж узсүгэй”, түүнчлэн Улсын Их Хурлын 1998 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 77 дугаар тогтоолын 1-д “Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын ... оны

тогтоол нь Үндсэн хуулийн ..., ... гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна” хэмээн хариу мэдэгдэж байжээ.

Улсын Их Хурлын дээрх хандлага нь Үндсэн хуулийг амьгуйдүүлж, асуудлыг Үндсэн хуулийн цэцийн хяналтаас гадуур дур зоргоороо шийдвэрлэх гэсэн оролдлого байсан хэмээн үзэх үндэслэлтэй. Харин Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн асуудалд бодитой, хуульд хүндэтгэлтэй хандсаны үр дунд төрийн эрх мэдлийн байгууллага үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцдаа Үндсэн хуулийг зөрчсөн тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн хяналт шударгаар хэрэгжиж, гаргасан шийдвэр нь эцсийн, дээд хүчин чадалтай байж, Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэх үүрэгтэй болохоо батлан харуулсан юм.

Монгол улсын Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэх замаар эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн анхаарах асуудал байна. Үндсэн хуулийн цэц нь хуульд нэрлэн заасан байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шалгах үүрэгтэй байхаар хуульчилсан ч зарим шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуулийн хяналтаас гадуур байна. Тухайлбал: Улс төрийн намуудын хооронд байгуулагдсан Үндсэн хуулийн эрх зүйн харилцааг зохицуулсан гэрээ, хэлэлцээр, Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэр болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хооронд хийгдсэн гэрээ, хэлэлцээр, Сонгуулийн өрөнхий хорооны үйл ажиллагаа, эс үйлдэл, Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол, улс төрийн намын бүртгэлийн талаар гаргасан

шийдвэр, Улсын Их Хурлаас Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт зэрэг нь Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд хэрэг маргааныг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна. Иймд Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэхийн тулд Үндсэн хуулийн цэцийн хяналтын хүрээг өргөтгөх шаардлагатай байна.

Үндэсний эрх зүйн тогтолцоонд шинэ үзэл, номпол, хандлагыг нэвтрүүлэх нь эрх зүйн шинэтгэлд Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх чиг үүрэг болно. Өрнийн судлаачид Амьд Үндсэн хуулийн /a living Constitution/ талаар нэлээдгүй ярих болжээ. Үндсэн хууль нь нийгмийн харилцаанд гарч буй хувьсал, өөрчлөлтэд дасан зохицох чадвартай байж, шинэ үзэл, хандлагыг өөртөө шингээн зохих нэмэлт, өөрчлөлт орж байх нь дээрх ойлголтын гол утга болно.¹ Гэхдээ нийгмийн өөрчлөлттэй уялдуулан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж оролдохын оронд Үндсэн хуулийн зохицуулалтыг нийгмийн хувьсал, өөрчлөлтөд нийцүүлэн тайлбарлан хэрэглэх замаар эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх боломж Үндсэн хуулийн шүүхэд байдаг. Дээрх эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нь асуудалд бодитой, хүний эрхийн мэдрэмжтэй, холч ухаантай, Үндсэн хуулийн зохицуулалтын утга бүрийг нийгмийн хувьсал, өөрчлөлтөд нийцүүлэн тайлбарлах чадвартай, гадаад улс болон олон улсын түвшинд гарч буй Үндсэн хуулийн эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлийг цаг алдалгүй судалдаг, идэвхтэй, бүтээлч, зөв цаг хугацаанд оновчтой шийдвэр гаргах чадвартай байх нь хамгаас чухал. Харин маргааныг

шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн заалтын хэлбэрт хэтанхааран, угэнд хөтлөгдвэл асуудлыг шийдвэрлэх боломж улам хязгаарлагдан хуулийн зүйл заалт дээр дасгал ажилладаг гэсэн өрнийн зарим судлаачдын өгсөн шүүмжлэл үнэнд ойрхон болох уу.

Олон улсын түвшинд хүний эрхийн олон салбар чиглэлд шинэтгэл, өөрчлөлт хийгдэж байна. Нийгмийн бүлгийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг хамгаалахад улс орон, олонулсын байгууллагууданхаардаг байсан бол эдүгээ нийгмийн цөөнх, цаашлаад буруутан гэгдэн нэрлэгдэж байсан хоригдлуудын улс төрийн эрх, биеэ үнэлэгчдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, лэсби, гей, бисексуаль, трансхендэр хүмүүсийн гэр бүл болох, хүүхэдтэй байх эрхийг хулээн зөвшөөрөх асуудалд нааштай өөрчлөлтүүд хийгдэж байна. Хүний эрхийн дээрх өөрчлөлтөд улс орнуудын хууль тогтоогчид, нийгмийн зүгээс ихээхэн шүүмжлэлтэй ханддаг ч Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрхийг удирдлага болгон эрх зүйн зохицуулалтад эрс шинэтгэл хийх байдал ихээр ажиглагдах боллоо. Жишээ нь: Нийгмийн гэрээг зөрчиж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс төрийн эрхийг давхар хязгаарлах нь эрүүгийн эрх зүйн Civic death зарчмаар хүлээн зөвшөөрөгдж, хоригдлуудын сонгуульд оролцон санал өгөх эрхийг хязгаарлах нь зүй ёсны мэтээр улс орнууд ойлгох байсан цаг саяхан. Харин сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Канад, Австралий², Өмнөд Африк, болон Европын

¹ David A. Strauss, The Living Constitution, 2010, www.law.uchicago.edu

²Lisa Hill, University of Adelaide, Prisoner voting right, Symposium: Protecting Human Rights in Australia: Challenge and Strategies, November 2009

Албани³, Хорват, Бүгд Найрамдах Кибр улс, Дани, Финланд, Исланд, Ирланд⁴, Испани, Швед зэрэг улс орнууд хоригдлуудын сонгуульд санал өгөх эрхийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна. Энэхүү зохицуулалтын өөрчлөлтөд улс орнуудын Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд шүүх тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна. Үндэсний эрх зүйн тогтолцоонд эрх зүйн шинэтгэл хийх Үндсэн хуулийн шүүхийн хүчин чармайлт нь хууль тогтоох байгууллагын оролцоо, дэмжлэггүйгээр хэрэгжих боломжгүй. Учир нь хууль батлах, эрх зүйн зохицуулалтын шинэтгэл хийх нь Хууль тогтоох байгууллагын онцгой бүрэн эрх бөгөөд түүний батлан гаргасан хуулийг хянах, үйлчлэлийг хязгаарлах эрхийг гагцхүү Үндсэн хуулийн шүүх / зарим улсад Улсын дээд шүүх/ хэрэгжүүлдэг. Үндсэн хуулийн хяналтын эцсийн үр дунд хууль тогтоох байгууллага өөрийн батлан гаргасан хуулийн зохицуулалтыг Үндсэн хуулийн агуулга, хүний эрхийн олон улсын хүрсэн түвшинд аль болох нийцүүлэн боловсруулдаг байх нь ихээхэн чухал.

Харин манай улсын хувьд Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгосон хуулийн заалтыг Үндсэн хуулийн утга санаанд нийцүүлэн боловсронгуй болгохын оронд тухайн заалтыг ердийн журмаар хүчингүй болгон зохицуулалтыг зөнгөнд нь хаях явдал түгээмэл байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Үндсэн хуулийн шүүх нь хууль,

³ Тус улс 2006 он хүртэл хоригдлуудын сонгуулийн эрхийг хуулиар шүүд хязгаарладаг зохицуулалтаа өөрчилсөн бөгөөд эдүгээ бүх хоригдлууд сонгууль өгөх эрхтэй.

⁴ 2006 оны хуулиар хоригдлууд нь өөрийн байнга оршин суудаг байсан газрынхаяа сонгуулийн хэсэгт шуудангаар сонгууль өгөх эрхтэй байхаар хуульчилсан.

тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг тогтоохыг зэрэгцээ, түүний зохицуулалт ямар байх ёстой талаар зөвлөмж, чиглэлийн удирдамж өгөх нь түүний чухал үүрэг болно.⁵

Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын хэрэгжилт, төрийн байгууллагын зохион байгуулалтын зохист харьцааг хянах замаарх зүйншиэнтгэлийг хэрэгжүүлэх нь Үндсэн хуулийн шүүхийн чухал үүрэг болно.⁶ Үндсэн хууплыт төрийн үзэл санааны суурь зарчим болох төрийн эрх мэдэл хуваарилах онол ёсоор хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага нь зохимжит байдлаар хуваарилсан тус тусын бүрэн эрхийг аливаа давхцал, дур зоргоос ангид байдлаар хэрэгжүүлэх журамтай. Төрийн байгууллагын бүтцийн зохион байгуулалтыг тогтоох нь хуулиар эрх олгогдсон төрийн байгууллагын шийдвэрлэх асуудал хэдий ч эцсийн шийдвэр нь төрийн эрх мэдэл хуваарилах онол, зарчимд нийцэн байх учиртай. Манай улсын хувьд төрийн байгууллагын бүтцийн зохион байгуулалттай холбоотой асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан иргэний өргөдөл, мэдээлэл маш цөөн байгаа нь энэ салбарт эрх зүйн шинэтгэл хийх Үндсэн хуулийн цэцийн боломжийг багасгаж байна. Тухайлбал:

- Үндсэн хуулийн цэцийн орлогч даргыг томилох талаарх өнөөгийн эрх зүйн зохицуулалт нь цэцийн гишүүд эрх тэгш байх зарчимд нийцэж байгаа эсэх;

- Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, Монгол банкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргыг

⁵ Peter Heberle, Role and Impact of Constitutional Court

⁶ Benny K. Harman, The Role of the Constitutional Court in Indonesian Legal Reform

томилох талаар Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд санал оруулж байгаа нь Улсын их хурлын дарга үйл ажиллагааны зохион байгуулалтаас бусад асуудлаар давуу эрх эдлэхгүй байх зарчимд нийцэж байгаа эсэх;

- Улсын дээд шүүх улс төрийн намын бүртгэлийн асуудлыг шийдвэрлэж байгаа нь шүүхийн чиг үүрэг, төрийн эрх мэдэл хуваарилах онол, зарчимд нийцэж байгаа эсэх зэрэг асуудлыг Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэх бүрэн боломжтой.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нь эрх зүйн шинэтгэлд Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх үндсэн чиг үүрэг болно. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн шууд үйлчлэх шинжийг хангах замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэдэг. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрлэсэн хэрэг, маргаанд дун шинжилгээ хийх явцад Монгол төрийн бодлого “социаль төр”, “эрх зүйт төр”, “нийгмийн баримжаат төр”, “либераль төр”-ийн төрийн ямар хэлбэрээр замнаж байгаа нь тодорхойгүйгээс хувийн эрх ашиг болон нийтийн эрх ашгийн хамгааллын давуу байдлын талаар өргедэл, мэдээлэл гаргагч, маргалдагч тал, Үндсэн хуулийн цэцийн хооронд ойлгоцын ихээхэн зөрүү байгаа нь ажиглагдаж байна. Үндсэнхуулийншүүхньхүнийэрхийн талаарх маргааныг шийдвэрлэхдээ олон улсын стандарт, өөрийн улсын эрх зүйн зохицуулалтын хүрсэн түвшинг харгалзан эрх зүйн зохицуулалт байнга дэвшилттэй, хүний эрхэд үндэслэгдсэн байх нөхцөлийг харгалзан ажиллах учиртай. 2011 онд Үндсэн хуулийн цэц Засгийн газраас батлан гаргасан “Ахмад дайчдын орон сууцны тухай” 2007 оны 250 тоот тогтоолын 3 дахь хэсгийн “Гадаад, дотоодын

хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2 хувийг үнэ төлбөргүйгээр, 20 хүртэл хувийг өөрийн өргөөр нь тооцож тусгай санд шилжүүлнэ” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэсэн. Үндсэн хуулийн цэцэд өргедэл гаргагч “Монгол улсын төрөөс иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшуулж, ашиглуулахдаа хувийн өмчийн эд хөрөнгийн эрхэнд халдаж байгаа нь Үндсэн хууль зөрчиж байна” хэмээн үзсэн бол Монгол Улсын Засгийн газраас өөрийн батлан гаргасан тогтоолын маргаантай байгаа заалтая “Ахмадуудын талаар төрөөс бодлого боловсруулах, иргэдийн ахуй, орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах нь Засгийн газрын хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарна” хэмээн зөвтгэн тайлбарласан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс уг асуудал нь Үндсэн хуулийг зөрчөөгүй хэмээн шийдвэрлэсэн байна. Миний хувьд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг зөв, буруу эсэхийг тунгаан шүүхийг зорьсонгүй. Харин өмчийн харилцаанд нийтийн болон хувийн эрх ашгийн тэнцвэрийг хангахад маргаантай асуудлыг социаль, эсхүл эрх зүйт төрийн аль хандлагаар харж байгаагаас хамааран шүүхийн шийдвэрийн агуулга тодорхойлогоно. Хэрэв хууль тогтоох байгууллагаас хүний эрхийг хангаж, хамгаалах төрийн бодлогыг тодорхойлоогүй нөхцөлд Үндсэн хуулийн цэцээс хэрэг, маргааныг шийдвэрлэх замаар энэхүү бодлогыг тодорхойлох боломжтой. Төрийн бодлого, хүрэх зорилт нь тодорхойгүй байгаа уед эрх зүйн шинэтгэлийг тогтвортой хэрэгжүүлэх боломж байхгүй. Иймд Үндсэн хуулийн цэц хэрэг

маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн орчин үеийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрхийн зохицуулалтыг нэгдсэн чиглэмжийг бий болгох шаардлагатай байна.

Үндсэн хууль ёсонд нийцүүлэн үндэсний эрх зүйн тогтолцоог шинэтгэх санал боловсруулах нь эрх зүйн шинэтгэлд Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх чухал үүрэг болно.

Монгол улсын Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1-т “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно” хэмээн тодорхойлсон нь дээрх чиг

үүргийг тодорхойлсон чухал заалт болно.

Үндсэн хуулийн шүүх нь төрийн эрх мэдлийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг дан ганц хянаад зогсохгүй өөрийн хараат бус, бие даасан байдлаа алдагдуулахгүйгээр зохимжит байдлаар тэдэнтэй хамтран ажиллах боломжтой юм.

Цаашид төрийн зохих байгууллагууд эрх зүйн шинэтгэлд Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх чиг үүргийг гүнзгий ухамсарлан Үндсэнхуулийншүүхийншийдвэрийг хүндэтгэн биелүүлж, харилцан хамтран ажиллах шаардлагатай байна.

---00---

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ



Монголын Өмгөөлөгчдийн холбооны
шишүүн, өмгөөлөгч Ц.Баасанжав

Нэг. Оршил

Хууль эрх зүй, улс төр болон эдийн засгийн уялдаа холбоо, тэдгээрийг хамтатган судлах асуудал нь сүүлийн жилүүдэд нэлээдгүй дэлгэрч байгаа бөгөөд энэ нь улс орнуудын эдийн засгийн харьцангуй ёсөлт, ялгаатай, тэгш бус байдлын шалтгааныг тайлбарлахад ач холбогдолтой гэж үзэх болсонтой холбоотой. Монгол улсын хувьд ихээхэн хэмжээний байгалийн нөөц баялгийг тойрсон улс төрийн шийдэл, асуудал, эдийн засагчид, хөрөнгө оруулагчдын шүүмжлэлтэй ханддаг “улс төрийн эрсдэл”¹ буюу хууль эрх зүйн тогтвортой байдал ихтэй нь энэ асуудлыг зайлшгүй хөндөх шаардлагыг зүй ёсоор бий болгож байна.

Мөн асуудлыг судалснаар аливаа улс төрийн шийдвэр, хууль эрх зүйн тогтвортой байдал, Монгол улсын Үндсэн хуулийн үйлчлэл, түүний тогтвортой байдал нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа, түүнийг хэрхэн бууруулах талаар тодорхойлох, цаашид хууль эрх зүйн хөгжилд эдийн засгийн ач холбогдолтыг нэмэгдүүлэх боломжтой болно.

Түүнээс гадна Үндсэн хууль болон эдийн засгийн уялдааг эдийн засгийн хөгжилтэй холбо гол хүч болох хөрөнгө оруулагчид, тэдгээрийн үнэлэмжийг зөв тодорхойлон авч үзэх нь цаашдын хууль эрх зүйн тогтвортой хөгжлийн Үндэс болох учиртай.


Хоёр. Хууль эрх зүй ба эдийн засаг

Хөрөнгө оруулагчдын судалгаагаар 2012 онд болсон УИХ-ын сонгуулийг даган Монгол улсын хэмжээнд улс төр, хууль эрх зүйн орчны тогтвортой байдал хурдацтайгаар бий болж, улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурч эхэлсэн. Монгол улсын Засгийн газрын хийсэн Оюу толгой, Таван толгойтой холбоотой хэлэлцээрүүд, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах гэсэн оролдлого зэрэг нь Монгол улсын улс төрийн эрсдэл, тэр дундаа хууль эрх зүйн тогтвортой байдлыг бий болгосон байдаг.²

¹ Улс төрийн эрсдэл гэдэг нь аливаа улс орны эрх бүхий байгууллагын гэнэтийн шийдвэр, бодлогын өөрчлөлт зэргээс үүдэн хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид учирч байгаа эрсдэлийг ойлгоно.

² David Stanway , Key political risks for mining investment in Mongolia, Tuesday , 01 Nov 2011, Re-

Тэрбум ам.доллараар



Үндэсний статистикийн газраас гаргасан судалгаагаар Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалт ойрын хоёр жилийн хугацаанд зурагт үзүүлсэнчлэн эрчимтэй буурсан бөгөөд хэзээ өсч эхлэх нь нь тодорхой бус байна. Монгол улсын 2014 оны ДНБ-ний өсөлтийг Олон улсын Валютын сангаас 9.6 хувь байхаар төсөөлсөн нь өмнөх онууд буюу 2011 онд 12.3%, 2013 онд 11.8 хувийн өсөлтөөс тодорхой түвшинд буурсан үзүүлэлт юм.³

АНУ-ын улс төр судлаач, эдийн засагч Торстен Перссон болон Гүедо Табеллини нарын бичсэн “Улс төрийн эдийн засаг, болон түүний бодлогыг тайлбарлах нь” номондоо улс төр, тэр тусмаа үндсэн хуулийн харилцаа нь тухайн орны эдийн засагт хэрхэн нөлөөлдөг, шийдвэр гаргах зарчмын талаар дэлгэрэнгүй тайлбарласан нь энэхүү сэдвийг олны анхааралд өртүүлэхэд гол нөлөө үзүүлсэн бөгөөд тус номонд эдийн засаг, улс төрийн бодлогын шийдвэр гаргах ажиллагаа, тэдгээрийн холбоог зурагт үзүүлсэн байдлаар тодорхойлжээ. Үүнд:⁴

uters.

³<http://www.imf.org/external/np/sec/pr/2013/pr13526.htm>

⁴Torsten Persson and Guido Tabellini, Political Economics: Explaining Economic Policy, Massachusetts Institute of Technology Press in 2000.

Ерөнхий зарчмын хувьд аливаа улс орон өөрийн үндсэн хуулийн тогтолцооноос хамаарч янз бүрийн эдийн засгийн тогтолцоог сонгосон байдаг бөгөөд үүнийг дагаад дэлхий дээр эдийн засгийн маш олон төрлийн тогтолцоо оршин байна. Тухайлбал төвлөрсөн төлөвлөгөөт, зах зээлийн гэх мэт маш олон төрлийн үзэл номлол, чиг хандлага бүхий эдийн засгийн тогтолцоо оршин байна.⁵

1990-ээдоос эхлэн социалист эдийн засгийн тогтолцоо үндсэндээ ашиггүй гэдэг нь нотлогдож задран унасан. Энэ талаар АНУ-ын нэрт улс төр, эдийн засаг судлаач, эдийн засагч Муррай Ротбард “Эдийн засгийн ач холбогдол” номондоо социалист эдийн засгийн тогтолцоо, түүний задран унах болсон шалтгааныг ингэж тайлбарласан байдаг:⁶

“Хорьдугаар зууны эхэн үед ихэнх улс орон социалист системийг сонгон, үлдсэн орнууд

⁵http://en.wikipedia.org/wiki/Market_economy

A market economy is an economy in which decisions regarding investment, production and distribution are based on supply and demand, and prices of goods and services are determined in a free price system. In contrast, a planned economy is an economy in which investment and production decisions are embodied in a plan of production.

⁶Murray Rothbard, *Making Economic Sense*, Auburn, AL: Ludwig von Mises Institute, 2007, Chapter 99, *The Collapse of Socialism*

нь энэхүү үзэл санаа руу хөтлөгдөж байсан. Гэвч удалгуй өөрсдийгөө шинэчлэгч гэж, бусдыг буруутгаж байсан тэрхүү социалист улсын орчинд дахь хатуу үзэл суртал нь суларч ирсэн. Лудвин Вон Мисэс өөрийн алдарт нийтлэлдээ социалист систем нь урт хугацаанд оршин тогтоно боломжгүй бөгөөд, тус тогтолцоо нь аж үйлдвэржсэн эдийн засгийг удирдан явуулах нь бүү хэл тухайн удирдагчдынхаа шаардлагыг ч хангаж чадахгүй хэмээн анхааруулж байсан.

Харин одоо томоохон социалист улсууд болох ЗСБНХУ, Унгар, Хятад зэрэг улсууд энэхүү системийг өөрчлөхийн төлөө ажиллаж эхэлсэн. Зах зээлийн эдийн засаг нь сүл дорой компаниудыг дампууруулж, улс орныг хямралд хургэсэн бөгөөд гол шалтгаан нь аж үйлдвэржсэн томоохон нийгмийг төвлөрсэн төлөвлөгөөгөөр удирдах боломжгүй гэдэг нь тодорхой болсон.”

Ийнхүү хуучин социалист улс орнууд шинэ үзэл баримтлал бүхий өөрсдийн үндсэн хуулиа шилжин орж буй зах зээлийн эдийн засгийн системийн онцлогт нийцүүлэн, эрх зүйн тогтолцоогоо боловсруулж зах зээлийн чөлөөт эдийн засгийн харилцааг сонгох болсон. Гэвч эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжинэ гэдэг нь тийм ч амаргүй хэрэг гэдэг нь Муррай Ротбардын дурдсанчлан хуучин социалист гэгдэж байсан орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн удаашралтай байдлаас харагддаг.

Нэгэнт алдагдалд орсон ашиггүй, эрэлт, нийлүүлэлтийн уялдаагүй байгуулагдсан, өрсөлдөх чадваргүй, техник, технологийн хоцрогдолтойгээд шинээдийн засагт шилжин ороход нэлээд хүндэрэл учирч байв. Иймээс ч зах зээлийн

сонгодог онолыг алдагдуулан цэвэр зах зээлийн бус социалист-чөлөөт /холимог/ зах зээлийн хэлбэрийг тодорхой хэмжээгээр агуулсан эдийн засгийн тогтолцоонуудыг бий болгох болсон. Өөрөөр хэлбэл пост социалист орнуудын нэлээд нь эдийн засгийг чөлөөтэй тавьж өгч, хувийн өмчийг хүлээн зөвшөөрсөн ч төрийн оролцоог мөн их хэмжээгээр тунхагласан⁷. Төрийн дамжлага маш их хэмжээгээр бий болохын хэрээр чөлөөт эдийн засгийн тогтолцоо алдагдаж зах зээл, бизнест саад болох болсон. Төр нь сэлүүрдэх бус чиглүүлэх үүрэгтэй атал түүнийгээ умартан эдийн засгийн хуваарилалт хийх, эдийн засагт оролцох оролцоо нь нэмэгдсэн.

Харин энэхүү төрийн эдийн засаг дахь оролцоог хязгаарлах цорын ганц арга зам нь Үндсэн хууль буюу түүнд нийцүүлэн гаргах эрх зүйн зохицуулалт, хязгаарлалт бөгөөд үүнийг эрх зүйн шинжлэх ухаанд Үндсэн хуулийн эдийн засаг хэмээн нэрлэсэн 1982 оноос хойш нэлээдгүй хугацаа өнгөрчээ.⁸

Дээрх байдлаарт төрийн оролцоо нэмэгдэх хандлага, үзэгдэл өнөөдөр Монгол улсад ч мөн адил нэлээд байна. Иймээс энэхүү оролцоог хязгаарлах онолын үндсийг судлах шаардлага зүй ёсоор бий болж байна.

Үүний нэгэн илрэл нь 2009 онд Татварын ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран

⁷ Хэдийгээр чөлөөт зах зээл дангаараа оршин байх боломжгүй ч гэлээ чөлөөт зах зээл болон төрийн оролцоо бүхий холимог тогтолцоо өнөөдөр дэлхийд зонхилж байна. Гэвч улс орнуудын төрийн оролцоо зах зээлд байх ёстой гэдэг чиг хандлагыг урвуугаар ашиглах, түүнээс үүдэн төрийн хүнд суртал түүнийгээ дагаад авилга хээл хахууль хөгжжих бий орнуудад газар аваад байна.

⁸ http://en.wikipedia.org/wiki/Constitutional_economics

“Үндсэн хуулийн эдийн засаг” гэсэн сэдвээр олон улсын бага хурал зохион байгуулсан явдал юм. Энд судлаачид Үндсэн хуулийн эдийн засаг хэмээх онолын шинэ үзэл баримтлал чиг хандлага, түүний татвартай холбоотой асуудлаар туршлага солилцсон. Хэдий тийм ч энэ судлагдахуун өнөөдөр Монгол улсын хувьд дөнгөжинэнэр томъёо төдий байгаа бөгөөд гол утга учир, ач холбогдлыг нь шинжлэн судлах Монгол улсад ямар ач холбогдолтой байгааг нь танин мэдэх зүй ёсны шаардлага байсаар байна.

Гурав. Үндсэн хуулийн эдийн засаг

Үндсэн хуулийн эдийн засаг гэдэг нэр томъёог 1982 онд АНУ-ын эдийн засагч Ричард МакКинзи бий болгосон. Үүний дараа АНУ-ын өөр нэг эдийн засагч Джеймс Макгилл Бьюкенен дэд шинжлэх ухааны нэр болгон ашигласан. “Гэрээний болон Үндсэн хуулийн хөгжил нь эдийн засгийн болон улс төрийн шийдвэр гаргах оноолд үндэслэл болох нь” гэсэн Бьюкенены ажил нь түүнд 1986 онд эдийн засгийн салбар дахь Нобелийн шагналыг авчирсан.⁹

Бьюкенен “дээд зэргийн / superior/” гэж үздэг төрийн аливаа нэгдмэл тогтолцоог эсэргүүцдэг байсан. Бьюкенен Үндсэн хууль бүр бүх иргэдэд зориулагдан бүтээгддэг гэдэгт итгэдэг байсан. Иймээс Үндсэн хууль нь төр, нийгэм, хувь этгээдүүдийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх чадвартай байх ёстой гэж үздэг байсан. Энэ Бьюкенены философиийн үзэл нь Үндсэн хуулийн эдийн засгийн суурь философи болдог.

Харин Ludwig Van den Hauwe Үндсэн хуулийн эдийн засаг нь орчин үеийн хууль зүйн шинжлэх

ухаан гэдгийг онцолсон.¹⁰

Үндсэн хуулийн эдийн засаг гэдэг нь улс орны эдийн засгийн чиг хандлага, төрийн эдийн засаг дахь оролцоо, зах зээлийн чөлөөт байдал зэрэг эдийн засгийн ойлголт, зах зээлийн эдийн засгийн суурь зарчмыг Үндсэн хуульд тусгах, Үндсэн хуулиар хамгаалахтай холбоотой судлагдахуун тул эдийн засаг болон Үндсэн хуулийн нийлбэр судлагдахуун юм. Үндсэн хуулийн эдийн засгийг зарим тохиопдолд Үндсэн хуулийн эрх зүйн эдийн засгийн дүн шинжилгээ гэж тайлбарлагддаг. Үндсэн хуулийн эдийн засаг нь Үндсэн хууль дахь эдийн засаг улс төрийн үйл ажиллагааны сонголтын хязгаарыг Үндсэн хуулийн чадавх дээр тулгуурлан тайлбарлахыг зорьдог нь уламжлалт эдийн засгийн чиг хандлагаас ялгаатай.

Үндсэн хуулийн эдийн засаг эдийн засгийн сонголт, хөгжил, үйл ажиллагаанд Үндсэн хуулийн хэм хэмжээний чадавхад гол ач холбогдол өгдөг бол уламжлалт/orthodox/ эдийн засаг эдийн засгийн салбаруудын харилцан үйлчлэл, улс төрийн зүтгэлтний үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулдаг.¹¹ Түүнчлэн Үндсэн хуулийн эдийн засаг нь иргэний Үндсэн хуулиар олгогдсон эдийн засгийн эрхтэй нийцсэн хамгийн сайн эдийн засгийн шийдвэрийг хэрхэн гаргахыг эрмэлзэдэг бөгөөд эдийн засаг, санхүүгийн нөөцийн хуваарилалт нь улс бүрийн томоохон асуудал юм.

Үндсэн хуулийн эдийн засаг энэ асуудлыг шийдвэрлэх хууль

¹⁰http://en.wikipedia.org/wiki/Constitutional_economics

¹¹ Н.Лундэндорж, Үндсэн хуулийн эдийн засгийн тогтолцоон дахь төр-2009 онд болсон “Үндсэн хуулийн эдийн засаг” олон улсын бага хурал дээр тавигдсан илтгэл.

⁹ http://www.nobelprize.org/nobel_prizes/economic-sciences/laureates/1986/buchanan-facts.html

зүйн механизмыг олоход тусалдаг. Үндсэн хуулийн эдийн засаг нь энгийнээр хэлбэл эдийн засаг дахь төрийн оролцоог Үндсэн хуулиар хэрхэн хуваарилах тухай асуудал юм. Адам Смит “Үндэсний баялаг” зохиолдоо төрийн эдийн засаг дахь оролцоо буюу хийх ёстой зүйлийг дараах байдлаар нэрлэсэн. Үүнд:

“Төрхувьхумүүсийнүйлдвэрлэл явуулах үйл ажиллагааг хянах, уг үйлдвэрлэл явавал хамгийн их өгөөж өгөх талаар заавар чиглэл өгөхөөс бүрэн чөлөөлөгдөх ёстой. Яагаад гэвэл энэ тохиолдолд тоолж баршгүй төөрөгдөл эндэгдэлтэй тулгарахаас гадна угаасаа тэр бүхнийг гүйцэд сайн хэрэгжүүлнэ гэвэл хүний оюун ухаан мэдлэг хүрэлцэхгүй. Жам ёсны эрх чөлөөт тогтолцоонд төр ердөө л гурван үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь тун гэгээн том үүрэг, нөгөө талаас хүн бүгдэд ойлгомжтой, тодорхой гурван үүрэг юм. Үүнд:

1. Нийгмийг өөр бусад хөндлөнгийн нийгмийн халдлага хүчирхийллээс хамгаалах;

2. Нийгмийн гишүүн бүрийг нөгөө гишүүдийнх зүгээс учруулах шударга бус явдал, доромжлол, хавчлагаас хамгаалах, өөреөр хэлбэл, шударга шүүхийн тогтолцоог бий болгох;

3. Аль нэг хувь хүн буюу хэсэг хүмүүсийн эрх ашгийн төлөө бус харин олон нийтийг хамарсан ажил хөдөлмөр буюу зарим тодорхой хамтын байгууламжийг бий болгон байнга арчилж үйлчлэх зэрэг.”

Ийнхүү буй болгож, байнга арчилж үйлчлэхийн утга учир нь энэхүү нийтийн ажил хөдөлмөрөөс орох ашиг нь хэзээ ч хувь хүн эсвэл жижиг цөөн бүлэг хүмүүсийн гаргасан зардлыг нөхөхгүй бөгөөд

харин ч ихэнх тохиолдолд нийт нийгэмдээ хавьгүй их илүү өгөөж өгөх ач холбогдолтой юм”¹² гэсэн бол харин М.Фридман, Р.Фридман нар 1980 онд бичсэн “Хувь заяагаа өөрөө сонгох нь” бүтээлдээ төрийн дөрөв дэх үүргийг тодорхойлжээ. Тэд “Хариуцлага хүлээх чадваргүй гэж тооцогдож буй тэр хүмүүсийг төрийн зүгээс ямар нэг хэмжээгээр эцгийн халамжаар харж үзэхээс бүр мөсөн зайлсхийх арга ч нэг талаас бидэнд байхгүй” гэж тодорхойлсон.¹³ Өөреөр хэлбэл төр эдийн засгийн харилцаанд оролцохгүй байх ч тодорхой хэсгийг нь буюу өөрөө бие даан амь зуух чадваргүй тэр хэсэгт нь тодорхой тусламж, дэмжлэгийг олгох ёстой гэж үзсэн.

Харин холимог эдийн засгийн онолоор төр нь эдийн засгийг үр ашигтай(1), шударга(2), тогтвортой(3) байлгах гэсэн 3 үндсэн үүрэгтэй гэж үздэг байна.¹⁴ Мөн төрийн нэг гол үүрэг нь эдийн засгийн балансыг тохируулах явдал юм. Чөлөөт эдийн засгийн онолоор эдийн засаг гэдэг нь ямар ч төрийн оролцоогүйгээр өөрийн эрэлт нийлуулэлтийн хуулиар зохицуулагдаж байдаг гэж үздэг байсан ч өнөөдөр тэр үзэл баримтлал тодорхой хэмжээгээр өөрчлөгдөөд байна. Өөреөр хэлбэл өнөөдрийн эдийн засгийн чиг хандлагыг ажиглавал цэвэр эдийн засгийн онол биш. Үүнийг зарим эдийн засагчид “цэвэр зах зээлийн эдийн засаг гэж байхгүй бөгөөд орчин үеийн зах зээлийн эдийн засгийг холимог эдийн засгийн

¹²Н.Лүндэндорж, Үндсэн хуулийн эдийн засгаар төрийн үүргийг хязгаарлах үзэл номполуудад хийсэн шинжилгээ, Эрх зүй сэтгүүл №18-19, УБ., 2010, 20 дахь тал.

¹³ Н.Лүндэндорж, Үндсэн хуулийн эдийн засгаар төрийн үүргийг хязгаарлах үзэл номполуудад хийсэн шинжилгээ, Эрх зүй сэтгүүл №18-19, УБ., 2010, 21 дэх тал.

¹⁴Г.Цэдэндорж, Эдийн засгийн онол, УБ., 2001 он, 30 дахь тал.

гэж нэрлэгдэж байна” хэмээн тодорхойлж байна.¹⁵

Өнөөдөр эдийн засаг дахь төрийн оролцооны байдлаар нь хэд хэдэн эдийн засгийн онолын ангилал байдаг ч Кейнсийн онолыг ихэнх эдийн засагчид хүлээн зөвшөөрөөд байна. Энэхүү онол нь “улс орны эдийн засаг өөрийгөө өөрийн нөөцөө бүрэн ашиглалаа ч хангахгүй. Хувийн сектор нь зарим нэг макро эдийн засгийн харилцаанд оролцоход заавал төрийн оролцоо шаардлагатай байдаг¹⁶” мөн чөлөөт өрсөлдөөний үед үнэ нь эрэлт, нийлүүлэлтийн жинхэнэ механизм болж үр ашигтай эрэлтийг бүрдүүлж нөөцийг бүрэн бус ашиглах учраас эдийн засгийн тэнцвэрийг хангахын тулд төр эдийн засагт оролцож нь зайлшгүй¹⁷ гэж үздэг. Энэхүү Кейнсийн онол нь холимог эдийн засгийг дэмждэг.

Монгол улсын хувьд Үндсэн хуулиараа “өмчийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрнө” хэмээн заасан. Мөн эдийн засгийн хэлбэрээ “дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгтай байна” гэж заасан. Мөн Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, 5.4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасан.

Гэтэл Үндсэн хуулийн 25 дүгээр зүйлийн 25.1 дэх хэсэгт

“хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”, 25.7 дахь хэсэгт “УИХ нь төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын тесев, түүний гүйцэтгэлийн тайланг батлах эрхтэй” гэж заасан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурал өмчлөгчийн эрхийг хэрхэн хязгаарлах, эдийн засгийг хэрхэн хөгжүүлэх гээд бүхий л эрхийг эдэлж байна. Өөрөөр хэлбэл төр буюу манайхаар УИХ, Засгийн газар зэрэг байгууллага зөвхөн дээр дурдсан дөрвөн үүргийг л биелүүлэх эрхтэй атал бүх эрх хэмжээг УИХ дангаар эдэлж байна. Мөн Үндсэн хуульд “Монгол улс нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгтай байна” гэж заасан нь туйлын тодорхой бус хааш нь ч эргүүлж ойлгож болохоор заалт болсон байна.

Үндсэн хуулийн эдийн засгийн үзэл баримтлалын дагуу Үндсэн хууль нь эдийн засгийн бүхий л суурь зарчим тогтолцоог тунхаглахаас гадна, хамгийн гол нь төрийн эрх мэдлийн хязгаарлалтыг хийж өгөх ёстой байдаг. Гэтэл Монгол улсын Үндсэн хуулийн дагуу бол УИХ нь төрийн эрх дээд байгууллага бөгөөд Үндсэн хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд эдийн засгийнхаа чиг хандлага, үндсэн чиглэлийг тогтоож, татвар, санхүүгийн бүхий л эрх хэмжээг өөртөө шингээсэн superiog төр болон хувирсан гэдэг нь харагдаж байна.

Үндсэн хуулиар төрийн эдийн засаг дахь оролцоог хязгаарлаагүйн улмаас үүссэн жишээ Монгол улсад маш олон байдаг. Тухайлбал 2006 онд батлагдсан Гэнэтийн ашгийн албан татварын тухай хууль юм. Энэ

¹⁵ Г.Цэдэндорж, Эдийн засгийн онол, УБ., 2001 он, 26 дахь тал.

¹⁶ Т.Оргилхүү, Эдийн засгийн тайлбар толь, УБ., 2008 он, 196 дахь тал.

¹⁷ Г.Цэдэндорж, Эдийн засгийн онол, УБ., 2001 он, 17 дахь тал.

татвар нь дэлхийн жишигт байхгүй ямар ч бизнес, эдийн засгийн онолоор хэрэглэгддэггүй тийм нэр томъёоллыг оруулан түүнийгээ УИХ батлан эдийн засгийн хөгжилд ихээхэн саад болсон байдаг. Энэ хуульд тухайн үед Ерөнхийлөгчийг хориг тавиагүй тухай шүүмжлэлтэй хандаж байсан бөгөөд тухайн үеийн Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Д.Намхайжанцан хэлэхдээ:¹⁸

“Хамгийн харамсмаар зүйл нь, нэгдүгээрт, яаруу сандруу батлагдлаа. Хоёрдугаарт, энэ байдлаасаа болоод Монгол Улсын төрийн эрх зүйн зохицуулалтын бодлого, татварын бодлого тогтвортгүй байдаг гэсэн ойлголтыг гадаадын хөрөнгө оруулагч, гадаад, дотоодын түншүүдэд өгсөн нь хүндэрэлтэй байдлыг үүссэлээ. Мөн алт олборлолтынүйлажиллагаэрхэлж буй дотоодын 180 гаруй аж ахуйн нэгжүүдэд асар хүндээр тусч байна. Тэдний ихэнх нь гадны банкнаас зээл авсан, эсвэл гадны түншүүдээсээ техник, технологийн шинэчлэл хийхэд зориулан тодорхой хөрөнгө оруулалтын дэмжлэг авсан байгаа юм. Манай улс капиталын хуримтлалгүй зах зээлд шилжээд арав гаруйхан жил боллоо. Гэтэл гадаадын түншүүд “Зээлээ төлөх баталгаа чинь яаж байна, одоо яаж төлөх гэж байна. Танай татварын орчин чинь ингээд өөрчлөгдчихлөө. Тийм учраас өгсөн мөнгийг, миний оруулсан хөрөнгө оруулалтыг төдийд төлнө гэсэн баталгаа өг” гэх зэрэг шаардлагуудыг тавьж байгаа.”

Мөн Ашигт малтмалын тухай хуульд нэгэнт Тусгай зөвшөөрлөөр

¹⁸ Гэнэтийн ашигийн албан татварын хуульд Ерөнхийлөгч хориг тавьсангүй, Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Д.Намхайжанцангийн ярилцлага, Өдрийн сонин, 2006.05.29-ны дугаар.

олгогдсон талбайг нөөцөд авахаар заасан бөгөөд нөөцөд авах үндэслэл нь тусгай зөвшөөрлийн бүртгэлийг цэгцлэх, улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийх, ашигт малтмал эрэх, хайх, хилийн маргааныг шийдвэрлэх зорилгоор нөөцөд авдаг. Гэтэл тухайн иргэн хайгуул хийгээд, эсхүл ашиглалт явуулаад тодорхой хөрөнгө зарцуулан ирээдүйн эдийн засгийн төлөвлөгөөгөө гаргаад ажил нь явагдаж байхад төрийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас үүдсэн эмх замбаараагүй бүртгэл, эсхүл хилийн маргааныг шийдвэрлэхээр нөөцөд авч байгаа нь өмчлөгчийн эрхийг үндэслэлгүйгээр зөрчиж буй хэрэг. Хичнээн нөхөн төлбөр төлдөг ч энэ нь бизнесийн төлөвлөсөн ашигт хүрэхгүй гэдэг нь тодорхой.

Дөрөв. Дүгнэлт

Төр нь иргэнээ хамгаалах, нийгэмд чиглэсэн бүтээн байгуулалт хийх, чадваргүй хэсгийг нь халамжлах гэсэн хүрээнд эдийн засгийн сэлүүрдэгч биш харин зохицуулагч нь байна. Эдийн засаг, санхүүгийн нөөцийн хуваарилалт нь улс бүрийн томоохон асуудал байх бөгөөд Үндсэн хуулийн эдийн засаг нь дээрх үүргийн хүрээнд төр ямар механизмаар хуваарилалт хийж зохицуулагч байх вэ? гэдэгт хариулт өгдөг. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн эдийн засаг нь эдийн засгийн гол суурь асуудал, зарчмыг Үндсэн хуульдаа хэрхэн тусгах вэ гэсэн асуудлыг судалдаг. Энэ үзэл баримтлалын дагуу Үндсэн хуулиар төрийн эдийн засаг дахь оролцоог маш тодорхой болгох ёстой бөгөөд эдийн засаг, түүний тогтвортой байдалд улс төрийн зүгээс аливаа саад тогтор болохгүй байх талаас нь зохицуулалт хийх ёстой аж.

Судлаачид үзэхдээ улс төрийн аливаа шийдвэр нь иргэдийн эрх ашиг болон тухайн шийдвэрийн үр ашигтай байдал гэсэн хоёр зүйлийг хослуулах шаардлагатай болдог гэж үзжээ. АНУ-ын судлаач, эдийн засагч Торстен Перссон болон Гүедо Табеллини нар өөрсдийн бичсэн Улс төрийн эдийн засаг болон нийтийн санхүү номондоо аливаа шийдвэр нь үр ашигтай байдлыг эрхэмлэх нь зүйтэй байх бөгөөд харин хувь хүн тус бүрийн эрх ашгийг авч хэлэлцэх нь туулийн боломжгүй хэмээн үзсэн байdag.¹⁹

Гэвч зах зээлийн дутагдал, эдийн засгийн хуваарилалтыг засах гэж төр оролдох явцдаа өөрийн мэдэлгүй, үр ашиггүй болон бусдын нийтийн эрх

ашгийг харгалзахгүйгээр зах зээлийн тогтолцоонд үл үзэгдэх зохицуулалт бий болгон улмаар эдийн засгийн үр ашиггүй байдал үүсгэн, асуудлыг улам хүндруулэх нь бий гэж судлаачид тэмдэглэж байна.²⁰

Тиймээс, Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гарч буй аливаа хууль тогтоомж, шийдвэрийн эдийн засгийн үр дагавар, ач холбогдлыг хамтатган судалж, санхүүгийн ойлголтыг хууль зүйн асуудалтай уялдуулах нь чухал байна. Эс тэгвээс төр буюу төрд ажиллаж буй эрх бүхий этгээд нь субъектив байдлаар хандан эдийн засаг дахь төрийн оролцоог ихэсгэж, улмаар үр ашгийг бууруулах эрсдэлтэй.

---00---

¹⁹Persson, Torsten and Guido Tabellini. 2002. Political Economics and Public Finance. In Handbook of Public Economics. Volume 3, ed. Alan J. Auerbach and Martin Feldstein. Amsterdam: North Holland.

²⁰ Н.Лүндэндорж, Үндсэн хуулийн эдийн засгаар төрийн үүргийг хязгаарлах үзэл номлолуудад хийсэн шинжилгээ, Эрх зүй сэтгүүл №18-19, УБ., 2010, 23 дахь тал.

ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХЭД ГАРЧ БАЙГАА ХҮНДРЭЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД



Захиргааны хэргийн анхан шатны
16 дугаар шуухийн шүүгч
У.Бадамсүрэн

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд шүүхийн хяналтаас гадаар байжүл болно" гэсэн заалтыг иш үндэс болгон, Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд, Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын шүүхийн тогтолцоонд анхны дагнасан Захиргааны хэргийн дагнасан шүүхийг байгуулаад 10 жил болж байна. Энэ хугацаанд захиргааны хэргийн анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны шүүхүүд уг шүүхийн зорилго, чиг үүргийг амжилттай хэрэгжүүлж ирсэн гэж би хувьдаа үздэг бөгөөд цаашид шүүхийн зөв төлөвшлийг

тогооход энд ажиллаж байгаа хүмүүсийн хүчин чармайлт их байх болно.

Юуны урьд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар захиргааны хэрэг нь, захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа буюу захиргааны шат, захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа буюу шүүхийн шат гэсэн 2 үндсэн шатыг дамждаг бөгөөд захиргааны процессын эрх зүйн хэм хэмжээнээс захиргааны үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг салган тусад нь хуульчлах ёстой гэдэгтэй санал нэг байдаг. Иймээс энэ нийтлэлд зөвхөн шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа асуудлуудыг хөндсөнөөс гадна өөрийнхөө аймгийн Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргүүдээс жишээ татлаа.

Нэг. Хэргийн оролцогч

1.1. Захиргааны хэргийн шүүх нь нийтийн эрх зүйн субъект болох засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль дээдлэн бэхжүүлэх, хүний эрхийг хэрхэн хангаж байгааг иргэд, хуулийн этгээдийннэхэмжлэлийнүндсэндээр хянан шалгаж, тэдгээр байгууллага, албан тушаалтны хууль бус акт /үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг/ дур зоргын үйл ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зөрчигдсөн эрхийг нь сэргээж

тогтоох зорилго эрх мэдэл бүхий дагнасан шүүх мөн¹.

Энэ тодорхойлолт болон Захиргааны хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ЗХХШТХууль гэх/-ийг 12 дугаар зүйлийн 12.1 заалтаас үзэхэд иргэн, хуулийн этгээд нэхэмжлэл гаргах эрхтэй байна. Тэдгээр нэхэмжлэгч бол хууль ёсны ашиг сонирхол, эрх эрх чөлөөгөө хамгаалуулж байгаа этгээд байх бөгөөд хуульд түүнийг хэргийн оролцогч гэж нэрлэжээ.

Эрдэмтэн Б.Чимид хувь хүний болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг захиргааны хууль бус дур зоргын үйл ажиллагаанаас хамгаалах нь Захиргааны хэргийн шүүх /ЗХШ /-ийн тэргүүн зэргийн чиг үүрэг мөн² гэж үзсэн бол доктор А.Эрдэнэцогт ... захиргааны актаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн нийтийн эрх зүйн хуулийн этгээд ЗХШ-д нэхэмжлэгч байж болно³ гэжээ.

Түүнчлэн аль аймгийн ЗХШ-ийн 2006 оны 2 дугаар сарын 06 өдрийн 01 дүгээр шийдвэрийг давж заалдашшатны шүүхээс/2006.04.17-ны өдрийн 43 дугаар магадлал/ хүчингүй болгоходо нэхэмжлэгч болох аймгийн Онцгой байдлын хэлтсийг хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзэж, захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд биш гээд ЗХХШТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-ийг зөрчсөн гэж дүгнэж байжээ.

Тэгэхээр “хуулийн этгээд” гэсэн нэр томъёог ЗХХШТХуулиар тайлбарлаагүй, зөвхөн хувийн эрх зүйн хуулийн этгээдийг Иргэний

хуулийн үүднээс авч үзэх үү, нийтийн эрх зүйн хуулийн этгээдүүд өөрсдөө тэрийн халдлагад өртөөд ашиг сонирхол нь хөндөгдөөд байвал ях вэ, гэх зэргээс хуулиар нарийвчлан зааж өгөх нь зөв санагдана.

1.2. Хариуцагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бичгээр тайлбараа гарган оролцож байгаад гэнэтхэн нэг тийш / мэдээж албан томилолтоор/ явсан байдаг. Тухайн хэргийн онцлогоос хамаараад хариуцагчийг заавал байлцуулж байж ажиллагаа явуулах шаардлаа гардаг, хариуцагч нь ийнхүү урт богино хугацаагаар шүүхэд мэдэгдэх ч юмуу, өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон үргэлжлүүлэн оролцох арга хэмжээ авахгүйгээр /хариуцагч хуулиар ийм үүрэг хүлээдэггүй/ шүүхээс хариуцагчийг иртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгахаас өөр арга зам байхгүйбайна. Эндминийхэлэхгэсэн санаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх хувилбар байх уу. ЗХХШТХуулийн 48 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалтыг хийхдээ ИХХШТХ-ийн 80 дугаар зүйлийг баримтлахаар заасан. Энд хариуцагч оршин суугаа хаягтаа байхгүй буюу хариуцагчийг эрэн сурвалжлах шаардлага бий болсон гэсэн заалтыг төсөөтэй хэрэглэх боломжгүй байдаг. Учир нь хариуцагч захиргааны байгууллага оршин байгаа хаягтаа байнга байдаг, түүнийг эрэн сурвалжлах бус албан ажлаар тодорхой газарт явж байдаг.

1.3. Шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч, хэргийн оролцогчийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн

¹Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн УБ хот 2004 он 33 дахь тал

²Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн УБ хот 2004 он 37 дахь тал

³ Монгол Улсын захиргааны процессын эрх зүй УБ хот 2006, 161 дэх тал

даргыг бусад оролцогч гэнэ.⁴ Өнгөрсөн хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцсон тохиолдол гаралгаа, харин өмгөөлөгч оролцох асуудал учир дутагдалтай байна. Орон нутагт цөөхөн өмгөөлөгчтэй бүгд бие биенээ мэддэг, хамгийн гол нь хүний эрхийн баталгаа болж байх ёстой өмгөөлөгчид өөрсдөө захиргааны албан тушаалтнаас эмээгээд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй, захиргааны хэрэг маргааныг ойлгохгүй гэх явдал байна. Тухайлбал, иргэн Г.Батсүхийн нэхэмжлэлээр аймгийн Засаг даргад холбогдуулан үүсгэсэн хэрэгт нэхэмжлэгч нь Удирдлагын академид суралцах болсон тул өмгөөлөгч олдоогүй /үнэн хэрэгтээ аймгийн Засаг даргын өөдөөс харьцахаас болгоомжилсон/ тул хадам эцэг болох 71 настай хүнийг итгэмжлэлээрөөрийгөөтөлөөлүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулсан байх юм.

Хоёр. Нотлох баримт

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ.⁵ Гол бэрхшээл нь шүүх өөрөө цуглуулсан нотлох баримтуудыг яаж хууль ёсны болгох вэ гэдэгт байна. Баримт бичгүүд эх хувиараа олдохгүй, олдсон нь архивын хувь байдаг, үүнийг хуулбарлаад хэрэгт хийхэд хуулийн шаардлага хангадаггүй. Заавал нотариатаар гэрчлүүлж батлуулах болдог. Энэ зардлыг цуглуулж олж авснаараа шүүх хариуцах уу, эсвэл шүүхийн олж цуглуулсан баримт нь хэргийн оролцогчдын хэн алинд нь

⁴ЗХХШТХуулийн 54 дугээр зүйлийн 54.2

⁵ ЗХХШТХуулийн 31 дугээр зүйлийн 31.1

ашигтай байна тэр тал нь хариуцах уу?

Хөдөө сумуудад Засаг даргын Тамгын газрын дарга нь нотариатын үүрэг гүйцэтгэгчээр ажилладаг. Энэхүү үүрэг гүйцэтгэгчид нь нэг асуудлыг хоёр өөр өнцгөөс тайлбарлаж, эсрэг тэсрэг дүгнэлт хийж тодорхойлсон байхад хэн хүссэнд нь нотариатын баталгаа хийж өгдөг, аль эсвэл зөвхөн захиргааны талд үйлчилдэг. Ийм нотлох баримтыг шүүх үнэлэхэд бэрхшээлтэй байдаг. Энэ тохиолдолд газар дээр нь очиж шалгалт хийх, нягтлан тодруулах хэрэгтэй ба дагнасан шүүх нотлох баримтаа өөрөө цуглуулдаг гэдэг утгаар нь төсөв санхүү дээр нь анхаарч хуульд зохицуулалт хийвэл ямар вэ/гэхдээ шүүхийн зардлыг улсын тэсвөөс хариуцна гэсэн зохицуулалттай/, практик дээр төсөв мөнгө байхгүй, томилолтын зардал байхгүй зэрэг шалтгааныг шүүхийн захиргааны удирдлагаас тайлбарладаг юм.

Гурав. Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж

Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ. Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээүүзүүлсний төлөөзөхигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ.⁶

Гомдлоор авч хэлэлцэх хэргийн нэхэмжлэл улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгднө гэсэн тэмдэгтийн хураамжийн хуулийн заалтыг хэрэглэх үү, тэгвэл захиргааны хууль бус актын улмаас учирсан хохирлоо арилгуулахаар гаргаж байгаа нэхэмжлэл бүр

⁶ЗХХШТХуулийн 80 дугаар зүйл, ИХХШТХуулийн 57 дугаар зүйлийн 57.1

гомдлын нэхэмжлэл мөн үү зэргээр эргэлзээтэй асуудал байна. Нөгөө талаас ЗХХШТХуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д: “Захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг ИХШХШТХуулийн 52-60 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ” гэж алгасуулан ишилсэн зүйл, заалтууд бүгд таарч хэрэглэгдэж байна уу гэдэгт бас асуудал байна.

ЗХШ-д нэхэмжлэгчийн тавьж байгаа шаардлагууд үндсэндээ хангагдаж байдаг. Энэ тохиолдолд хариуцагч нь мэдээж захиргааны байгууллага, албан тушаалтнууд байдаг ба ихэнх нь төсвийн байгууллага байдаг. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хангасныг эс зөвшөөрч давж заалдах, хяналтын гомдлыг гаргахдаа тэмдэгтийн хураамж төлөх үү. Одоогийн практикаар төлдөг.

Гэхдээ ЗХХШТХуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д давж заалдах гомдлын хэлбэр, агуулга нь ИХШХШТХуулийн 162 дугаар зүйлийн 162.1-162.3-т нийцсэн байна гэж ишилснийг харахад хуулийн 162.4-ийн “давж заалдах журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ” гэсэн заалтыг ишлэхгүйгээр орхигдуулсан байдаг. Үүнийг анологи хийгээд эсвэл ЗХХШТХуулийн 2 дугаар зүйлд зааснаар угаасаа захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Шүүхийн тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэх тул нарийвчлан ишилж заагаагүй

ч гэсэн агуулгаар нь хэрэглэх боломжтой юм.

Тэгвэл Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас 2003 оны 11 дүгээр сард гаргасан “улсын тэмдэгтийн хураамжийн тухай” зөвлөмжинд төсвийн байгууллага давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргахад улсын тэмдэгтийнхураамжийгтөлүүлэхгүй. Учир нь ИХШХШТХ-ийн 162 дугаар зүйлийн 162.4, 173 дугаар зүйлийн 173.3-т: “...гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ” гэж заасан бөгөөд уг 57 дугаар зүйлийн 57.1 заалт нь анх нэхэмжлэл гаргахад тэмдэгтийн хураамжийг төлүүлэхтэй адил агуулгаар тусгагдсан билээ. Иймд Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт төсвийн байгууллагын нэхэмжлэл хураамжаас чөлөөлөгдхөөр заасны дагуу төсвийн байгууллагын нэхэмжлэл давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдол улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгднө гэж ойлгоно” гэжээ.⁷

Дээр дурдсан үндэслэлээр хариуцагч захиргааны байгууллагаас давж заалдах гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлэхгүйгээр хоёр хэргийг хүргүүлсэн жишээ байгаа ба харин давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүх тэмдэгтийн хураамжийг төлүүлээгүй буруутай болохыг магадлалдаа тэмдэглэж байжээ.

⁷ Монгол Улсын дээд шүүхийн мэдээлэл 2003 он №4

ДҮГНЭЛТ

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар төр, иргэний хооронд үүсэх эрх зүйн харилцааг баталгаажуулж өгсөн бөгөөд иргэний эрх, эрх чөлөөг дээдэлж, түүнийг зөрчигдсөн гэж үзвэл төр, захиргааны байгууллага, албан тушаалтны эсрэг шүүхэд хандаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах боломжийг бий болгосон юм. Хэдийгээр хуулиар ийм боломж олгосон боловч ард иргэдийн дунд захиргааны хэргийн шүүх, захиргааны хэрэг шийдвэрлэх ажиллагааны талаарх ойлголт бага, үнэлэмж сайн биш байгаа юм.

Энд ажиллаж байгаа шүүгч, ажилтнуудаас гадна эрх зүйн бодлогын хэмжээнд авч үзэж ард иргэдийн сэтгэлгээнд өөрчлөлт оруулах /даргыгаа тахин шутдэг, дарга албан тушаалтнууд буруу зүйл хийдэггүй гэсэн хатуу байр суурьтай байдаг/ хүний салшгүй эрхүүдийг хэн нэгэн дуртай үедээ хөндөж, хууль зөрчих ёсгүй гэдгийг дахин дахин сурталчилж таниулах нь хамгаас чухал гэж үзэж байна.

Монголын ардчиллыг дэмжин байгаа гадаадын төсөл, үүнд: Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэл”, Ханис-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи зэргээс эрхлэн болон ивээн тэтгэж гаргасан ном сурх бичиг, гарын авлага материалууд нь практик ажилтнуудад ач холбогдоо өгдгийг сайшаан тэмдэглэх нь зүйтэй.

Дээрх бичсэн зүйлдээ үндэслээд дараах саналыг дэвшүүлж байна.

- Юуны урьд захиргааны үйл ажиллагааны эрх зүйг захиргааны процессын эрх зүйн хэм хэмжээнээс

ялган нарийвчлан хуульчлах, үүний сацуу захиргааны ерөнхий эрх зүй, захиргааны тусгай эрх зүйг зааглах;

- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөрийн өвөрмөц онцлогтой, өргөн хүрээтэй олон асуудал хамардаг тул хуульч эрдэмтэд, практик ажилтнуудаас санал авч ЗХХШТХУУЛЬД яаралтай өөрчлөлт оруулах;

- Ялангуяа хуулийн нэр томъёог тодруулж, дэлгэрүүлж тайлбарлах, тухайлбал, нийтийн захиргааны бусад байгууллагын шийдвэр гэдэгт юуг хамааруулах, хэргийн хариуцагч шүүхийн дудсанаар хүрэлцэн ирэхгүй тохиолдолд үүсэх үр дагаврыг хуульчлах, нэгэнт ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөөд, захиргааны хэргийн шүүх дуудаад байхад ирдэггүй хүнд суртал гаргадаг этгээдүүдэд шүүхийн нөхөн төлүүлэх зардлыг хариуцуулах, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх асуудлыг нарийвчлах гэх мэтээр нэг мөр цэгцтэй ойлголт өгөх;

- Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс холбогдох тайлбар, зөвлөмжүүдийг байнга өгч байгаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн нэг зарчимд үндэслэж хуулийг хэрэглэж байгаа боловч хуулийг яаж тайлбарлаж хэрэглэх нь тухайн шүүгчийн дотоод итгэл, хууль зүйн өндөр мэргэшлээс шууд хамаарч байдаг тул шүүгч нарын сургалтаар нэгдсэн ойлголтуудыг өгч байх;

- Захиргааны хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйл захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх гэсэн зохицуулалтыг илүү нарийвчлах;

- Захиргааны байгууллага, албан тушаалтнууд өөрсдийн гаргасан шийдвэртээ гомддоггүй, нөгөө талаас захиргааны хэргийн шүүх өөрийн санаачилгаар хэрэг үүсгэдэггүй тул ашиг сонирхол,

эрх, эрх чөлөө нь хөндөгдсөн гэж үзэж байгаа иргэд өөрсдөө идэвх санаачилгатай байж, тэдний нэхэмжлэлээ хэр үндэслэлтэй гаргаж байгаагаас энэ шүүхийн хувь заяа, зөв төлөвшил яригдах тул сургалт, сурталчилгааг тодорхой төсөв, төлөвлөгөөтэй тогтмол хэрэгжүүлж байх.

---oo---

ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА ШАЛГУУР-ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА СЭДВИЙН ХҮРЭЭНД*



МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн
захирлын туслах, хууль зүйн ухааны
магистр О.Алтантуяа

Регресс

Аргалын эвэр тэмзэнд хэрэггүй
Адууны сүүл ямаанд хэрэггүй
Архины лонж шүүвүнд хэрэггүй
Алтан бөгж сармагчинд хэрэггүй
Хөлийн оймыг гаргт өмсөөвлөв ямар вэ?
Хөхөнөний дуугаар нокой дондодвөл ямар вэ?
Хөхний даруулгыг нүдэндээ зүүвэл яах вэ?
Хөрсний анжсаар дээл эсгэвэл яах вэ?
Зохицохгүй юмыг зохицуулах гэвэл
Зөвлөн болохос ашиг болохгүй
Зохицох ёсог гэвэй, дотроо бас
Зориуд тааруулсан өөрийн цагтай¹
Улзэрэлзээс, өөчтөнийг эмчлэх эмч хүмүүн
Үүргээ умартаал хэрээ юун
Хууль хэрэглэгч шүүгч хүмүүнээр
Хаа хамаагүй мэргэжилтнийг сонговол,
аюул гэдэг тэр бизээ...

Оршил

“Би шүүхийг гал сөнөөгч маягаар төсөөлж ойлгодог бөгөөд улс гэрээ шатаахгүй тулд энд тэнд гал гарвал гарсан доор нь унтрааж явдаг мэдрэмжтэй байгууллага гэж үздэг² хэмээн АНУ Дээд шүүхийн эрхэм шүүгч Сандра Дэй О’Коннорын хэлсэн үгээр өөрийн сэдэмжийг эхлүүлэхийг хүслээ. Учир ньнийгмийнамьдралөөрчлөгдхэхийн хэрээр хуулинд тусгагдаагүй зохицуулагдаагүй хийдэл олон байх бөгөөд шүүхээс тухайн тохиолдолд хуулийг хэрэглэхдээ хууль, эрх зүйн зохицуулалтгүй байсан хэдий ч (энэ нь эрүүгийн эрх зүйд хамаарахгүй) тайлбарлах замаар уг хийдлийг арилгах ёстой³ юм. Тиймдээ ч шүүхийн үйл ажиллагааны цорын ганц чиг үүрэг нь хууль хэрэглэх бөгөөд шүүхээс тухайн тохиолдолд хуулийг хэрэхэнхэрэглэжтайлбарлаж буйгаар нь эрх зүйн шинжлэх ухааны хөгжилтодорхойлогдож, ард олны шүүхэд итгэх итгэл нэмэгдэх төдийгүй улмаар үндсэн эрх, эрх чөлөө, ардчиллын суурь зарчмууд бэхжин баталгаажиж⁴ байдаг. Угтаа шүүхийн төрлөөс үл хамааран хуулийг хэрэглэх нь шүүгчдийн амин чухаласуудал байх нь дамжигүй юм. /Үндсэн хуулийн Цэцийг шүүх мөн, биш гэх, Цэцийн гишүүдийг шүүгч

* Эрх зүй сэтгүүл.УБ.,2002 №8-9.Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын хамгаалан дэмжих тухай семинарт эрхэм шүүгч Сандра Дэй О’Коннорын хэлсэн уг.47 дах тал.

¹ Regelsberger, Pandakten. 1893., p156

² О.Алтантуяа. Хууль хэрэглэх онол, практикийн зарим асуудалд. Илтгэл

^{*} Үндсэн Хуулийн Цэцийн даргын нэрэмжит сэдэмж бичгийн уралдааны дэд байранд шалгарсан илтгэл

¹ Чойном Р. Сүмтэй бударын чулуу., УБ., 1990., 118 дахь тал

мөн, биш хэмээх маргаан өдгөө нэг тийш болж Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн шүүх мөн гэдгийг манай олон эрдэмтэн, судлаачид өөрсдийн судалгаа, бүтээлүүдээрээ нотолсон байдаг.

Хууль хэрэглэх субъект нь гагчхүү шүүх, шүүгч бөгөөд шүүх, шүүгч нь хуулийг эцэслэн хэрэглэдгээрээ бусад субъектээс ялгаатай. Өөрөөр хэлбэл социализмын үед бичигдсэн бүтээлүүдийг судалж үзэхэд хууль хэрэглэх, хууль тайлбарлах хэмээх ойлголтыг хоёр өөр ойлголт, хоёр өөр ертөнц мэтээр авч үзсэн байх ба манай зарим эрдэмтэн, судлаачид, улс төрчид үүнийг одоо хүртэл хоёр өөр асуудал мэт ойлгосоор байна. Эрх зүйн сонгодог онол ёсоор хууль хэрэглэх, хууль тайлбарлах хэмээх ойлголтыг нэг ойлголт хэмээн үзэх болсон төдийгүй социалист нийгэмд онолын үзэл баримтлал, шүүхийн практикт хоёр өөр мэт байсан эрх зүйнерөнхийонолын “хууль хэрэглэх”, “хууль тайлбарлах” хэмээх судлагдахууныг өнөө цагт нэг болгож хэрэглээний шинж чанар олгох нь зайлшгүй чухал⁵ асуудал болсоор байна. Шүүгчид хууль хэрэглэн дүгнэлтээ итгэл үнэмшилтэйгээр бичиж шийдвэрийнхээ учир шалтгааныг хэн ч ойлгохуйцаар ойлгомжтой, Үндэслэлтэй тайлбарлан бичиж, эрх зүйн шинжлэх ухааны тусламжтайгаар шийдвэрээ сайжруулах хандлага бий болсоор байна. Эрх зүйн аливаа маргаан хэрэг тохиолдлыг шүүхээс шийдвэрлэнэ гэдэг нь хуулийг хэрэглэх, улмаар түүний үзэл баримтлалын үүднээс тайлбарлах гэх ойлголт юм. Ийнхүү шүүгчдэд зайлшгүй байх чадвар бол хууль хэрэглэх чадвар юм. Шүүгч нь хууль хэрэглэх чадвартай байхын тулд

⁵ О.Алтантуяа. Хууль хэрэглэх онол, практикийн зарим асуудалд. Илтгэл. 2 дахь тал

хуульч байх шаардлагатай гэдэг нь хэнд ч ойлгомжтой билээ.

“Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл нь нэг хүний гарг тевлөрвөөс энэ нь эцэстээ дарангуйлалд хүргэж эрх чөлөөний үнэр ч үгүй болно. Засаглалыг хувааж тэдгээрийн харилцан тэнцвэрт байдал тогтсон үед л хууль бус явдал зогсож, иргэд амар амьдрах баталгаатай болно” хэмээн XIII зууны үеийн Францын улс төрийн сэтгэлгээний гол төлөөлөгч Шарль Луй Монтескье төрийн эрх мэдлийн гурван салаа мөчрийг тодорхойлсон байдаг. Ийнхүү БНМАУ-ын Ардын Их Хурал 1992 оны 1 дүгээр сарын 13-нд Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталснаар төрийн гурван эрх мэдэл болох хууль тогтоох /УИХ/, гүйцэтгэх /засгийн газар/, шүүх /Үндсэн хуулийн цэц болон дагнасан шүүхүүд/ эрх мэдлүүд харилцан тэнцвэртэй нэг нэгнээсээ хараат бусаар орших үндэс суурийг бүрдүүлсэн билээ. Гэтэл УИХ-ын гишүүн засгийн газрын гишүүний ажил, албан тушаалыг хавсарч болохоор⁶ хуульчилсан, Үндсэн хуулийн цэцэд улс төрийн өндөр мэргэшилтэй /түүхч, уул уурхайн ашиглалтын инженер, түүх, газар зүйн багш зэрэг мэргэжилтэй/ гэх нэрийдлээр хуульч биш хүмүүс сонгдох болсон зэрэг нь ардчиллын хөгжлийг хойш татаж, төрийн эрх мэдэл хуваарилалтыг алдагдуулж, нийгэмд олон сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Шинэ Үндсэн хууль бидний нийгэмсоёлын бүхийл үнэт зүйлсийг бэхжүүлэн бататгаж, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал,

⁶ Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлийн 1-Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

ард түмний эрх, эрх чөлөөний баталгаа болохоос гадна өмнөх (1924, 1940, 1960 онуудын) Үндсэн хуулиудтайхарьцуулахадолончухал өөрчлөлт, шинэчлэлтийг өөртөө агуулахын сацуу өнөөгийн эрх зүй болоод нийгмийн хөгжил дэвшилийн гол чиг шугамыг тодорхойлж байна. Үүний нэг жишээ нь Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх “Үндсэн хуулийн Цэц” цоо шинээр бий болсон явдал юм. Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д зааснаар “Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага бөгөөд Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” хэмээжээ. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг чандлан сахиулах манаачийн хувьд түүнийг төрийн байгууллага, албан тушаалтны дур зорго, аливаа эрх мэдэлтэн, дураар авирлагчдын хувийн ашиг сонирхлоос хамгаалж, төр, түүний албан тушаалтны зүгээс хүн нэг бурийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөөнд халдсан хууль бус үйлдлийг таслан зогсоох чиг үүрэг бүхий бие даасан шүүх билээ. Ийм ч учраас Үндсэн хуулийг хамгаалах арга хэрэгсэл нь Үндсэн хуулийн Цэцийн “шийдвэр” байх тул Үндсэн хуулийн Цэцийн гишүүд дүгнэлтээ итгэл үнэмшилтэй, үндэслэлтэй бичиж, шийдвэрийнхээ учир шалтгааныг хэнбүхэндойлгогдохуйцтайлбарлах чадвартай⁷ Монгол улсын шилдэг, туршлагатай, мэргэшсэн хуульч байх шаардлага⁸ зүй ёсоор урган Бямбажаргал.А. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэгээ: Эрх зүйн шинжилгээ. Хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл. УБ.,2009. 4 дэх тал

⁷ О.Алтантуяа. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилоход тавигдах шаардлага, түүний хэрэгжилтэд холбогдох зарим асуудал. Хууль зүйн ухааны бакалаврын зэрэг горилсон бүтээл. УБ. 2011. 4 дэх тал

гарна.

Монгол Улсын **Үндсэн хуулийн** Жаран тав дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хурсэн иргэнийг томилно⁹; Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Цэцийн гишүүн хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүгийн ял шийтгэлгүй, Монгол Улсын дөчин нас хурсэн иргэн байна¹⁰ хэмээн Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг тус тус хуульчилсан. Ийнхүү Үндсэн хуулийн Цэц (шүүх) байгуулагдсанаас хойш Цэцэд 30 орчимгишүүнтомилогдонажилласан байдаг. Эдгээр гишүүдийн мэргэжлийг авч үзвэл дийлэнхи гишүүд нь хуульч мэргэжилтэй байх боловч хуульч биш мэргэжлийн нэлээд хүмүүс ажиллаж байсан, өдгөө ч ажилласаар л байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүд бусад шүүхийн шүүгчтэй харьцуулахад өндөр шалгуураар шигшигдэн томилогдож ажилладаг мэргэжлийн хуульчид байх шаардлагатай атал ийнхүү хуульч биш мэргэжлийн хүмүүс ажилласаар байгаа нь хуулийн заалтаас улбаатай юу?

“Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол улсын дөчин нас хурсэн иргэнийг томилно” хэмээн заасан заалтыг **утгачилан** тайлбарлавал:

1.1 Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэдэг нь: Мэргэжлийн диплом эзэмшсэн тэдий ойлголт биш. Тухайн хуульч улс төрийн хувьд өндөр мэргэшсэн байх шаардлагатай бөгөөд тэр нь уг хүний академик боловсрол, практик

⁹ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он

¹⁰ Үндсэн хуулийн цэцийн тухай хууль 1997 он

үйл ажиллагааны үр дүн нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, тун үгүйдээ тухайн мэргэжлийн хэсгийн дотор зохих хэмжээнд танил болж зэрэг үнэлэгдсэн байх ёстой.

1.2. Монгол Улсын иргэн байх: Монгол улсын харьяат иргэн гэх албан ёсны баталгаатай бөгөөд иргэний хувьд хоёрдмөл харьялалгүй хүн байх ёстой. Монгол улсын унаган харьяатаар сүүлд зөвшөөрүүлсэн гэх ялгаа байж болохгүй.

1.3. Цэцийн гишүүнээр ажиллахад 40 нас хүрсэн байх:

Юуны өмнө уг хүн ажил, амьдралын тодорхой дадлага, туршлагатай болж, хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй болсон байх шалгуурын давхар баталгаа нь юм. Хүнийг 23-25 насанд дээд боловсрол эзэмшдэг гэхэд уг хүн сургууль төгсөж мэргэжил эзэмшсэнээс хойш 15-17 жил мэргэжлийн дагуу тасралтгүй ажилласан байхад академик боловсролын төдийгүй практик үйл ажиллагааны хувьд өндөр мэргэшсэн байх боломжийн доод хугацаа юм¹¹.

2.“Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно” хэмээн заасан заалтыг хэл зүйн¹² хувьд тайлбарлавал:

2.1 (,) Үүнийг 1952 онд тасалгаа¹³ гэсэн нэршлээр хэрэглэж байсан бөгөөд 1954 оноос таслал хэмээн нэрлэх болсон. Таслалыг өгүүлбэрийн доторх зэрэгцсэн гишүүдийг бие, биеэс нь салангадыг үзүүлэхийн тулд хамгийн сүүлчийнхээс бусдын дараа бүр тавьж хэрэглэвэл зохино¹⁴ хэмээн хэл зүйн ухаанд үздэг бөгөөд зэрэгцсэн өгүүлэгдэхүүнийг тасалгаагаар салгахын жишээ нь: Богд ууланд хус, хуш, хар мод, нарс, гацуур, улиас ургадаг¹⁵ хэмээжээ.

Таслал гэдэг бол 2 зүйлийн тэнцүү гэдгийг илтгэх бөгөөд нэг нь нөгөөгөөсөө ялгаатайг илэрхийлэх¹⁶ тул “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно” хэмээснийг Монгол Улсын 40 насанд хүрсэн иргэн хууль зүйн өндөр мэргэшилтэй болон улс төрийн өндөр мэргэшилтэй байж Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдох боломжтой хэмээн тайлбарлахад хүрнэ. Өөрөөр хэлбэл хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэсэн нь хоёулаа нэг хунд тавигдах шаардлага бөгөөд эдгээрийн аль нэгээр мэргэшсэн хүн тухайлбал улс төрч боловч хуульч биш хүн, хуульч боловч улс төрийн өндөр мэргэшилгүй¹⁷ хүн нь Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллах боломжгүй хэмээн үзэхэд хүргэж байна.

¹³ Ш.Лувсанвандан. Монгол хэлний зүй II боть. УБ., 2010. 348 дахь хуудас

¹⁴ Ш.Лувсанвандан. Монгол хэлний зүй III боть. УБ., 2010. 237 дахь хуудас

¹⁵ Мен тэнд 348 дахь тал

¹⁶ Ж.Баянсан, Ш.Одонтер. Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь. УБ., 1995

¹⁷ Аль нэг аж ахуйн нэгжид олон жил үр бутээлтэй ажилласан, магадгүй дан ганц салбарынхаа хууль тогтоомжийг илүү сайн мэддэг болсон, улс төрийн боловсрол нь хангалтгүй хуульч хүн Үндсэн хуулийн цэцийн гишүүн байх нь Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг хангахгүй юм.

¹¹ Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000.256 дахь тал

¹² Уг тайлбараар тухайн улсын хэлний ерөнхий зүй тогтолцд тулгуурлан хийгдэж байдаг. Ингэхдээ тухайн эрх зүйн зохицуулалтад хэргэлэсэн үг хэллэгийн салаа, ойлгомжгүй нэр томьёог тодорхой нөхцөл байдалд өгүүлбэрийн утгатай уялдуулах байдлаар хэрэглэнэ. Монголын тэр, эрх зүй сэтгүүл. УБ., 2005. Д.Наранчимэг. Хуулийн тайлбар ба шинжлэх ухааны тайлбарын онцлог. Нийтлэл. 16 дахь тал.

Үүнийг эрдэмтэн Н.Жанцан болон Ц.Сарантуяа нар хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэдэг нь уг хоёр мэргэшлийн аль нэгийг биш, хоёуланг нэгэн зэрэг нэг хүн эзэмшсэн байх гэсэн утгатай гэж үзээд Үндсэн хуулийн цэцийн гишүүн нь шүүгч хүн болохын хувьд тухайн хүний суурь мэргэжил нь хуульч байгаад зогсохгүй мэргэжлээрээ олон жил ажилласан мэргэшсэн хуульч байх ёстой хэмээн нотлон тайлбарласан байдаг. Харин улс төрийн мэргэшлийн хувьд энэ чиглэлээр тусгайлсан дипломын боловсролсон байхыг шаардахгүй бөгөөд тухайн хүний өмнө нь хашиж байсан ажил албан тушаал, сонирхол, улс төрд оролцож байсан байдал зэргийг хамааруулдаг¹⁸ байна. Өrnөдийн улсуудад улс төрөөс ангид байсан хүнийг Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр сонгодог бичигдээгүй хууль байдаг.

2.2 Үгийн үгчлэн¹⁹ тайлбар

Дээрх тайлбаруудаас үзвэл мэргэшил гэдэг үгийн утгыг гаргах шаардлагатай байна. Үүний тул мэргэжил болон мэргэшил хоёрын ялгааг авч үзэх шаардлагатай.

2.2.1. Мэргэжил: Аливаа нэг салбарын үйл ажилд тэнцэх мэдлэг боловсрол эзэмшин, тухайн чиглэлээр мэргэжлийн сургууль төгсөн диплом авсан байх;

2.2.2 Мэргэшил: Аливаа нэг мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай туршлага, дадал эзэмшсэн байх. Өөрөөр хэлбэл ямарваа нэг салбарын хүрээнд голлож эзэмшсэн мэдлэг, боловсрол, мэргэжил дээрээ тулгуурлан тухайн чиглэлийн дадлага, туршлагыг хуримтуулсан байх;

Мэргэжил нь аливаа нэг салбар чиглэлээр тусгайлан суралцаж диплом авсан байх шаардлагатайг илэрхийлдэг бол мэргэшил гэдэг нь тэрхүү мэргэжил дээр тулгуурлан гүнзгийрсэн мэдлэг, чадвар, дадал, туршлага суусан байх шаардлага юм. Иймд Үндсэн хуулийн цэцийн гишүүн нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй байх гэдэг нь хуульч байхаас гадна хууль зүй болон улс төрийн үйл ажиллагааны талаар дадал, туршлага, мэдлэг чадвартай байх шаардлагыг илэрхийлэх тул Үндсэн хуулийн цэцийн гишүүн заавал хуульч байх шаардлагатай болох нь Үндсэн хууль болоод Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн холбогдох зүйл заалтын тайлбараар нотлогдож байна.

Шүүгч хүн улс төрийн албан тушаалтан биш, шүүх нь нь улс төрийн хүчинүүдийн төлөөллийн нэгж буюу улс төрийн балансыг тэнцүүлэх зориулалтаар бий болсон нэгж ч биш, харин хуулийн уг үсгийг баримтлан “хуулийн ноёрхлыг буюу хүний эрхийг” хамгаалах зориулалттай байгууллага байдаг. Ийм ч учраас шүүгч хүн, энэ тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн гишүүн хүн мэргэжлийн арвин туршлагатай хуульч хүн байх ёстой гэдэг нь утгаа хуулиар ч зохицуулах шаардлагагүй, хөгжингүй нийгэмд хэнд ч ойлгомжтой зүйл юм. Харин энэхүү “мэргэжлийн арвин туршлага” буюу манай Үндсэн хуулийн дагуу

¹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. өгүүлэл илтгэлийн эмхтгэл: Н.Жанцан. Монгол Улсад Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, чөлөөлөх зарим онцлог.УБ.,2007. 337 дах тал

¹⁹ Уг тайлбарын онцлог нь хуулиар зохицуулж буй харилцаан дахь аливаа нэр томъёог чухам хэрхэн ойлгох байдлыг тайлбарлаж байдаг. өөрөөр хэлбэл эрх зүйн нэр томъёо цаашид уг зохицуулалт бусад заалтуудтай хэрхэн холбогдох байдлыг илтгэж байдаг. А.Бямбажаргал. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэгээ: Эрх зүйн шинжилгээ.Хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл. УБ.,2009. 49 дэх тал

цэцийн гишүүн хүнд тавигдах "хууль зүйн өндөр мэргэшил" гэдэг шаардлагад чухам юуг хамааруулах вэ гэдгийг манай нөхцөлд "цэцийн тухай хууль"-иараа тодотгож өгөхгүй бол өмнө нь парламентийн гишүүн байсан, ерөнхий мэдлэг чадвар сайтай, угаасаа төлөв төвшин хүн зэрэг "зэрэг" боловч төрөл бүрийн, мэргэжлийн бус үзүүлэлтээр цэцийн гишүүний нэрийг дэвшүүлж байгаа нь манай оронд Үндсэн хуулийн шүүх бүрэлдэхүүний хувьд төлөвших ёстой утгаараа төлөвшихгүй байдалд хүргэж²⁰ байгаа нь хуулийн хэрэгжилт, практикаас харагдаж байна.

Дээрхээс үзвэл хуулийн зүйл заалтаас улбаалан хуульч биш мэргэжилтэй хүмүүс Үндсэн хуулийн цэцэд томилогдож байна гэж үзэх үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл хуульд тодорхой заасан байтал хуульч биш мэргэжилтэй хүмүүсийг Цэцийн гишүүнд нэр дэвшүүлж, томилон ажиллуулдаг нь томилогдохыг хүссэн хүмүүс,

санал болгож, томилж буй эрх бүхий байгууллага, албан тушаалтын аль алиных нь ашиг сонирхол эсвэл хуулийн холбогдох заалтыг гүйвуулан, өөрсдийн эрх, ашигт нийцүүлж ирсэнтэй холбоотой.

Ийнхүү хуулийг гүйвуулан ойлгож, хууль бус томилгоо хийж байгаагаас улбаалан ард иргэд ч Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн талаар буруу ойлголттой²¹ болоод зогсохгүй, улс төрийн албан тушаалын наймаа газар авах бололцоотой бөгөөд энэ нь цаашлаад Үндсэн хуулийн шүүхийн хуульч шүүгч болон хуульч биш шүүгч²² хэмээх асар том ялгааг²³ бий болгосоор байх тул хуулийн шаардлагын дагуу ядаж Үндсэн хуулийн Цэцийн гишүүдийг томилж байвал Үндсэн хуулийн мөн чанар, үзэл баримтлал ухарч буй нэг ч атугаа үйлдэл таслан зогсох нь дамжиггүй юм.

---0o---

²⁰ Ц.Сарантуяа. Шүүгчдэд тавих Үндсэн хуулийн шаардлага ба цэцийн бүрэлдэхүүн. З дах тал

²¹Монгол улсын Ерөнхий сайд С.Батболдын санаачилгаар саяхан зохион байгуулсан улс төрийн нэгэн уулзалт дээр манай улс төрийн хучний нелөө бүхий эрхэм "Ерөнхийлөгч асан улс төрд орохгүй Үндсэн хуулийн цэцэд ороод сууж байх хэрэгтэй" хэмээн ярьсан.

²² Угтаа хуульч биш шүүгч дэлхийн хаана ч байхгүй гэдэгтэй та ч санал нийлэх бизээ.

²³Хуульч гишүүд хуульч биш гишүүдээс илүү их өргөдөл шалгаж ажилладаг.

ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ МЭТГЭЛЦЭХ ЗАРЧМЫН ТАЛААРХ ЗАРИМ АСУУДАЛ

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч
Л.Даваасүрэн

Монгол Улсын Үндсэн хуулийн 1.2-т "...хуульдээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн..." гэж заасан. Хуулийг дээдлэх гэдэг нь мөн чанартай хуулийн заалтыг хатуу чанд сахин биелүүлэх ёстой гэсэн ойлголтыг агуулдаг. Үүнээс үүдэн, Үндсэн хууль, түүнд нийцүүлж гаргасан бусад хуулийг байгууллага, албан тушаалтан, иргэн, тус улсад суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс нэг мөр сахин биелүүлэх үүрэгтэй гэж үзвэл монголын шүүхнь Улсын нэрийн өмнөөс шүүн таслах үйл ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй байгууллага. Шүүхийнтэрхүүүргийг өрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын мэтгэлцэх нөхцөл, боломжийг аль хир хангаснаар нь дүгнэж болно /Эрүүгийн байцаан шийтгэх хууль /ЭБШХ-/ийн 17 дугаар зүйлийн 17.1-ийн "...шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана..." гэж заасан/.

Мөн зүйлийн 17.2, 17.3, 17.4 дэх хэсгүүдэд "... шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээнэ...", "...Өмгөөлөгч

нь шүүгдэгчийг өмгөөлөхийн тулд хуульд заасан бүхий л арга хэрэгслээр хууль зүйн туслалцаа үзүүлнэ...", "...тaluуд шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар санаалаа илэрхийлэх талаар эрх тэгш байна..." гэсэн нь эрүүгийн шүүн таслах ажиллагаа нь яллах, өмгөөлөх талуудын хоорондын мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчмыг тодорхойлон заасан.

Гэвч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх практикийн явцад ойлгомжгүй асуудал багагүй тохиолдож байна. Тухайлбал:

1. ЭБШХ-ийн 34 дүгээр бүлэг буюу шүүхийн хэлэлцүүлгийн үе шатанд хэрэг бүртгэлт явуулсан хэрэгт яллагдагчаар татсан тогтоол, мөрдөн байцаалт явуулсан хэрэгт яллах дүгнэлт үншиж сонсгосноор шүүхийн хэлэлцүүлэг эхэлж, шүүгдэгчийн мэдүүлгийг сонсох, шүүх хуралдааны үед шинжилгээ хийх, эд мөрийн болон бичиг баримт, газар орон байранд үзлэг болон туршилт хийж, шүүхийн хэлэлцүүлэг дуусах гэж байгаатай холбогдуулах оролцогчдоос нэмж асуулт тавих эсэх асуудлыг шийдвэрлээд шүүхийн хэлэлцүүлгийг дуусгаж шүүмжлэлийн үе шатанд орж байна.

Ийнхүү ЭБШХ-ийн 17 дугаар зүйлд мэтгэлцэх зарчмыг тодорхойлсон хэдий ч мөн хуулийн 34 дүгээр бүлэг буюу 262 дугаар зүйлээс 278 дугаар зүйлүүдэд яллах, өмгөөлөх талуудын мэтгэлцээн явуулах журмыг нарийн зааж өгөөгүйгээс болж шүүх хурлын хэлэлцүүлэг дээр мэтгэлцээн явуулах талаар хуульчид янз бүрийн ойлголттой байна. Тухайлбал зарим хуульч ЭБШХ-ийн 262-278 дугаар зүйлдзаасан дараалал, журмынхаа дагуу шүүхийн хэлэлцүүлгийг явуулахад л аяандaa мэтгэлцээн өрнөж буй хэрэг гэж үздэг ажээ.

Яллах, өмгөөлөх талуудын хоорондын мэтгэлцээнд шүүгч, шүүх бүрэлдэхүүн оролцох ёсгүй, харин хөндлөнгийн байр суурьнаас оролцох ёстой гэдгийг хуульчид бүгд хүлээн зөвшөөрөх нь зүйтэй хэрэг.

Тэгвэл шүүхийн хэлэлцүүлэг явуулах үед шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээч нараас шүүх бүрэлдэхүүн асуулт тавьж хариулт авдаг эрх нь хуулиар олгогдсон. Энэ асуулт тавих үйл ажиллагаа нь мэтгэлцээнд шүүгч өөрөө оролцож байгаа болж харагдана. Иймээс дээрх байдлаар шүүхийн хэлэлцүүлэг явуулж байгаа үйл ажиллагаа нь хуульд заасан эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талуудын мэтгэлцээн гэж үзэхэд эргэлзээ төрүүлэхээр харагдаж байна.

Шүүхийн хэлэлцүүлэгт: яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлт уншиж шүүгдэгчийн мэдүүлгийг сонсоод асуулт хариулт явагдаж, мөн хохирогч гэрчийн мэдүүлгийг шинжээчийн дүгнэлт зэргийг сонсон асуулт хариулт явагдаад, бичгийн нотлох баримтыг уншиж сонсгож, эд мөрийн баримтад үзлэг хийж байгаа үйл ажиллагаа нь мэтгэлцээнийг явуулж байгаа үйл

ажиллагаа биш харин мэтгэлцээнийг явуулах баримт материалыа шүүх хурал дээр дэлгэн гарган ирж байгаа явдал юм. Зарим хуульчид, шүүхийн хэлэлцүүлгийг дуусгаад яллах, өмгөөлөх талуудын шүүмжлэл явуулж байгаа нь мэтгэлцээн явагдаж байгаа үйл ажиллагаа гэж үзэж байна.

Миний үзэж буйгаар дээрх үйл ажиллагаануудын аль нь ч мэтгэлцээн явагдаж байгаа хэрэг бус, харин яллах, өмгөөлөх талууд мэтгэлцээнийг явуулах баримт материалыа шүүх хурал дээр шүүх бүрэлдэхүүн, бусад оролцогч, иргэдийн төлөөлөгч, шүүгчдэд сонсгон танилцуулж, хэлэлцүүлж байгаа үйл ажиллагаа юм. Мэтгэлцээн гэдэг нь мэтгэлцэж буй талууд нэгнь нөгөөгийнхөө хэлсэн уг, хийсэн ажил, үйлдэл үйл ажиллагаа эс үйлдлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул хоорондоо өөр өөрсдийн үзэл бодол, үйл ажиллагааг үнэн зөв гэдгийг нотлох, хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор уг хэллэгээ илэрхийлэхийг хэлнэ. Мэтгэлцээн нь ирээдүйд болох үйл явдал, ажил Үүргийн үр дүн үзэл бодлын талаар ч талууд хоорондоо мэтгэлцэж болдог байна. Харин эрүүгийн шүүн таслах үйл ажиллагаан дахь яллах, өмгөөлөх талуудын хоорондын мэтгэлцээн нь:

- Гэмт хэргийн зүйлчлэл дээр мэтгэлцэх;
- Шүүгдэгчийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэл тогтоогдоогүй байгаа талаар мэтгэлцэх;
- Тухайн гэмт хэргийг шүүгдэгч үйлдээгүй талаар мэтгэлцэх;
- Шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн нь бүрэн нотлогдсоны дараа ял шийтгэл оногдуулах ёстой. Иймдэнэ хэргийг нэмэлт

- мөрдөн байцаалтад буцааж, дахин шалгаж тогтоосны дараа хэргийг эцэслэн шийдвэрлэх талаарх мэтгэлцээн;
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтуудыг зөрчиж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан нь шүүгдэгчийн хууль ёсны эрх ашгийг ноцтой зөрчиж байна. Энэ зөрчлийг засаж арилгуулсны дараа хэргийг шийдвэрлэх ёстай гэх мэтээр мэтгэлцээн явагдах ёстай.

Гэвч шүүх хуралдаан бүрт заавал мэтгэлцээн явуулах ёстай юу гэдэг асуудал гарч ирнэ. Тэгвэл шүүх хуралдаан бүр мэтгэлцээн явуулах ёстай гэж үзэж болохгүй. Өөрөөр хэлбэл мэтгэлцээнгүйгээр шүүх хуралдаан явагдаж болно.

Тухайлбал: шүүгдэгч өөрийн үйлдсэн гэмт хэргээ бүрэн хүлээн зөвшөөрч байгаа, түүний үйлдсэн гэмт хэрэг явуулсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд түүний эрх, хууль ёсны ашгийг ямар нэгэн байдлаар хохироосон зүйл байхгүй нөхцөлд яллах, өмгөөлөх талуудын хооронд ямар нэгэн мэтгэлцээн явуулахгүйгээр шүүх хуралдааны хэлэлцүүлэг явагдаж болно.

Дүгнэлт: эрүүгийн "шүүн таслах ажил"-ын практикаас үзэхэд яллах, өмгөөлөх талуудын хооронд мэтгэлцэх үйл ажиллагаа зохих ёсоороо хэрэгжихгүй байна. Ийнхүү мэтгэлцэх зарчим эрүүгийн шүүн таслах ажиллагаанд жинхэнэ ёсоор хэрэгжин биелэхгүй байгааганхаарч, ЭБШХ-ийн 34 дүгээр бүлэгт заасан шүүхийн хэлэлцүүлгийн үе шатанд буюу шүүхийн хэлэлцүүлгийг дуусгаад яллах, өмгөөлөх талуудын хоорондын мэтгэлцээний үе шатыг шүүмжлэлийн үе шат эхлэхийн урьд тодорхой заалт нэмж оруулах нь зүйтэй. Ийм заалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулаагүй нөхцөлд мэтгэлцээн явуулсангүй гэж шүүх хурал даргалагчийг буруутгах чүндэслэлгүй юм. Түүгээр ч барахгүй давах ба хяналтын шатны шүүх хуралдаан явагдах үед ч мэтгэлцээний явуулах нөхцөл, журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тодорхой тусгаж оруулах нь чухал байна.

---0о---

УСНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИХ ГЭМТ ХЭРЭГТ ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ НЬ

Дүүргийн Эрүүгийн хэргийн 1 дүгээр шүүхийн шүүгч С. Соёмбо-Эрдэнэ

1. Удиртгал

Хүн төрөлхтөн байгаль орчин, эх дэлхийтэйгээ салшгүй холбоотой, түүний бүрэлдэхүүн билээ. Байгаль орчин сүүлийн жилүүдэд доройтоож, энэ нь бидний анхаарлын төвд байна. Дэлхий нийтэд ундны усны хомдол нүүрлэсэн өнөө үед Монгол улс усны нөөцөөр баялаг боловч сүүлийн жилүүдэд хүний буруутай үйл ажиллагаанаас болж усны хомдолтой тулгарах аюул үүсэх нь тодорхой боллоо.

Ирээдүйд учирч болох энэхүү үйл явдлаас сэргийлэх нэг арга зам бол уг салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгүй болгох, хууль тогтоомжийн уялдаа холбоог бэхжүүлэх, хэрэгжилтийг хангах ажил гэж үзэж болно. Усны салбарт үйлчлэх гол хуулиудын хэрэгждэггүй заалт, хуулийн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг судлан хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт, санал өгөхийг зорьж байгааг энд хэлмээр байна.

Монгол улс усыг хэрэглэх, ашиглах, хамгаалахтай холбоотой төрөл бүрийн харилцааг хуулиар зохицуулахаас гадна, зан заншлын шинжтэй маш олон хэм хэмжээгээр зохицуулж ирсэн түүхэн уламжлалтай.

Уг харилцааг зохицуулсан дараах хууль, тогтоомжууд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Үүнд: Үндсэн хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ус рашаан ашигласны төлбөрийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ариун цэврийн тухай, Далайашиглах тухай, Хүнсний тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хувь хэмжээний тухай хууль, **Эрүүгийн хууль**, Хот суурины ус хангамж, ариутгах татварын ашиглалтын тухай, Рашааны тухай, Татварын ерөнхий хууль, Усан замын тээврийн тухай, **Усны тухай** зэрэг хуулиуд юм.

Энэхүү нийтлэлд эдгээр хуулиудыг бүгдийг судлан, уялдаа, холбоо, зөрчил, хийдэл, алдаа, дутагдлыг олох гэхээс илүүтэй Эрүүгийн хуулийн 23-р бүлэг буюу байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн зарим зүйл заалт, Усны тухай хуулийн хэрэгждэггүй зүйл, заалт, хуулийн зөрчил түүнд хүлээлгэх хариуцлагыг шинжлэх ухааны харьцуулалт, логикин аргыг ашиглан судлав.

2.Усны тухай хууль түүний үйлчлэх хүрээ

Ус, түүний сав газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдон үүсэх нийгмийн бүхий л харилцааг зохицуулах бөгөөд энэ хүрээнд усны салбарт үйл ажиллагаа явуулах төрийн байгууллагуудын эрх, үүргийн хуваарилалтыг хуульчлан тогтоосон.

Хуульд зааснаар усны асуудал эрхэлсэн байгууллагууд нь Байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд ажиллах болсон нь экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж, байгаль орчны тэнцлийг хангах хуулийн зарчмыг хэрэгжүүлж буй хэрэг юм.

Тухайлбал: Усны асуудал эрхэлсэн засгийн газрын эрх бүхий байгууллага, гол мөрний сав газрын зөвлөлийг төрийн байгууллагын тогтолцоонд суулгасан. Мөн ус ашиглалтын байдалд хяналт тавих зорилгоор ус хэрэглэгч, ус ашиглагч гэсэн эрх зүйн ойлголтыг шинээр бий болгон ус ашиглагч нь усны нөөц ашигласны төлбөрийг мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтийн дагуу төлөх тогтолцоог бий болгож, усны асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд нь мэргэжлийн дүгнэлт гаргах замаар усны нөөцийн ашиглалтад урьдчилсан хяналт тавих болсон. Усны асуудал хариусан засгийн газрын эрх бүхий байгууллага усны нөөцийн ашиглалтад мэргэжлийн дүгнэлтээр дамжуулан урьдчилсан хяналт тавих болсноор усны салбарын бүхий л үйл ажиллагаанд оролцох, төрийн бусад байгууллага, яам, агентлагуудтай усны асуудлаар харилцах эрх нь нээгдсэн.

Хуулиар тогтоосон журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх нь ямар ч нөхцөлд гарцаагүй бөгөөд зайлшгүй хэрэгжих учиртай. Усны тухай хууль зөрчсөн этгээдэд эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр заажегсэн. Ингэхлээр хуулийн заалт хэрэгжих боломж, нөхцөл, зохицуулалтын мөн чанарыг авч үзье.

1. Эрүүгийн хуулийн 23 дугаар буюу Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн бүлгийн 207.1-д Газрын хөрс, усыг бохирдуулсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Өөрөөр хэлбэл "Химиин бодис бордоог экспортлох, улсын хилээр дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах, устгах, ашиглах, тээвэрлэх журам зөрчсөн, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдаар газрын хөрс, **усыг бохирдуулж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол учруулсан** бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, З-аас 6 сар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ¹ гэж заажээ. Энэ заалттай холбоотой УДШ-ийн тайлбар хараахан гараагүй байна. Ямар ч байсан усыг бохирдуулж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол учруулах буюу ЭХ-ийн 29.1-д зааснаар "..... хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-125 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх"² хохирол, мөнгөн дүнгээр доод тал нь 9,6 сая төгрөгийн

¹Монгол улсын Эрүүгийн хууль 2002 он. УБ., 23-р булаг, 207 дугаар зүйл

² Монгол улсын Эрүүгийн хууль 2002 он. УБ., 29.1 дэх заалт. 2013.09.01-нээс 1 сард 192000 төгрөг болсон

хохирол учруулсан тохиолдолд 207.1-д заасан эрүүгийн хэрэг үүсгэж, буруутай этгээдийг торгох, баривчлах, хорих ял шийтгэх эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулсан хохирол, дээр дурдсан хэмжээнд хүрэхгүй бол эрүүгийн хэрэг үүсэхгүй. Нөгөө талаар үлээмж хэмжээний хохирол учруулахгүйгээр усыг бохирдуулаад байж болохоор байна. Түүнчлэн хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээг тогтоох тогтолцоо, механизм нэг мөр шийдэгдээгүй өнөө үед тус заалт хэрэгжих нөхцөл тун бага юм.

2. Эрүүгийн хуулийн 208.1-д “Усны тухай хууль тогтоомж зөрчих”³ гэмт хэргийг хуульчлахдаа “Усны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас ан амьтан, шувуу, загас олноор үхсэн болон бусад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь тахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” заасан. Эрүүгийн хэрэг үүсгэхэд ан амьтан, шувуу, загас олноор үхсэн эсвэл бусад их хэмжээний хохирол буюу ЭХ-ийн 29.1 дугаар зүйлд зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 125-200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, мөнгөн дүнгээр 24.0 сая төгрөгийн хохирол учирсан байх ёстой болно. 2008 оны 06 дугаар сарын 25-нд УДШ-ээс 208.1 дэх заалтыг тайлбарласан 30 дугаар тогтоол гарсан. Үүнд: “**An amьтан, шувуу, загас олноор**

үхсэн болон бусад их хэмжээний хохирол учирсан” гэдэгт үхсэн ан амьтан, шувуу, загасны экологи, эдийн засгийн нийт үнэлгээ Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд тодорхойлсон хохирлын хэмжээнд хүрсэн байхаас гадна усны болон түүний орчмын ургамал, амьтан өвчлөх, загасны нөөц хомсдох, тэдгээрийн бүтэц өөрчлөгдөх (ховор үүлдрийн загасны нөөц багасах, хортой ба хэрэглээний бус үүлдэр бий болох г.м.) намагшсан буюу хужиршсан газар үүссэн зэргийн улмаас мөн их хэмжээний хохирол учирсан байхыг ойлгоно. **Нэн ховор ан амьтан, шувуу, загас хоёр буюу түүнээс олноор үхсэнийг мөн ойлголтод хамааруулж үзнэ**⁴ гэж тайлбарласан. Энэ тайлбараас харахад нэн ховор амьтан олноороо үхсэн гэдгийг хоёроос олноор үхсэн байх, цаашлаад 208.1-д заасан хэрэг үүсгэх нөхцөл болж байна. Эрүүгийн хуулийн энэ зөрчил манай улсад цөөнгүй гардаг боловч ховор амьтан хоёроос дээш үхсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн практик, тохиолдол байдаггүй. Тэгэхээр УДШ ЭХ-ийн 208.1 дэх заалтыг механик буюу уян хатан биш, хэрэгжих боломжгүй тайлбарласан. Тэгээд ч дээрх үндэслэлээр эрүүгийн хариуцлагад татахад зохимжгүй юм.

Учир нь урсгал гол, мөрөн, нууранд ховор загас хоёроос дээш тоогоор үхсэн болгонд эрүүгийн хэрэг үүсгээд байж болохгүй, боломж ч үгүй, харьцангуй ойлголт юм.

³ Монгол улсын Эрүүгийн хууль 2002 он. УБ., 23-р бүлэг, 208 дугаар зүйл

⁴ Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Монгол улсын Дээд шүүхийн тогтоол №30. УБ., 2008.06.25

3. Эрүүгийн хуулийн 208.2-т усны тухай хууль тогтоомжийг хүндрүүлэх нөхцөлтэй зөрчсөн этгээдэд гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ⁵ гэж заажээ. Хүндрүүлэх нөхцөлд 208.1 дэх хэргийг давтан үйлдсэн, тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн, их буюу онц их хохиролучирсан байх шаардлагатай байна. УДШ-ийн 30 дугаар тогтоол ёсоор тусгай хамгаалалттай газар нутагт ховор ан, амьтан хоёр ба түүнээс олон тоогоор үхсэн нөхцөлд буруутай иргэн, аж ахуй нэгж, байгууллагын албан тушаалтан гурваас дээш таван жилийн хорих ялаар шийтгүүлэх юм. Манай улс Эрүүгийн хуулиар байгаль, эх дэлхийн үндэс болсон усаа хамгаалж байгаа нь нэг талаараа зөв санаа боловч, нөгөө талаас маш тодорхой бус, нөлөө бага, хэрэгжих үндэслэл тааруухан зохицуулалт оруулжээ. Мөн Эрүүгийн хуулиар зөвхөн хувь хүн хариуцлага хүлээхээр заасан байдаг. Гэтэл усны хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага тэдгээрийн ажилтан зөрчсөн тохиолдолд удирдлагыг /гүйцэтгэх захирал/ эрүүгийн хариуцлагад татдаг гажиг тогтолцоо байна. Хууль зүйн зарчмын үүднээс авч үзвэл аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үр дагавраас болж хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учирч байгаа тул тухайн хуулийн этгээдийн хувийн хөрөнгөөр хохирлыг барагдуулах ёстой.

⁵ Монгол улсын Эрүүгийн хуулийн 208.2 дахь заалт “Энэ хэргийг давтан, эсхүл улсын тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн, их буюу онц их хэмжээний хохирол учирсан, хүний эрүүл мэнд, амь нас хохирсон бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”

3. Усны хууль тогтоомж зөрчих гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага түүнийг боловсронгуй болгох

Улсын Иххурлаас 2004 онд Усны хуулийгшинэчлэнбаталж, нэлээдгүй шинэ төрлийн харилцаануудыг зохицуулж өгсөн бөгөөд “Хуулийн зорилт нь ус, түүний сав газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна”⁶. Улмаар 2009 оны 08 дугаар сарын 25-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хуулийн 37 дугаар зүйлд хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан. Эдгээр заалтуудыг хараад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны шийтгэлийг иргэн, эрх бүхий албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулахаар хуульчилсан.

Захиргааны шийтгэлийн хууль бусаар олсон орлого хураах, торгох гэсэн хоёр төрлийн шийтгэл ногдуулахаар хуульчилжээ. Усны хуулийн зөрчлийн шинж чанараас хамаарч иргэнийг 10000-30000 төгрөг хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөг хүртэл торгох шийтгэл ногдуулж байна. Бид ирээдүйд усны салбарaa аврах, устайгаа үлдэх нэг гарц Усны хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн этгээдэд хууль зүйн үндэслэлтэй бодитой хариуцлага хүлээлгэж байх шаардлагатай. Одоогийн хуулийн хариуцлагын тогтолцоо нь үр нөлөө багатай гэж үзэж байна. Тухайлбал: Усны тухай хуулийн 34.1-д “Усны нөөцийн сан бүхий газарт цацраг идэвхт, халдвартараах болон химийн хорт бодисын хаягдал хадгалах, устгах, хог хаягдал, бохирдуулах бодис, үйлдвэрлэлийн бохир ус хаяхыг

⁶ Усны тухай хууль 2004 он., УБ 1.1 дэх заалт

Эрүүгийн хуульд дараах өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзлээ.

1. Эрүүгийн хуулийн 207-р зүйлд “....усыг бохирдуулах” гэсэн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд. Үүнд:

- байгаль орчны эсрэг гэмт хэрэгт хуулийн этгээдийг хариуцлагад татдаг байхаар хуульчлах;

2. Эрүүгийн хуулийн 208-р зүйлд “Усны тухай хууль тогтоомж зөрчих” гэмт хэргийн “....ховор ан, амьтан олноор үхсэн” гэх нөхцөлийг тайлбарласан УДШ-ийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болгох шаардлагатай. Уг заалтыг мөн өөрчлөн найруулж хэрэгжих боломжтой зохицуулалт оруулах;

3. Эрүүгийн хуулийн өрөнхий ангид өөрчлөлт оруулах замаар Усны тухай хууль зөрчсөн аж ахуй нэгж, байгууллагыг хариуцлагад татдаг байхаар хуульчлах, өдгээр болно.

Усны тухай хуулийн хэрэгжилт, хариуцлагын үр нөлөөний хувьд зарим тодорхой бус заалтууд ажиглагдлаа. Үүнд: Хуулийн хариуцлагын тогтолцоо оновчтой бус, хэрэгждэггүй, хэрэгжих боломж бага заалт цөөнгүй байна.

Усны тухай хуулийн зөрчилд захиргааны шийтгэл ногдуулах хэлбэрүүдийг сонгож хэрэглэх боломж эрх бүхий албан тушаалтанд олгогдоогүй сул талтай юм.

Тиймээс захиргааны шийтгэлийн торгох төрлийг ганц хэрэглэх бус аж ахуйн нэгж, байгууллагын зөрчилд тусгайлан олгосон эрх хасах, татаан буулгахаар эрх бүхий байгууллагад уламжлах зэрэг шийтгэлийн төрлийг Усны тухай хуульд нэмж оруулмаар байна. Мөн торгох хариуцлагын хэлбэрийг мөнгөн дүнгээр тортодог хэлбэр цаг үеэ өнгөрөөсөн, түүний оронд аж ахуйн нэгжийн орлогынх нь хувь хэмжээгээр, Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд дүйцүүлэн тортгууль ногдуулах хэлбэрийг нэмжхуульчлах шаардлагатай. Тухайлбал: Усны тухай хууль зөрчөөд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэн, ихээхэн ашиг олдог бизнесийн байгууллага манайд цөөнгүй бид ирээдүй хойч үеэ усны гачигдалгүй байлгахын тулд дурдсан хариуцлагын энэхүү аргыг хэрэглэх цаг болсон гэж үзэж байна. Дээрх тортгуулиудын үр дунд бий болсон төвлөрсөн мөнгөн хөрөнгийг тусгай санд төвлөрүүлэн усиг хамгаалах, нөхөн сэргээх ажилд дийлэнхи хувийг зарцуулдаг байх шаардлагатай.

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН ШИЙДВЭР, ТҮҮНИЙГ ТОЙРСОН ЗАРИМ АСУУДАЛ



*Иргэний хэргийн давж заалдах шатны
3 дугаар шүүхийн шүүгч
Ц.Отгонцэцэг*

Удиртгал

Эрх зүйн актыг эрх зүйн үзэгдлийг системчлэх гол элемент гэж үздэг бөгөөд тэрээр тухайн нийгмийн эрх зүйн амьдрал буюу хууль зүйн ахуйн илэрхийлэл болж байдаг. Иргэд өдөр тутмын амьдралдаа эрх зүйн актын хэм хэмжээг мөрдөж, түүний үйлчлэлийг хүртэж байдаг бөгөөд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаж буй этгээдийн шийдвэр нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж үйлчлэх учиргүй юм.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь хуулийн дэд актын хүрээнд хамаардаг бөгөөд хуулийн дэд акт нь захиргааны хэм хэмжээ тогтоосон болон нэг бүрчилсэн шинж (төрийн шинж)-

ийг агуулдаг. Өөрөөр хэлбэл, захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг зөвхөн төрийн байгууллага батлах буюу зөвшөөрөх бөгөөд түүнийг зөрчвэл эрх зүйн үр дагавар үүсгэдэг онцлогтой. Мөн энэ төрлийн актууд бие биедээ хатуу шатлан захирагдсан, өөр хоорондоо нийцсэн байх шаардлагатай төдийгүй хуулийн зарим хэм хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор, хуульд чанд нийцэн гарсан байх ёстай.

Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт нь нэг талын шинжтэй, тодорхой бус хүрээний этгээдэд хандсан, нийтлэг харилцааг зохицуулж, давтан үйлчлэх шинжтэй байдаг¹ төдийгүй эрх зүйн хэм хэмжээг агуулсан бичгэн хэлбэр бүхий эрх бүхий төрийн байгууллагын шийдвэр² юм. Тодруулбал, төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт нь нийтээр дагаж мөрдөгдөх шинжийг агуулсдаг тул би энэхүү илтгэлээр нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож буй практикийг гадаадын зарим улсын практик, зохицуулалттай харьцуулан судалж дүгнэх, захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг гаргах журам, түүний

¹ Е.С.Шугрина. Муниципальное право Российской Федерации: учеб.-2-е изд., перераб. и доп. –М.: Проспект, 2009. С.67.

² Теория государства и права: Учебник /Под ред. М.Н.Марченко. –М.: Издательство “Зерцало”, 2005. С.591.

хэрэгжилтийн байдлыг авч үзлээ.

Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт гэдэг нь эрх зүйн ерөнхий онолын хүрээнд өргөн утгыг илэрхийлдэг. Үүнд хууль, хуулийн дэд акт (хуульчилсан акт), зарим тохиолдолд гэрээг³ ч оруулж үздэг байна.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын дээрх шинж нь түүний хуулийн адил дагаж мөрдөхөд хүргэдэг байна. Одоо ч гадаадын зарим улсад захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг хэрхэн гаргаж, үнэлж байгаа тоймлон авч үзье.

Гадаад орнуудын захиргааны хэм хэмжээ тогтоодог практик

Гадаадын зарим улсад захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг хэрхэн гаргаж, үнэлж байгаа тоймлон авч үзье.

1. Америкийн Нэгдсэн Улс. АНУ-ын Дээд шүүх 1957 онд нэгэн хэргийгшийдвэрлэхдээ/United States v Howard/ хэм хэмжээ тогтоосон захиргааны акт нь хуулийн хүчин чадалтай гэж тогтоож, захиргааны актыг зөрчих нь эрх зүйн хариуцлага хүлээх үр дагавартай⁴ гэж дүгнэсэн байна.

АНУ-д хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх зэрэг турван эрх мэдэл харьцангуй бие даасан, харилцан тэнцэлтэй байдаг.

³Е.С.Шугрина. Муниципальное право Российской Федерации: учеб.-2-е изд., перераб. и доп. –М.: Проспект, 2009. С.68. Жишээлбэл, ОХУ-д НУБ-удын хооронд байгуулсан бүрэн эрх хуваарилсан гэрээ, Олон улсын гэрээг хамруулж болно гэж үздэг.

⁴Захиргааны хэргийн шүүх: Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх, цуврал 6, УБ, 2005, 6 дахь тал

Хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэхэрхмэдлийнбайгууллагууд эрх хэмжээнийхээ дотор ажиллаж байгаа эсэхийг хянах үүрэгтэй. Хэрвээ ерөнхийлөгч эсвэл бусад гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтан хуулийн үндэслэлгүй хэм хэмжээ бүхий захиргааны акт гаргавал Конгрессын гишүүд түүнийг хуулиар олгосон эрх мэдлээ хэтрүүлсэн гэж үзэн холбогдох актыг хүчингүй болгохыг шаардах эрхтэй байна. АНУ-ын Дээд шүүх хэд хэдэн удаагийн шийдвэртээ хэм хэмжээ бүхий захиргааны актыг зөвхөн тухайн захиргааны байгууллагынээр үүрэгтэй холбоотой хуульд тодорхой заасан эрх хэмжээнд гаргасан бол Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзнэ гэсэн байдал.

Захиргааны акт нь захиргааны байгууллагаас хэм хэмжээ тогтох байгаа явдал бөгөөд энэ утгаараа захиргааны бусад актаас ялгаатай. Хэм хэмжээ бүхий захиргааны актыг шүүхтэй төсөөтэй байгууллага болон шүүхээр хянадаггүй⁵. Энэ актыг гаргах явцад захиргааны байгууллага иргэн хоорондын харилцаанд албан ба албан бусаар мөрддөг хэд хэдэн зарчим байдаг. Үүнд:

- Гомдол гаргах эрх боломж олгох;
- Захиргааны акт гаргах гэж буй тухай мэдээлэх;
- Захиргааны байгууллагын мэдээ сэлтэд иргэд чөлөөтэй нэвтрэх бололцоо олгох;
- Иргэдэд зөвлөгөө өгөх, зөвлөх хуралдаан зохион байгуулах, хуралдааныг нээлттэй хийх;

⁵Захиргааны хэргийн шүүх: Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх, цуврал 6, УБ, 2005, 6 дахь тал

- Захиргааны актыг бүртгэх, хэвлэн нийтлэх;
- Захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлэх зэрэг болно.

Тус улсад захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаж буй этгээд нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын дэргэд байгуулагдсан, тэдгээрээс шууд хяналт тавьдаг зэргээс үл хамаарч гүйцэтгэх эрх мэдлийг хангах зорилгоор тухайн актыг гаргадаг. Хэм хэмжээний актын хувьд гаргаж буй субъектийг онцлог зохицуулалтаар нь ялгалгүй хэм хэмжээний актын нийтлэг зорилгоор нь авч үздэг хандлага байжээ. Хууль тогтоох байгууллагаас байгуулсан этгээдийг эрх зүйн байдлын хувьд хууль тогтоогчид хамааруулж үздэггүй. Харин зорилгын хувьд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүрэг бүхий байгууллагыг хууль тогтоогч дэргэдээ байгуулдаг практик өргөн дэлгэрсэн. Энэ нь хууль тогтоогчийн дэргэд, эсхүл түүний байгуулсан байгууллага нь хууль тогтоогчийн эрх мэдлийг эдэлнэ гэсэн ойлголт биш юм.

2. Бүгд найрамдах

Солонгос улс. БНСУ-д үйл ажиллагаа нь ард түмний шууд оролцооноос ангид, хязгаарлагдсан байдлаар хэрэгжүүлдэг байгууллага нь хэм хэмжээний акт батлан гаргах, бүртгэлд оруулах, нийтийн хүртээл болгох тусгай зохицуулалттай байдаг. Тухайлбал, БНСУ-ын 1997 оны Захиргааны хэм хэмжээний тухай үндсэн актын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх хэсгийн заалтаар энэ төрлийн актыг Сонгуулийн хороо, Хяналт, шалгалтын зөвлөлийн шийдвэрт хамаарахгүй байхаар

хуульчилжээ⁶.

3. Казакстан улс. Ромгерманы эрх зүйн тогтолцоотой ихэнх улсад, жишээлбэл Казахстан улсад хэм хэмжээ тогтооход нийтлэг журам үйлчлэх боловч бүртгэлийн тусдаа тогтолцоотой байдаг ажээ. Тухайлбал, 1998 оны Казахстаны Эрх зүйн хэм хэмжээний актын тухай хуульд хамаарах этгээдэд Сонгуулийн төв комиссыг багтаасан байна.

4. Украян улс. Украян улсад хэм хэмжээ тогтооход нийтлэг журам мөрдөх боловч бүртгэлийн хувьд зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын шийдвэрийг хамааруулдаг байна. Тухайлбал, Украян улсын:

- Ерөнхийлөгчийн 1992 оны 492 дугаар зарлигаар Яам болон бусад гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хэм хэмжээний актыг улсын бүртгэлд бүртгэх тухай журам;
- Сайд нарын зөвлөлийн 2001 оны 376 дугаар тогтоолоор баталсан Эрх зүйн хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийг хөтлөх болон бүртгэлийг ашиглах журам;
- Хууль зүйн сайдын 2005 оны 34/5 тушаалаар Эрх зүйн хэм хэмжээний актыг Улсын бүртгэлд бүртгүүлэх журам.

⁶Эрх зүйн судалгааны төв. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын хэрэгжилт судалгааны ажлын тайлан

5. Оросын Холбооны Улс.

ОХУ-ын Засгийн газрын 1997 оны 1009 дүгээр тогтоолоор "Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн хэм хэмжээний актыг бэлтгэх болон улсын бүртгэл хөтлөх тухай" баталсан.

Дээр дурдсан улсуудын тухайд захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай зэрэгцээ эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт гэдгийг хуульд үндэслэн түүнийг хэрэгжүүлэх зорилгоор хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын эрх хэмжээний хүрээнд гаргасан шийдвэр, аж ахуйн удирдлага, хяналтын байгууллагын болон хүний эрх, эрх чөлөөг хөндсөн шийдвэрийг ойлгохоор хуульчилжээ.

Монгол Улсад захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт гаргаж, үнэлж байгаа өнөөгийн практик

Монгол Улсын тухайд зарим судлаачдын үзэж буйгаар "хэм хэмжээний актад Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүд, түүнчлэн хууль зүйн үндэслэл бүхий гадагш чиглэсэн заалт агуулсан захиргааны дотоод журмыг хамааруулдаг ба энэ төрлийн хэм хэмжээний акт батлахад бусад /төрийн захиргааны байгууллагаас гаргадаг/ хэм хэмжээний акттай нэгэнадилхуулиар заавал тусгайллан эрх олгосон байхыг шаарддаггүй... Гэхдээ улсын бүртгэлд бүртгүүлэхгүй байгаа нь алдаатай"⁷ гэж үзэх нь бий.

⁷П.Одгэрэл. Хэм хэмжээний акт: Нийтээр дагаж мөрдөх шийдвэр. Гарын авлага. Уб, 2009. 15, 19 дэх тал

Иймд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас гаргаж буй захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр улсын бүртгэлд бүртгэгдэх бүрэн үндэстэй байна. Харин энд анхаарах ёстой нэг асуудал бол ийнхүү бүртгүүлэх асуудлыг Засгийн газрын тогтоолоор журамласан явдал юм.

Хууль тогтоох эрх мэдлийн байгууллага бол зөвхөн УИХ бөгөөд шүүх эрх мэдлийн байгууллагад хуулийн дагуу байгуулгасан шүүх хамаарна. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд прокурор, өмгөөлөл гэх мэт байгууллага, албан тушаалтан оролцдог бол төрийн байгууллага, албан тушаалтны үлдэх хэсэг нь бүхэлдээ гүйцэтгэх эрх мэдэлд хамаарч болно. Ингэж үзвэл хэдийгээр УИХ-аас байгуулагддаг, Засгийн газраас хараат бус шинжтэй, субъектууд нь мөн чанараараа гүйцэтгэх эрх мэдэлд хамаарна. Жишээлбэл, АНУ-д хараат бус агентлаг, Төв банк зэрэг субъектийг гүйцэтгэх эрх мэдэлд хамааруулан үздэг⁸. Энэ утгаар онцлог зохицуулалтад хамаарах субъектээс гаргаж буй захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын шийдвэр⁹ мөн тул захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоож байна.

⁸Д.Галлиган, В.В.Полянский, Ю.Н. Старилов. Административное право: история развития и основные современные концепции. –М.: Юристъ, 2002. С.245.

⁹ Монгол Улсад 2002 онд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлан гаргаснаар "захиргааны байгууллага" хэмээх ойлголтыг хуульчилсан. Түүнчлэн энэ хуулиар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь захиргааны актад хамаарна гэж үзэх болсноор Монгол Улсад тус ойлголтын хүрээ зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаар хязгаарлагдахаа больсон. Иймээс бидний хувьд захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр гэж үзэх боломжтой юм.

Яагаад гэвэл Монгол улсын Засгийн газрын 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 119 дүгээр тогтоолоор Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмыг шинэчлэн баталжээ.

Энэ нь нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах журам бөгөөд нийт иргэд, олон нийттэй хамаатай аливаа шийдвэр гаргахдаа яам агентлаг, ИТХ, засаг дарга нар тухайн шийдвэртэй холбоотой этгээдүүдийн саналыг авах, хуульд нийцсэн байх, бусад шийдвэр журмуудтай зэрчилдэхгүй байх, шийдвэрийн талаарх нөлөөллийн шинжилгээхийх, шийдвэрийн талаар хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавьж санал авах гэх мэт олон чухал асуудлыг зохицуулсны зэрэгцээ тус журмын 1.3 дахь хэсгийн заалтаар “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд гаргах” тухай зохицуулсан байна.

Хууль тогтоогч нийгмийн тодорхой харилцааг тухайн хуулиар нэг мэр зохицуулах боломжгүй, эсхүл зарим харилцааг хуулиар зохицуулах шаардлагагүй гэж үзвэл хэм хэмжээ тогтоох эрхийг эрх бүхий этгээдэд шилжүүлдэг байна. Гэтэл өнөөдөр эрх бүхий этгээд зарим шийдвэрээ ерөнхий эрх хэмжээний хүрээнд, эсхүл ямар ч эрх хэмжээ олгоогүй байхад гаргаж байгаа нь өнөөдөр практикт маргаантай байдлыг үүсгэж байна¹⁰. Тухайлбал, “Эрх зүйн судалгааны төв” ТББ-аас гүйцэтгэсэн “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын хэрэгжилт”

судалгааны явцад хуулиар тусгайлан эрх олгоогүй ч тухайн харилцааг зайлшгүй зохицуулах шаардлагын үүднээс зарим байгууллага, тус байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаж буй байдалд үндэслэн шалтгааны тодруулах зорилгоор анкетийн судалгаагаар “*тухайн байгууллага тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар шийдвэр гаргах асуудалтай тулгардаг эсэх*”-ийг тодруулахад судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь тухайн харилцааг зохицуулах шаардлага, хэрэгцээ гардаг болохыг¹¹, мөн байнга шинэчлэгдсэн мэдээллийг цэгцэлж албан ёсоор хүртээмжтэй байгах, шийдвэрийн төслийг боловсруулахдаа аль болох шийдвэрт нийцүүлэхийг эрхэмлэдэг ч эрх зүйн үзүүлэдэг орох бүрт дахин өөрчлөх нь хүндрэлтэйгээс гадна салбарын хуулиар тусгайлан эрх олгосгүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргадаг бэрхшээл гардаг болохыг тодорхойлсон байна. Ийнхүү тодорхойлох болсон үндэслэлээ дараах байдлаар тайлбарласан байна.

УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагааны улмаас бэрхшээл учирдаг. Бөгөөдэнэнь хууль тогтоогч нийгмийн тодорхой харилцааг хуулиар бүхэлд нь зохицуулдаггүй, зохицуулах боломжгүй, эрх бүхий байгууллагад захиргааны хэм хэмжээ тогтоох эрхийг тусгайлан олгох зохицуулалтыг хуульд нарийвчлан заагаагүй, хуулиар ХЗДХЯ-нд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр /шийдвэрийн эрх зүйн үндэслэл, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой

¹⁰ Эрх зүйн судалгааны төвийн гүйцэтгэсэн “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын хэрэгжилт” судалгааны тайлан

¹¹ Хуульчамжтэйчүүдийнхолбооны Дундговьаймаг дахь салбар зөвлөлийн гүйцэтгэсэн “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын хэрэгжилт-орон нутагт” судалгааны тайлан

нийцэж буй эсэх/-ийг хянах эрх хэмжээ олгоогүй атال журмаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгэх эрх олгосноос ХЗДХЯ энэ төрлийн шийдвэр гаргадаг байгууллагудын бүрэн эрхэд халдах хандлагатай болсон байна. Тодруулбал, тэдгээр байгууллагын шийдвэрийг Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэхгүй, хуулиар тусгайлан эрх олгоогүй бол өөрөө, эсхүл дээд шатны байгууллага, эсхүл шүүхийн журмаар тухайн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох онолын үндэслэл гэжээ.

Дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийж үзвэл Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамд заасан буюу ХЗДХЯ-нд хуулиар олгоогүй эрхийг зохицуулсан журмын дээрх зохицуулалтыг хүчингүй болгож, харин Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэхгүй буюу хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад гаргасан шийдвэрийг шийдвэр гаргагч өөрөө, эсхүл дээд шатны байгууллага болон шүүхийн журмаар хүчингүй болгох зохицуулалтыг тодорхой тусгах замаар хууль, журмыг боловсронгүй болгох, ингэхдээ захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгэх тогтолцоог ХЗДХЯ-нд үлдээж, харин хянах механизмыг тухайн байгууллага тус бүр дээр хадгалж, тухайн байгууллагын хууль зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн буюу нэгж хяналтыг хэрэгжүүлдэг байхаар зохицуулах нь зүйтэй юм.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрт нийцсэн байх шаардлагыг хангахад

хүндрэлтэй байдаг. Учир нь хууль тогтоомжид нийцүүлэх нийцлийг шалган тогтоох асуудлын хувьд арга зүй, тусгай ур чадвар хэрэгтэй, эх сурвалжийг олох хүндрэл гардаг болохыг судалгаанд оролцогч аймаг сумдын териин албан тушаалтан (байгууллага агентлагын дарга) нар хариулсан байна. Судалгааны баг асуулгын дүнд үндэслэн “журмын дээрх заалтыг хэрэгжүүлэхэд тухайн шийдвэрийг гаргадаг болон хянадаг эрх бүхий этгээдийн эрх зүйн мэдлэг, тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, шийдвэрийг гаргах, хянах эрх бүхий байгууллага албан тушаалтны харилцан хамтын ажиллагаа зэрэг нөхцөл байдлууд нөлөөлдөг” гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмаар сумын Засаг дарга болон ИТХ-ын тэргүүлэгчдийг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрх бүхий субъектээр тодорхойлсон байх бөгөөд тус эрх бүхий байгууллага, албан тушаалтууд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цөөнгүй гаргадаг байна. Гэтэл тухайн шийдвэрийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тохиолдол огт гараагүй бөгөөд энэ нь сумын засаг дарга болон ИТХТ-д дээрх эрх хэмжээг хуулиар олгоогүйтэй холбоотой байна. Тодруулбал, сумын засаг даргын гаргасан Архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглох тухай захирамж нь захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр мөн боловч Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хууль болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, бусад салбар хуулиар тухайн

шийдвэрийг гаргах эрхийг дээр дурдсан байгууллага, албан тушаалтанд олгоогүй учраас ХЗДХЯ сумын засаг даргын захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бургажээс татгалзсан байна.

Тэгэхээр дээрх нөхцөл байдалд үндэслэн эрх бүхий байгууллагад захиргааны хэм хэмжээ тогтоох эрхийг тусгайлан олгох зохицуулалтыг хуульд нарийвчлан заах, эсхүл журмын сумын засаг даргад захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрх олгосон хэм хэмжээг дээр дурдсан хуулийн хэм хэмжээтэй нийцүүлэх шаардлагатай юм.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамд олон нийттэй холбоотой аливаа шийдвэрийг гаргахдаа тухайн шийдвэртэй холбоотой этгээдүүдийн саналыг авах, шийдвэрийн төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх ажиллагаа явуулах, хэл найруулга нь товч тодорхой, монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу хоёрдмол утгагүй, ойлгоход хялбар байдлаар бичигдсэн, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт заасан баримт бичиг зохион бүрдүүлэх шаардлагыг хангасан байх гэсэн олон чухал асуудлууд тусгагдсан байдаг. Орон нутагт журмын тус хэм хэмжээ хангалттай хэрэгжихгүй байгаа талаар судалгааны баг хийсэн дүгнэлтээ “Сумдад өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл дутмаг, цахим орчин тогтвржоогүй, иргэд болон албан тушаалтнуудын мэдлэг, мэдээлэл хангалтгүй”¹², зэрэг хүчин зүйлтэй холбож тайлбарласан байна.

Дүгнэлтийн оронд

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь хуулиар зохицуулаагүй харилцааг нөхөн зохицуулдгаараа иргэд, хуулийн этгээд нийгмийн харилцаанд оролцоход нь баримтлах хэм хэмжээ болдог. Гэтэл хэм хэмжээ тогтоох эрх бүхий этгээдүүд Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамыг баримтлахгүй байх нь хууль зүйн сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тухайлбал, Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг “Хууль зүйн мэдээлэл” сэргүүлд нийтэлснээр хүчин төгөлдөр болдог ба нийтлэгдээгүй шийдвэр хүчингүй болох, эрх зүйн ач холбогдоо алдах зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэдэг байна.

Иймээс Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын хэм хэмжээг хуулийн хэм хэмжээтэй нийцүүлэх, улмаар орон нутаг дахь захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тус шийдвэрийг гаргах журмын талаар цогц, нэгдсэн ойлголт өгөх арта хэмжээ зохион байгуулах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна. Уг саналыг хэрэгжүүлснээр нийтээр дагаж мөрдөх, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт хууль зүйн үндэслэл бүхий гарах, ингэснээр нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхгүй байх ач холбогдолтой юм.

---00---

¹²ХуульчэмэгтэйчүүдийнхолбооныДундговьаймаг дахь салбар зөвлөлийн гүйцэтгэсэн“Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын хэрэгжилт-орон нутагт” судалгааны тайлан, 6 дахь тал

2013 ОНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ (2013 оны улсын дүн)

ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн социологич, судлаач
Б.Доржлагма

Удиртгал

Цагдаагийн ерөнхий газраас эрхлэн гаргасан “2013 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик” мэдээнд тулгуурлан дүн шинжилгээ хийлзэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудал аливаа улс орны өмнө тулгамдсан асуудал мөн бөгөөд дэлхийн улсууд өөр өөрийн арга хандлага, туршлагаар энэ асуудалд ханддаг. Монгол улсын хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл,

арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-аар зохицуулдаг.

Улсын хэмжээнд гарч буй гэмт хэргийн мэдээнд дүн шинжилгээхийх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ач холбогдолтой асуудал юм. Иймд гэмт хэргийн одоогийн нэхцэл байдлын талаар дүгнэлт өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга барилыг сайжруулах талаар нийслэл болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж болох шинэ санал санаачилгыг тодорхойлохыг зорьлоо.

1. Гэмт хэргийн тоо, өсөлт бууралт:

Зураг 1



Улсын хэмжээнд 2010-2013 онд 86473 гэмт хэрэг бүртгэгдсэнээс Нийслэлд 49965, орон нутагт 35668 хэрэг бүртгэгдсэн байна. 2010-2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 41,2% орон нутагт бүртгэгдсэн бол 57,7% нь нийслэлд бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн гаралт 2010-2011 онуудад 3,2%-иар буурсан бол 2012 онд 15,1%-иар, 2013 онд 14,8%-иар тус тус өссөн байна.

2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн дийлэнх буюу 60.7% нийслэлд, 38.4% орон нутагт, бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оноос орон нутагт 25.3%, нийслэлд 19.4% өссөн байна. Гэмт хэргийн гаралт нийслэлд өндөр хувьтай байгаа нь сүүлийн жилүүдэд хотруу чиглэсэн шилжих хөдөлгөөн ихэссэн болон хүн амын нягтшил, төвлөрөлтэй холбоотойгоор бий болж байна.

Хүснэгт 1

	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Хүн амд зэлэх хувийн жингээр,		Хүн амд зэлэх хувь
		Улсын дүн	Хүн амын тоо ¹	
Улсын дүн	25362	2,867,744	0,8	
Баруун бүс	1538	361,000	0,4	
Хангайн бүс	2912	530,193	0,5	
Төвийн бүс	3798	467,034	0,8	
Зүүн бүс	1492	191,387	0,7	
Улаанбаатар	15149	1,318,130	1,1	
Баянгол	2521	192,615	1,3	
Баянзүрх	3742	294,908	1,2	
Сүхбаатар	2416	132,117	1,3	
Сонгинохайрхан	2778	261,917	1	
Хан-Уул	1236	127,477	0,9	
Чингэлтэй	2115	153,933	1,3	
Багануур	278	27,440	1	
Багахангай	31	3,691	0,8	
Налайх	302	32,893	0,9	

Хөдөө орон нутгуудад гэмт хэргийн гаралт хүн амын тооноос үл хамааран хүн амд зэлэх хувийн жин 1%-иас доош байна. Нийслэлд энэ үзүүлэлт Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 1,8%-д хүрсэн байна.

Зураг 2



Дээрх зурагт нийслэлд гэмт хэргийн бууралт байхгүй, харин сүүлийн 2 жилийн хугацаанд гэмт хэргийн гаралт тасралтгүй өссөн үзүүлэлт харагдаж байна.


Гэмт хэрэг гаралтаар 2013 онд өмнөх оноос хамгийн их өсөлттэй дүүрэг, тоогоор:

Баянзүрх -3742 ;

Сонгинохайрхан -2778 ;

Баянгол -2521 тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 3



Нийслэлийн хэмжээнд 2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 56,8%-ийг Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргүүдэд гарсан хэргүүд эзэлж байна. Үүнээс: ХУЛГАЙЛАХ/145/32.1%, ББМБГУ/96-100/-26.4%, Танхайрах/181/-10.4%. Бусад -8.7% хэргүүд өндөр хувьтай үйлдэгдсэн байна.

Зураг 4



Дээрх зурагт орон нутагт гэмт хэргийн бууралт байхгүй, гэмт хэргийн гаралт тасралтгүй өссөн үзүүлэлт харагдаж байна.

Гэмт хэрэг гаралтаар 2013 онд өмнөх жилээс хамгийн өндөр өсөлттэй 3 аймгийг хувиар харуулвал:

- Сүхбаатар – 50,7% ;
- Дундговь – 41,3% ;
- Ховд – 35,1%-иар өссөн байна.


Хамгийн их бууралттай байгаа 3 аймгийг харуулвал:

- Хэнтий -32% ;
- Баян-Өлгий -25,3% ;
- Завхан-15,3%-иар, Өвөрхангай -4,8% Дорноговь -4,0% Сэлэнгэ - 3,6%-иар аймгууд бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн гаралт хамгийн өндөртэй 3 аймгийг бүртгэгдсэн гэмт хэргийн тоогоор харуулвал:

- Төв - 922 ;
- Дархан-Уул -754 ;
- Дорнод -751 ;


Зураг 5



Орон нутгийн хэмжээнд 2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 24.9%-ийг Төв, Дархан-Уул, Дорнод аймгуудад гарсан хэргүүд зээлж байна. Үүнээс: ХУЛГАЙЛАХ /145/ 36%, ББМБГУ /96-100/ -28.2%, ТХХАБАЖЭ /215-225/ болон Бусад төрлийн хэргүүд 21.6% буюу өндөр хувьтай үйлдэгдсэн байна.


2. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл;

Зураг 6



2013 онд өмнөх оноос хөнгөн гэмт хэрэг 20.9%-иар, хүндэвтэр гэмт хэрэг 14.7%-иар ӨССӨН бол хүнд гэмт хэрэг -7.7%-иар, онц хүнд гэмт хэрэг -12.7%-иар БУУРСАН байна.

Зураг 7



Улсын хэмжээнд 25362 хэрэг бүртгэгдсэнээс ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ 45%, НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ, ТХХАБАЖЫН эсрэг гэмт хэргүүд 42%-ийг эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нарийвчлан үзүүлвэл:


Хүснэгт 2

Гэмт хэргийн төрөл, өсөлт бууралт хувиар, Улсын дүн, 2012-2013 он			Өсөлт бууралтын хувь
	2012	2013	
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг 91-107	7155	8156	14
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг 108-113	46	55	19.6
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг 114-129	405	425	4.9
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг 130-144	126	124	-1.6
Өмчлөх эрхийн эсрэг 145-155	9023	11118	23.2
Аж ахуйн эсрэг 156-176	185	234	26.5
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг 177-191	1749	1894	8.3
Хүн амын эрүүл мэндийн эсрэг 192-201	295	318	7.8
ТХХАБАЖЫН эсрэг 215-225	1999	2148	7.5
Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 226-229			
Захиргааны журмын эсрэг 230-244	332	278	-16.3
Шүүн таслах ажиллагааны эсрэг 245-262	100	104	4
Албан тушаалын эсрэг 263-273	110	106	-3.6
Бүгд	22089	25362	14.8

Тодорхой төрлийн гэмт хэргүүд дээр 2013 онд 2012 оноос өсөлт, бууралт ажиглагдаж байна. Тухайлбал ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ 145-155 23.2%-иар, АЖ АХУЙН ЭСРЭГ 156-176 26.5%-иар, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, АЛДАР ХҮНД, НЭР ТӨРИЙН ЭСРЭГ 108-113 19.6%-иар ӨССӨН бол ЗАХИРГААНЫ ЖУРМЫН ЭСРЭГ 230-244 -16.3%-иар, АЛБАН ТУШААЛЫН 263-273 -3.6%-иар БУУРСАН байна.

3. Шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нийгмийн байдал

Зураг 8



2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 36.8% Б.Э, 25.1% ял, 2013 онд 43% Б.Э, 20.7% ялласан байна. Бүртгэгдэх үедээ эзэнтэй байсан хэрэг

34%-иар өссөн ч ялласан байдал 2012 оноос 4.4%-иар БУУРСАН нь гэмт хэргийн гаралт өмнөх оноос 14.8%-иар өссөнтэй харьцуулахад гэмт хэргийн илрүүлэлт бага байна.

Зураг 9




Сүүлийн 2 жилийн дүнгээс харахад мансуурсан үед үйлдсэн болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас гардаг хэргийн гаралт өндөр хувиар буурсан байна. Харин согтуугаар үйлдсэн болон эмэгтэй хүн оролцсон хэргүүд өндөр өсөлттэй байна. 2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 25.2%-ийг согтуугаар үйлдсэн хэрэг эзэлж байна.

Зураг 10



2013 онд эрүүгийн хуулийн 36.1-р зүйлд заасан байдалд хамаагдсан хэргийн 97.1%-ийг бүлэглэн гүйцэтгэсэн, 2.4%-ийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, 0.4%-ийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол гэмт бүлэглэл үйлдсэн хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй байна.


Зураг 11



2012 онд 1248 буюу нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 5.6% нь насанд хүрээгүй байсан. 2013 онд гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 1222 нь 18 нас хүрээгүй буюу ХҮҮХЭД байна. Энэ нь нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 4.8% болж байна. Энэ нь өмнөх оноос 26 хүүхэд буюу 2,1%-иар БУУРСАН байна.

18-29 насны хүмүүс дийлэнх буюу 40.8%-ийг эзэлж, 40 хүртэлх насны хүмүүс 69.7% байна. Мөн нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 12,3% эмэгтэй байна. Энэ нь 2012 оноос тоогоор 470, хувиар 17.6% хүртэл өссөн байна.

Зураг 12



2012 онд нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 47% ажилгүй байсан бол 2013 онд энэ үзүүлэлт 51% болж өмнөх оноос 8.8%-иар өссөн байна. 2013 оны хагас жилийн байдлаар гэмт хэрэгт холбогдогчдын 53%-ийг ажилгүй хүмүүс эзэлж байсан байна. Гэмт хэрэг үйлдэгчдийн нийгмийн байдлын өсөлт, бууралтыг өмнөх оноос тооцож үзвэл:

Зураг 13



Сургууль завсадсан хүүхэд -4.8%-иар, хугацаат цэргийн алба хаагч -6.3%-иар хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч -2.9%-иар гэмт хэрэгт холбогдох нь буурсан бол бусад буюу хувиараа хедөлмөр эрхлэгч 46.8%-иар, төрийн бус байгууллагын ажилтан 42.4%-иар, төрийн албан хаагч 15.3%-иар, оюутан 15%-иар, тэнэмэл 8.9%-иар, ажилгүй 8.8%-иар ӨССӨН байна. Гэмт хэрэг үйлдэгчийн боловсролын түвшинг үзвэл:

Зураг 14




2013 оны хагас жилийн байдлаар нийт хэрэг үйлдсэн 10597 хүний 80% буюу 8478 хүн бүрэн дунд хүртэлх боловсролтой байсан бол 2013 онд хэрэг үйлдсэн 25362 хүний 67.1% буюу 16872 хүн бүрэн дунд хүртэлх боловсролтой байна.

Зураг 15



2013 онд ажлын өдрүүдэд гэмт хэрэг гаралт ижил түвшинд буюу 15-16%-тай бүртгэгдсэн бол амралтын өдрүүд дэх гэмт хэргийн гаралт 12%-тай байна.

Зураг 16




Шёнийн цагаар буюу 22-06 цагийн хооронд 2013 онд гарсан нийт гэмт хэргийн 9884 буюу 38.9% нь үйлдэгдсэн байна.

Зураг 17



2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн дийлэнх буюу 57% нь гэр орон сууц, олон нийтийн газар болон бусад газарт үйлдэгджээ. Хагас жилд бүртгэгдсэн гэмт хэргийн 65% нь гэр орон сууц, олон нийтийн газар, гудамж талбайд үйлдэгдэж байжээ. Гэмт хэрэг үйлдэгдсэн газрын өсөлт, бүуралтыг өмнөх оноос тооцож үзүүл:

Зураг 18



Гэмт хэрэг үйлдэгдсэн газар өмнөх оноос хамгийн их өсөлттэй нь гудамж талбай 42.5% байгаа бол бууралттай нь нийтийн тээвэр -6.2% байна. Гудамж талбайд үйлдэгдсэн 5363 гэмт хэргийн дийлэнх буюу 70%-ийг гэр болон орон сууцны хорооллын гудамжинд үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна.

Дүгнэлт

Гэмт хэрэг, захиргааны зөрчлийг арилгах, түүнийг бууруулах арга замыг тодорхойлох гэдэг нь цаг хугацаа, судалгаа, шинжилгээ төсөв, мөнгө шаардсан асуудал юм.

Улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг багасгах хүрээнд тухайн дүүрэг, орон нутаг бүр зохион байгуулалттай үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ч нүдэнд харагдахуйц үр дүн өгөлгүй жил бүрийн статистик мэдээнд зарим төрлийн гэмт хэрэг гаралт тасралтгүй өссөн дүнтэй байна.

Энэ нь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг тогтоох, түүнтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлээр цагдаагийн байгууллага төдийгүй иргэд, олон нийт, аж ахуй нэгж, бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, хууль зүйн туслаалцаа дэмжлэг харилцан үзүүлж ажиллах шаардлага тулгарсныг харуулж байна. Судалгааны хүрээнд улсын хэмжээнд 2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээг үндэслэн шинжилгээ хийв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд, судалгаа шинжилгээний үндсэн дээр тодорхой ўе шаттайгаар, оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. ГЭМТ ХЭРГИЙН ӨСӨЛТ, БАЙРШИЛ

1.1. Улсын хэмжээнд 2013 онд 25362 гэмт хэрэг бүртгэгдсэнээс

Нийслэлд 15419 буюу 60.7%, орон нутагт 9740 буюу 38.4 хувийг эзэлж байна.

Гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үеэс орон нутагт 25.3%-иар, нийслэлд 19.4%-иар өссөн байна. Гэмт хэргийн гаралт нийслэлд өндөр хувьтай байгаа нь сүүлийн жилүүдэд хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ихэссэн болон хүн амын нягтшил, төвлөрөлтэй холбоотойгоор бий болж байна. Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэг гаралтаар хамгийн өндөр байгаа дүүргүүдийг нарийвчлан авч үзвэл:

Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт гэмт хэрэг хамгийн ихээрүйлдэгдсэнбайна. Тусдүүргүүд хотын зүүн болон баруун захаар байрладаг, газар нутгийн хэмжээ том, хүн амын тоогоор нийслэлд эхний гуравт ордог. Мөн олон тооны үйлдвэрлэл үйлчилгээний газрууд байрладаг. Тухайн дүүргүүдэд гэмт хэргийн гаралт өссөн нь дараах шалтгаант нөхцөлүүдтэй холбоотой гэж үзсэн. Үүнд:

- Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг нь нийслэлийн баруун, зүүн захад байрладаг учир цагдаагийн байгууллагын хяналт, үйл ажиллагааны хүртээмж хангалтгүй байдаг;

- Баянгол дүүргийн зарим хороод Сонгинохайрхан дүүргийн замын урд тал буюу Саппорогоос 5 шархүртэлхгазрыг хамран байрладаг учир цагдаагийн байгууллагын хяналт, үйл ажиллагааны хүртээмж мөн хүрдэггүй;

- Захуудын гэрээт цагдаа нарыг татан буулгаснаар гэмт хэрэг өсөх хандлагатай болсон;
- "ТЭХ", "Гурвалжин", "Хархорин", Нарантуул, Да хүрээ, зэрэг худалдааны томоохон захууд байрладаг;
- Төмөр зам, суудлын вагон депо, вокзал орчимд олон нийт, явуулын иргэд ихээр цуглардаг;
- Баянгол дүүрэгт олон нийтийн газар, шөнийн клуб, үйлдвэрлэл үйлчилгээний газар олноор байрладаг;
- Камер, гэрэлтүүлгийн тоо бага байдаг;
- Хүн амын нягтшил их. Тухайлбал: хүн амын тоогоор Баянгол дүүрэг 192,615 буюу Нийслэлийн нийт хүн амын 15.6%, Баянзүрх 294,908 буюу 22.3%, Сонгинохайрхан дүүрэг 261,917 буюу 19.8%-ийг эзэлдэг.

1.2. Гэмт хэрэг гаралтаар 2013 онд өмнөх жилээс хамгийн өндөр өсөлттэй 3 аймагт Сүхбаатар – 50,7%, Дундговь – 41,3%, Ховд – 35,1%-иар ӨССӨН бол Хэнтий -32%, Баян-Өлгий - 25.3%, Завхан -15,3%-иар хамгийн их БУУРСАН байна.

Гэмт хэргийн гаралт хамгийн өндөртэй 3 аймгийг бүртгэгдсэн гэмт хэргийн тоогоор харуулвал:

- Төв - 922 ;
- Дархан-Уул -754 ;
- Дорнод -751 ;

Орон нутгийн хэмжээнд 2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 24.9%-ийг Төв, Дархан-Уул, Дорнод аймгуудад гарсан хэргүүд эзэлж байна. Үүнээс: ХУЛГАЙЛАХ /145/ 36%, ББМБГУ /96-100/ -28.2%, ТХХАБАЖЭ /215-225/ болон Бусад

төрлийн хэргүүд 21.6% буюу өндөр хувьтай үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг гаралтыг бүсээр авч үзвэл Баруун бүсэд 1538 хэрэг бүртгэгдэж өмнөх оноос -1.9%-иар буурсан бол Хангайн бүсэд 2912 хэрэг бүртгэгдэж 10%-иар, Төвийн бүсэд 3798 хэрэг бүртгэгдэж 11.8%-иар, Зүүн бүсэд 1492 хэрэг бүртгэгдэж 5.4%-иар тус тус өссөн байна. Хангайн болон Төвийн бүсийн гэмт хэргийн гаралт орон нутагт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 69%-ийг эзэлж байна.

Иймд тус дүүрэг болон аймгуудад цагдаагийн байгууллаын үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, хяналтын цэгийг оновчтой байршуулах, иргэдэд гэмт хэргээс өөрсдийгээ хамгаалахад тэдний сонор сээрэмж, анхаарал болгоомж, үүрэг хариуцлагаа ухамсарласан байдал онцгой чухал ач холбогдолтойг ухуулан таниулж, аюулд өөрийн хайхрамжгүй байдлаас болж өртөхгүй байх талаар анхааруулан сээрэмжлүүлэг өгч байх ажлыг бүх талууд (аж ахуй нэгжүүд, иргэд, олон нийт, төрийн байгууллагууд) хамтран ажиллах хүрээнд хэрэгжүүлэх нь гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

2. ЯМАР ГЭМТ ХЭРЭГ ӨСЧ, МӨН БУУРЧ БАЙНА ВЭ? ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ

2.1. Тодорхой зарим гэмт хэргийн хувьд:

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 43.8% Өмчлөх эрхийн эсрэг, 32.1% Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг 91-107, 8.4% ТХХАБАЖ-ын эсрэг 215-225, 7.4% Нийгмийн аюулгүй байдлын эсрэг 177-191, 1.6% Хүүхэд, гэр бул, нийгмийн ёс суртахууны эсрэг 114-129, 1.2% Хүн амын эрүүл мэндийн эсрэг 192-201, Аж ахуйн

эсрэг 156-176 0.9% байна.

Тодорхой төрлийн гэмт хэргүүд дээр 2013 онд 2012 оноос өсөлт, бууралт ажиглагдаж байна. Тухайлбал **ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ 145-155 23.2%-иар, АЖ АХУЙН ЭСРЭГ 156-176 26.5%-иар, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, АЛДАР ХҮНД, НЭР ТӨРИЙН ЭСРЭГ 108-113 19.6%-иар ӨССӨН бол ЗАХИРГААНЫ ЖУРМЫН ЭСРЭГ 230-244 -16.3%-иар, АЛБАН ТУШААЛЫН 263-273 -3.6%-иар БУУРСАН байна.**

Гэвч зарим нэг гэмт хэргийн онцлогоос хамаарч хохирогчид өөрсдөө нуун дарагдуулах цөөнгүй байдаг. Жишээлбэл эмэгтэйчүүд хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон ч цагаагийн байгууллагад гомдол гаргалгүй нуун дарагдуулж явдал байгаа эсэхийг анхаарах шаардлагатай.

Улсын хэмжээнд ББМБГУ /96-100/ болон Хулгайлах /145/ хэргүүд хамгийн өндөр гаралттай байна.

2.2. 2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 36.8% Б.Э, 25.1% ял, 2013 онд 43% Б.Э, 20.7% ялласан байна. Бүртгэгдэх үедээ эзэнтэй байсан хэрэг 34%-иар өссөн. Гэсэн хэдий ч ялласан байдал 2012 оноос 4.4%-иар буурсан мөн гэмт хэргийн гаралт 2012 оноос 14.8%-иар өссөнтэй харьцуулахад гэмт хэргийн илрүүлэлт муу байна.

Гэмт хэрэгтний барьж чаддаггүй, илрүүлэлт бага байдаг нь гэмт хэргийн өсөлтөд шууд нөлөөлөгч хүчин зүйл юм. Гэмт хэрэг үйлдэгчийг барьж, таслан зогсоож чадаагүйн улмаас хэрэг дахин үйлдэгдэх, гэмт хэргийн гаралт өсөх суурь нөхцөл болж байна.

Хэргийн илрүүлэлт буурсан шалтгаан нь зарим цагдаагийн хэлтэс, хэсгүүдэд мөрдөн байцаач, хэсгийн төлөөлөгчид ачаалал ихтэй

ажилладаг, мөн автомашины цонх толь хагалах, халаасны хулгай зэрэг хэрэг бүртгэгдэх үедээ хэргийн эзэн холбогдогч нь тодорхойгүй хэргүүд олноор бүртгэгддэгтэй холбоотой.

Гомдол, мэдээлэл өссөн ч гэмт хэргийн илрүүлэлт буурах хандлагатай байгаа нь анхаарах асуудал юм. Үүнийг нийгмийн сэтгэлгээ өөрчлөгдж буйтай холбон тайлбарлаж болох юм. Иргэд ямар нэгэнбайдлаарх оирсонтхиолдолд цагдаад мэдэгдэх, гомдол гаргаж бүртгүүлж байх шаардлагатайг ухамсарлаж эхэлсэн нь үүнээс харгадж байна. Энэ нь эргээд хэрэг шийдвэрлэлтэд ач холбогдолтой байдаг байна. Өргөдөл гомдол бүрийг бүртгэж (broken windows) байснаар дараа нь хэрэг гарахад өмнө нь ямар гомдол гаргаж хэдэн удаа хандсан, гэмт хэргийг давтан үйлдсэн эсэх талаар мэдээлэл харах боломжийг бүрдүүлж өгдөг байна.

3. ЗАРИМ ТӨРЛИЙН ХЭРГҮҮД

Гэмт хэрэг гаралтад байршил ихээр нөлөөлж байна. 2013 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн дийлэнх нь буюу 57% гэр орон сууц, олон нийтийн газар болон бусад газарт үйлдэгдсэн бол тус оны хагас жилд бүртгэгдсэн гэмт хэргийн 65% нь гэр орон сууц, олон нийтийн газар, гудамж талбайд үйлдэгдсэнээс харж болно. Олон нийтийн газар, гудамж талбайд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд цагдаагийн хяналтыг тогтмолжуулснаар гэмт хэрэг гаралтыг бууруулах боломжтой юм.

Архидалт-ажилгүйдэл-ядуурал нь гэмт хэрэг гарах суурь шалтгаан нөхцөл болж байна. Нийслэлд баар, шенийн клубууд олноор байрладаг нь гэмт хэргийн гаралтад нөлөөлж байна.

Энэ нь согтуугаар болон бүлэглэн үйлдэх гэмт хэргийн тоо

өссөнтэй шууд хамааралтай. 2013 онд согтуугаар үйлдэгдсэн хэрэг 6406 болж өмнөх оны мөн үеэс 26.5%-иар өссөн бол бүлэглэн үйлдсэн хэрэг 2447 болж өмнөх оноос 0,8%-иар тус тус өссөн байна.

Дэлхийн банк, Монгол улсын үндэсний статистикийн хорооноос хамтран гаргасан Монгол Улсын ядуурлын түвшин 2012 оны 4 дүгээр сарын мэдээгээр 29,8%-тай байгаа нь нэлзээд өндөр түвшин юм.¹

Өөрөөр хэлбэл 3 хүн тутмын нэг нь өдөр тутмын зайлшгүй хэрэгцээтэй ахуйн хэрэглээний зүйлсээр дутагдаж байгаа нь хулгай хийх, залилан мэхлэх зэрэг амар хялбар аргаар мөнгө олох сонирхол, сэдлийг бий болгож байна.

Мөн ажилгүйдлийн түвшин Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр 2013 оны 1-р улиралд 9.3%-тай байна.

Ажилгүйдлийнхувьөндөрбайгаа нь гэмт хэргийн гаралтад нөлөөлдөг нь 2013 онд гэмт хэрэг үйлдэгсдийн 51% нь ажилгүй гэж бүртгэгдсэнээс харагдаж байна. Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тухайд 40 хүртэлх насны хүмүүс 69.7%-ийг эзэлж, тодорхой эрхэлсэн ажилгүй, бүрэн дундаас доогуур боловсролтой, ажиллах идэвхтэй насны хүмүүс гэмт хэрэгт холбогдож байгаа нь анхаарах асуудал юм.

¹ Монгол улсын ядуурлын өнөөгийн дүр төрх, Б. Эрдэнэсүрэн, Үндэсний статистикийн хороо, УБ., 2012 оны 12 дугаар сар.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



МУИС-Хууль зүйн сургуулийн
магистрант Б.Мэргэн

Нэг. Оршил

Америкийн эдийн засагт 19 дүгээр зууны эцэст хүчтэй, шинэ аж ахуйн нэгжийн хэлбэр болох “трест”-үүд гарч ирж, өөрсдийн давамгай байдлаа ашиглан эдийн засгийн гэл, чухал салбаруудад ноёрхлоо тогтоож, хэрэглэгчдийн эрх ашигт харш үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь төрийн зүгээс зах зээлийн өрсөлдөөнийг хянан зохицуулах, монопольт үйл ажиллагааг хязгаарлах бодлого явуулахад хүргэнсээр¹ шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай анхны цэгцтэй ойлголтууд бий болсон. Харин дэлхийн II дугаар дайн 1945 онд дууссаны дараагаар Өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт олон улс оронд хурдаатай хөгжиж

¹ Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар 2005-2007 /тайлан, судалгаа, хяналт шалгалт/ УБ., 2007. 4 дэх тал.

эхэлсэн юм.² Тухайлбал, Их Британи 1973 онд “Fair Trading Act” гэх шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулиа баталжээ.³

Монгол улсын хувьд 1993 онд Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль /цаашид “ШБӨХТХ” гэх/ баталж, 2000 онд шинэчлэн найруулсан. Уг хуулиар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд зах зээлд өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэн, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хориглож, урьдчилан сэргийлэх эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тавьж өгсөн гэх боловч энэ нь бодит байдалд нийцэхгүй байсан нь судалгаанаас харагддаг. Тухайлбал, “Дэлхийн эдийн засгийн эрх чөлөө 2007” тайландурдсанаар Монгол улс эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтээрээ 78 дугаар байранд орсон бөгөөд энэ нь хил дамжин худалдаа хийх боломж, татвар төлөлт, өрсөлдөөний эрх зүйн орчин болон бусад зүйлсийг

² Дамшилэв. ЦэнгэлЧ. Монгол Улсын өрсөлдөөний хууль тогтоомжийг сайжруулах зарим асуудал. Cambridge University Press - Antitrust and Global Capitalism in America, Japan, Europe, and Australia, 1930–2004 - by Tony A. Freyer

³ АНУ-д Antitrust law (Sherman Act, 1890, Clayton Act, 1914, Federal Trade Commission Act, 1914); Их Британид Restrictive Trade Practice 1976, Fair Trading Act, 1973, Resale Price Act, 1978 Competition Act 1980; ХБНГУ-д Gesetz gegen der Wettbewerbsbeschränkungen, Kartellrecht; БНСУ-д Monopoly Regulation and Fair Trade Act, 1981; Японд Prohibition of Monopoly and Maintenance of Fair Trade Act, 1947; Монгол улсад Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, мөн үүнд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг хамруулж болох юм.

өрсөлддөг. БНСУ-ын LG болон Samsung хоёр компани гэр ахуйн бараа үйлдвэрлэлээр эх орондоо маш хүчтэй өрсөлддөг байсны үр дүнд эдгээр компаниудын гол гол бараа бүтээгдэхүүн өнөөдөр дэлхийн хэмжээнд өрсөлдөж байна.

2. Эдийн засгийн онолын үүднээс эдийн засгийн нөөц нь төгс өрсөлдөөний үед бараа үйлчилгээ болон тэнцвэртэй хуваарилагдаг гэж үздэг.¹¹ Ингэснээр барааны үнэ буурч, чанар сайжирдаг учраас хэрэглэгчдэд таатай нөлөө үзүүлнэ. Жишээ нь, Австрали улс 2000 оноос өрсөлдөөний хуулийг эдийн засгийн үндсэн хууль болгон хэрэгжүүлснээр 2006 онд айл өрх бүрт ногдох орлого 7000 австрали долларт хүрсэн байна.

3. Шударга, чөлөөт өрсөлдөөний орчин бүрэлдэн тогтосоор эдийн засгийн тогтвортой өсөлтөд сайн нөлөө үзүүлдэг. Францын нийслэл Парис хотноо байрладаг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан судалгаагаар өрсөлдөөнийг хэрэгжүүлээгүй оронтой харьцуулахад түүнийг хэрэгжүүлсэн орны нэг хүнд ногдох орлогын өсөлт 1-2 хувиар дээгүүр байдаг гэсэн судалгааны дүн гарчээ. Тухайлбал, БНСУ 1981 онд “Шударга худалдааны хууль”-ийг баталсан бөгөөд түүнээс өмнө эдийн засаг нь бууралттай байсан бол хуулийг хэрэгжүүлснээс хойших 10 жилд эдийн засаг нь жилд дунджаар 8 орчим хувийн өсөлттэй болсон байна.¹²

¹¹ Lypsey and Chrystal, Principles of Economics, Oxford University Press, 1999, p 139

¹² Жаргалтайхан Б. Монгол улсын зах зээлийн өрсөлдөөний өнөөгийн байдал, цаашдын чиг

Дээр дурдсан зэрэг нөхцөл байдлууд нь мэдээж шударга, чөлөөт өрсөлдөөний үед бий болох бөгөөд харин монополь болоод шударга бус өрсөлдөөний бусад үед дээрх турван үзүүлэлт эсрэгээр эргэж, үйлдвэрлэгч нь үнийг тодорхойлж, нэмэх ингэснээрээ хэрэглэгчдэд таагүй нөхцөлийг бий болгож улмаар улс орны эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг.

Гурав. Зарим улс орнуудын өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт

Улс орнуудын өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт нь тухайн улсын эдийн засаг, улс төрийн онцлог, орон зай, цаг хугацааны байдал зэрэг олон хүчин зүйлээс хамааран харилцан адилгүй байдаг. Хэдий тийм боловч ихэнх улсын өрсөлдөөний төрөлжсөн хууль дараах нийтлэг зорилгыг хангахад чиглэгддэг. Үүнд:¹³

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах. Ингэхдээ өрсөлдөөнд өөрт нь нөлөөлөх бус үнийг тогтоогч компаниудыг үнээ буулгахыг шаардсанаар хэрэглэгчийн эрхийг хамгаалдаг. Өрсөлдөөний тухай хууль нь шууд болоод шууд бус аргаар хэрэглэгчийг хамгаалах зорилготой байдаг.¹⁴

2. Эрх мэдлийн төвлөрлийг сааруулах. Энэ нь нэг гарч хэт их эдийн засгийн эрх мэдлийг төвлөрөхөөс сэргийлж, эдийн засгийн нөөцийг аль болох тэгш хуваарилах үүрэг юм. АНУ-ын

хандлага. “Өрсөлдөөн ба хөгжил” хэлэлцүүлэг. УБ., 2007. 8-9 дэх тал.

¹³ Алтангэрэл Т. Өрсөлдөөний эрх зүйн онолын үндэслэл. www.asuult.net.

¹⁴ Монгол Улсын Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль §6.1.7, §6.1.9. www.legalinfo.mn УБ., 2000.

заалтыг зөрчин, бусдад хохирол учруулсан зах зээлд оролцогч нь хохирлыг барагдуулан нөхөн төлбөр өгөх хариуцлага хүлээнэ. Хохирсон этгээдийн хохирлын тооцоолоход хэцүү үед хохирлын нийт хэмжээ нь тухайн зөрчилтэй үйл ажиллагааны үед зөрчлийн хугацааны туршид олсон ашиг орлого байх болно. Хууль ёсны эрх ашиг сонирхлыг нь зөрчсөн шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаанд тооцогдох зөрчил гаргасан этгээд нь хохирсон этгээдийн улирлын бүх зардлыг төлнө." гэж заасан байдаг. Мөн энэхүү хуулиар Зах зээлд оролцогч этгээд бусдын бүртгэлтэй барааны тэмдгийг хуурамчаар хийх, зөвшөөрөлгүйгээр хэн нэгний бизнесийн нэр болон хувийн нэрийг хэрэглэх, алдартай болон сайн чанарын бараа бүтээгдэхүүний таних тэмдэг, гэрчилгээ зэрэг чанарын тэмдгийг буруугаар ашиглах, дууриалган хийх, бараа бүтээгдэхүүний үүсэл гарлыг гүйвуулах, бичиг баримтыг хуурамчаар хийх, бараа бүтээгдэхүүний чанарыг төөрөгдүүлэн буруу мэдээлэл тараах зэрэг хууль бус үйлдэл хийсэн тохиолдолд БНХАУ-ын Бүтээгдэхүүний чанарын тухай хууль болон Барааны тэмдэгтийн тухай хуулийн заалтын дагуу шийтгэл хүлээлгэхээр заасан байна.

Тайвань улс. Тайвань улсын Шударга худалдааны хууль нь өрсөлдөөнд харш гэрээ хэлцэл, нэгдэн нийлэх явдал, монополь байдал, давамгай байдал, зүй ёсны монополь, эдийн засгийн төвлөрөл, хэт үнэ, үгсэн хуйвалдах, босоо хамтын ажиллагаа, босоо үнэ

тогтоох гэх мэт нийтлэг асуудлууд бүгдийг зохицуулжээ. Ингэхдээ ойлголт бүрийн тодорхойлолтыг нарийвчлан оруулж өгсөн ба тухайлбал, "тухайн зах зээлийн тодорхой хувийг дангаараа эзэмшиж үйл ажиллагаагаа явуулж байвал монополь гэнэ" гэхээсээ илүүтэйгээр яг ямар нөхцөлд монополь болох вэ, ямар нөхцөлд монополь гэж үзэхгүй вэ гэдгийг тодорхой зааж өгсөн байна. Жишээ нь, Тайваны Шударга худалдааны хуулинд "хэрвээ тухайн компанийн дангаараа зах зээлд эзлэх хувь нь 50%-с дээшгүй бол, хэрвээ тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй тэргүүлэх хоёр компанийн эзлэх хувь нийлээд 67%-с дээшгүй бол, хэрвээ гурван тэргүүлэгч компанийн зах зээлд эзлэх хувь 75%-с дээшгүй бол монополь гэж үзэхгүй" хэмээн заасан байна.

Тус улсын хувьд анх 1986 онд өрсөлдөөний хуулийн төслийг боловсруулсан ба удаан хугацааны хэлэлцүүлгийн үр дүнд 1991 онд Шударга худалдааны хууль нэртэйгээр батлагджээ. Уг хууль нь 1991 оны 2 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан бөгөөд нэг жилийн дараа хэрэгжиж эхэлсэн. Шударга худалдааны хууль нь худалдааны журмыг мөрдүүлэх, хэрэглэгчдийн эрх ашигийг хамгаалах, шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн тогтвортой байдал, түүний хэтийн тэлөвийг дэмжих зорилготой юм. Тайваны Шударга худалдааны хороо / FTC/ нь 1992 оны 1 дүгээр сарын 27-нд байгуулагдсан. Бодлого зохицуулалт, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг байгууллага болох Шударга худалдааны хороо нь орон тооны 9 гишүүнээс бүрддэг ба тэдгээрийг Ерөнхий сайдын санал

болгосноор Ерөнхийлөгч гурван жилийн хугацаатай томилдог байна. Тайваны Шударга худалдааны хороо нь бодлого болон хуулийн хэрэгжилтийг хариуцдаг Засгийн газрын харьяа Яамны түвшинд үйл ажиллагаа явуулдаг агентлаг юм.

Тайваны Шударга Худалдааны хуулийн 46 дугаар зүйлд 1999 онд орсон өөрчлөлтөөр “Аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнд хамааралтай үйл ажиллагааг зохицуулсан бусад хуулийн зохицуулалттай зөрчилдэж байвал энэ хууль нь давуу эрхтэй үйлчилнэ” гэж заасан байдаг бөгөөд хуульд энэхүү өөрчлөлт орсноор Шударга Худалдааны Хорооны эрх мэдэл, бие даасан байдлыг улам бэхжүүлсэн байна.

Оросын Холбооны Улс. ОХУ-ын Монополийн эсрэг алба нь ОХУ-ын Засгийн газрын 2008 оны 8-р сарын 19-ний тогтоолын дагуу Монополийн эсрэг хоёр дахь багц хуулийн төслийг боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлж дэмжлэг авсан байна. ОХУ-ын Монополийн эсрэг албаны дэргэд зах зээл бүрийг хариуцсан Шинжээчдийн зөвлөл ажилладаг. Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах Шинжээчдийн зөвлөл нь холбогдох хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж, асуудалд дүн шинжилгээхийж, ОХУ-ын Монополийн эсрэг албанд санал зөвлөмж өгөх үүрэгтэй. Монополийн эсрэг алба нь эдийн засгийн төвлөрөл, картелийн асуудал, компаниудын нэгдэн нийлэх процесс болон шударга бус өрсөлдөөний эсрэг бодлого боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах үүрэгтэй алба юм.

Тус улсын Өрсөлдөөнийг хамгаалах тухай холбооны хууль нь 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр 9 бүлэг, 52 зүйлтэйгээр батлагдсан.

Уг хууль нь дараах хэд хэдэн онцлогтой.

1. Нэр томъёоны хувьд нэлээд задлан тодорхойлжэгсэн. Жишээн: Хуулийн 4 дүгээр зүйлд “харилцан орлох бүтээгдэхүүн”, “ялгаварлан үзэх нэхцэл”, “санхүүгийн үйлчилгээний үндэслэлгүй хэт өндөр болон бага үнэ”, “өрсөлдөөнийт хязгаарлах шинж тэмдэг”, “босоо тохиролцоо”, “эдийн засгийн үйл ажиллагааны зохицуулалт”, “төрийн болон нутгийн захиргааны тусламж” зэрэг нэр томъёог нарийвчлан тодорхойлж өгсэн.

2. Төрийн байгууллага болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд 19-р зүйлд заасан зорилгоор тусламж үзүүлэхдээ Монополийн эсрэг байгууллагаас заавал зөвшөөрөл авах талаар заасан байдаг. Харин хуулийн 20-р зүйлд ОХУ-ын Монополийн эсрэг байгууллагаас урьдчилан зөвшөөрөл заавал авахгүйгээр улсын болон нутгийн захиргааны байгууллагаас тусламж үзүүлэх тохиолдлыг заасан байна.

3. ОХУ-ын Монополийн эсрэг байгууллагын үүрэг, бүрэн эрхийн талаар нарийвчлан зааснаас гадна иргэдээс Монополийн эсрэг байгууллагад мэдээлэл өгөх, монополийн эсрэг байгууллага хууль тогтоомж зөрчсөн эсэх талаар хэрэг үүсгэх процессыг нарийвчлан заасан.

4. Арилжааны байгууллагууд үүсэн байгуулагдах, нэгдэх, нийлэх тохиолдолд заавал Монополийн эсрэг байгууллагаас зөвшөөрөл авах талаар хуульчилсан.

5. Давамгай байдалтай аж ахуйн нэгжийн талаарх ойлголтыг маш нарийвчлан зохицуулсан. Жишээлбэл, дараах нэхцэлдажахуй эрхлэгч (санхүүгийн байгууллагаас

бусад)-ийг давамгай байдалтай гэж үзнэ:

- Хэрэв гурван аж ахуй эрхлэгч (тус бүрийнх нь эзлэх хувь тухайн зах зээл дэх бусад аж ахуй эрхлэгчээс илүү)-ийн нийт хувь зах зээлийн тавин хувиас дээш, эсвэл таван аж ахуй эрхлэгч (тус бүрийнх нь эзлэх хувь тухайн зах зээл дэх бусад аж ахуй эрхлэгчээс илүү)-ийн нийт хувь зах зээлийн далан хувиас дээш байвал (хэрэв эдгээр субъектүүдийн аль нэгнийх нь эзлэх хувь найман хувиас бага байвал энэхүү зүйл үйлчлэхгүй);

- Урт хугацааны туршид (нэг жилээс багагүй хугацаанд эсвэл тухайн барааны зах зээл үргэлжилсэн хугацаанаас жилорчим хугацаанд) аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь өөрчлөгдөөгүй, эсвэл өөрчлөлтөнд бага өртсөн, мөн тухайн зах зээлд шинэ өрсөлдөгч ороход бэрхшээлтэй бол;

- Аж ахуй эрхлэгчийн борлуулж эсвэл худалдан авч буй барааг өөр бараагаар орлуулах боломжгүй, (ялангуяа үйлдвэрлэлийн зорилгоор хэрэглэж байгаа үед), үнийн өсөлт, эрэлт буурахаас үл хамаарах, тухайн зах зээл дээрх барааны үнэ, худалдах, худалдан авах нөхцөлийн талаарх мэдээллийг тодорхой булэг этгээд л мэдэж болох нөхцөл байдалтай бол;

- Аж ахуй эрхлэгч өөрийг нь барааны зах зээлд давамгай байдалгүй болохыг батлах нотолгоог монополийн эсрэг байгууллага болон шүүхэд гаргах эрхтэй;

- Аж ахуй эрхлэгч барааны зах зээлд ердийн монополийн байр суурь эзэлж байгаа бол түүнийг давамгай байдалтай гэж үзнэ;

- Хэрэв аж ахуй эрхлэгч тодорхой барааны зах зээлд гучин таваас багагүй хувь эзэлдэг бол түүнийг Холбооны хуулиар давамгай

байдалтай гэж тогтоож болно;

- Энэхүү хуульд заасан хязгаарлалтыг тооцсоны үндсэн дээр Засгийн газар санхүүгийн байгууллага (зээлийн байгууллагаас бусад)-ыг давамгай суурьтай гэж үзнэ;

- Засгийн газар энэхүү хуульд заасан хязгаарлалтыг тооцсоны дараа Төв банктай зөвшилцсөний үндсэн дээр зээлийн байгууллагыг давамгай байр суурьтай гэж үзнэ;

- Санхүүгийн байгууллага (зээлийн байгууллагаас бусад)-ын давамгай байдлыг Засгийн газрын баталсан журмын дагуу Монополийн эсрэг байгууллага тогтооно;

- Зээлийн байгууллагын давамгай байдлыг тогтоох журмыг Засгийн газар Төв банктай зөвшилцсөний үндсэн дээр батална. Хэрэв зах зээлд эзлэх хувь нь арван хувиас дээшгүй, хэд хэдэн зах зээлд эзлэх хувь нь хорин хувиас дээшгүй бол тухайн санхүүгийн байгууллагыг давамгай байдалтай гэж үзэхгүй.

